



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
СТРАТЕГИ, БОДЛОГО, ИННОВАЦ, ХӨГЖЛИЙН АЛБА

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2024 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаанбаатар хот
2025 он



Бэлтгэсэн: Статистикийн сангийн эрхлэгч, цагдаагийн хошууч С.Энхбаатар
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Э.Батгэрэл
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Уянга
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Хулангоо
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Т.Дэлгэрсайхан
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Балжин
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Тамир
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад М.Ганзул
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Мөнхтөр
Цахим зураглал, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн,
цагдаагийн ахлах дэслэгч О.Чинбат

Хянасан: Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга,
Бригадын генерал О.Ганбат
Статистик, мэдээллийн хэлтсийн дарга,
цагдаагийн хурандаа Д.Жанчивдорж

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хуулбарлах, хэвлэн олшруулахыг хориглоно.



ГАРЧИГ

ГАРЧИГ	4
НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	5
ХОЁР. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	14
ГУРАВ. ОРОН НУТАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	88
ДӨРӨВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	245
4.1 Хүнийг алах гэмт хэрэг	245
4.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	249
4.3 Хүчиндэх гэмт хэрэг	254
4.4 Хулгайлах гэмт хэрэг	259
4.5 Хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг	263
4.6 Халаасны хулгайн гэмт хэрэг	267
4.7 Дээрэмдэх гэмт хэрэг	271
4.8 Залилах гэмт хэрэг	275
4.9 Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг	280
4.10 Мал хулгайлах гэмт хэрэг	285
4.11 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг	289
4.12 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	292
4.13 Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг	296
ТАВ. ГЭМТ ХЭРГИЙН ОНЦЛОГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ	300
5.1 Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг	300
5.2 Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг	305
5.3 Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг	310
5.4 Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	314
5.5 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил	318
ЗУРГАА. ГЭМТ ХЭРГИЙН НЯГТАРШИЛ	327
6.1 Нийслэлийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн нягтаршил	327
6.2 Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нягтаршил	328
6.3 Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн нягтаршил	329
6.4 Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн нягтаршил	330
6.5 Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн залилах гэмт хэргийн нягтаршил	331
6.6 Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн нягтаршил	332
6.7 Орон нутгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн нягтаршил	333
6.8 Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нягтаршил	334
6.9 Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн нягтаршил	335
6.10 Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн нягтаршил	336
6.11 Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн залилах гэмт хэргийн нягтаршил	337
6.12 Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн малын хулгай гэмт хэргийн нягтаршил	338
6.13 Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн нягтаршил	339



Нэг. УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Цагдаагийн байгууллага нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс **323.607** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 122.086 буюу 37.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 201.521 буюу 62.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.


Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 14.547 буюу 4.7 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 14.925 буюу 13.9 хувиар тус тус өссөн бол зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 378 буюу 0.2 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 32.101 буюу 27.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 82.776 буюу 71.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1443 буюу 1.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 124.255 буюу 62.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 72.701 буюу 36.6 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 1933 буюу 0.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт **44.673** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 9099 буюу 25.6 хувиар өссөн нь сүүлийн 10 жилийн дунджаар авч үзвэл 5.4 хувийн өсөлттэй байна.


1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (орон нутаг).



1.2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг (нийслэл).



1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.


Нийт бүртгэгдсэн хэргийн 38953 буюу 87.2 хувь нь хөнгөн, 5720 буюу 12.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 23.3, хүнд хэрэг 43.5 хувиар тус тус өссөн байна.



1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	573	852	48.7	1.9
	Үүнээс: Хүнийг алах	199	191	-4.0	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8531	8935	4.7	20.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	126	123	-2.4	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	728	847	16.3	1.9
	Үүнээс: Хүчиндэх	564	658	16.7	1.5
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	357	586	64.1	1.3
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	42	42.0 дах	0.1
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	39	48	23.1	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	68	66	-2.9	0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	21686	27971	29.0	62.6
8	Үүнээс: Хулгайлах	5401	7626	41.2	17.1
	Дээрэмдэх	392	568	44.9	1.3
	Залилах	12985	15889	22.4	35.6
	Малын хулгай	643	508	-21.0	1.1
9	Эдийн засгийн гэмт хэрэг	200	336	68.0	0.8
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	686	378	-44.9	0.8
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	125	166	32.8	0.4
13	Авлигын гэмт хэрэг	13	17	30.8	0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	400	321	-19.8	0.7
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	472	489	3.6	1.1
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	12	24	2.0 дах	0.1
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	388	406	4.6	0.9
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1280	3167	2.5 дах	7.1
18	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1279	3158	2.5 дах	7.1
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	13	21	61.5	0.1
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-

1.6. Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл.




Гэмт хэргийн бүтцээр авч үзвэл, нийт гэмт хэргийн 62.6 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 20.0 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус тус эзлэх бөгөөд сүүлийн 10 жилд дээрх 2 төрлийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 80.0-85.0 хувийг тогтвортой эзэлж байна.



1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 6937 буюу 15.5 хувь нь даваа гарагт, 6879 буюу 15.4 хувь нь мягмар гарагт, 6946 буюу 15.6 хувь нь лхагва гарагт, 6575 буюу 14.7 хувь нь пүрэв гарагт, 6206 буюу 13.9 хувь нь баасан гарагт, 5633 буюу 12.6 хувь нь бямба гарагт, 5497 буюу 12.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 16.112 буюу 36.1 хувь нь 06:00-14:00 цагт, 12.864 буюу 28.8 хувь нь 14:00-19:00 цагт, 5363 буюу 12.0 хувь нь 19:00-22:00 цагт, 10334 буюу 23.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 13.616 буюу 30.5 хувь нь гэр орон сууцанд, 9119 буюу 20.4 хувь нь гудамж талбайд, 4588 буюу 10.3 хувь нь олон нийтийн газарт, 276 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 380 буюу 0.9 хувь нь төрийн байгууллагад, 245 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 3652 буюу 8.2 хувь нь аж ахуйн нэгжид, 2842 буюу 6.4 хувь нь авто замд, 9955 буюу 22.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 6862 буюу 15.4 хувь нь согтуугаар, 6191 буюу 13.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 2067 буюу 4.6 хувь нь бүлэглэн, 1373 буюу 3.1 хувь нь хүүхэд оролцож, 1559 буюу 3.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 13061 буюу 29.2 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.






1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 81.635 хэрэгт хэрэг бүртгэлт, 6010 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 87.645 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 24.660 урьд оны үлдэгдэл хэрэг, 58.144 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 117, урьд оны хэрэгсэхгүй, хэрэг бүртгэлтийн хэрэг хааснаас сэргээсэн 4.724 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 49.083 буюу 56.0 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 21.939 буюу 44.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 19.080 буюу 38.9 хувийг шүүхэд шилжүүлж;
- 335 буюу 0.7 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 7078 буюу 14.4 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 651 буюу 1.3 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 56.0 хувь, хуулийн анхны хугацаанд 93.6 хувийг шийдвэрлэж, 2119 хүн, 1 хуулийн этгээдэд холбогдох 39.980 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Улсын хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 47.0 хувь, нийслэлд 42.1 хувь, орон нутагт 62.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 10.1 нэгжээр, нийслэлд 13.5 нэгжээр тус тус буурч, орон нутагт 0.9 нэгжээр өссөн байна.

Сүүлийн 20 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь





2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 40316 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 8842 хэрэг буюу 28.1 хувиар, үүнээс 18941 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 965 буюу 5.4 хувиар тус тус өссөн.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 25.291 хүн гэмт хэрэгт холбогдон яллагдагчаар татагдсан нь өмнөх онтой харьцуулахад 1157 буюу 4.8 хувиар өссөн.

Яллагдагчдын 5468 буюу 21.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 447 буюу 8.9 хувиар, 1675 буюу 6.6 хувийг 0-17 насны хүүхэд эзэлж байгаа нь 81 буюу 5.1 хувиар тус тус өссөн байна.


3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 42912 иргэн, 122 хуулийн этгээд хохирч, үүнээс 991 хүн нас барж, 10603 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал нийт хохирогч 7620 буюу 21.6 хувиар, хуулийн этгээд 16 буюу 15.1 хувиар, гэмтсэн хүн 922 буюу 9.5 хувиар, нас барсан хүн 143 буюу 16.9 хувиар тус тус өссөн байна.





4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 697.0 тэрбум төгрөгийн хохирлын 306.2 тэрбум төгрөг буюу 43.9 хувийг нөхөн төлүүлж, 5011.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 247922.2 сая төгрөг буюу 55.2 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 94721.8 сая төгрөг буюу 44.8 хувиар өсөж, битүүмжилсэн хөрөнгө 1941.6 сая төгрөг буюу 27.9 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 3.379.414 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 165.000 буюу 5.1 хувиар, 3.370.393 зөрчлийг шийдвэрлэсэн нь 160.782 буюу 5.0 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 3098319 буюу 91.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 117589 буюу 3.5 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 12392 буюу 0.4 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2735 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 148379 буюу 4.3 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 3269583 иргэн, 64585 хуулийн этгээдийг 82.2 тэрбум төгрөгөөр торгох, 12181 хүнийг баривчлуулах, 20072 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 3889 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 178830 буюу 5.8 хувиар өсөж, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 13620 буюу 40.4 хувиар, баривчлуулсан шийтгэл 1435 буюу 10.5 хувиар тус тус буурсан байна.

2024 онд улсын хэмжээнд нийт 7.710 хүн эрүүлжүүлж, 37.354 хүнийг саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 6446 буюу 45.5 хувиар, саатуулсан хүн 705 буюу 1.9 хувиар тус тус буурсан байна.



Зургаа. Дүгнэлт.

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагаас 2024 онд хүлээн авсан гомдол, мэдээллийн тоо өнгөрсөн оноос 4.7 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 14.4 хувиар тус тус өсөж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 0.3 хувиар буурсан.

2024 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 71.9 хувь нь Улаанбаатар хотод, 28.1 хувь нь орон нутагт үйлдэгдсэн ба 87.2 хувь нь хөнгөн, 12.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байна. Өмнөх онтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 25.6 хувиар, хүнд гэмт хэрэг 43.5 хувиар тус тус өссөн. Гэмт хэрэг өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн эзлэх хувьтай холбоотой юм.

Бүртгэгдэж буй 10 хэрэг тутмын 2 нь хулгайлах, 4 нь залилах, 2 нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг байна. 2024 онд Хүнийг алах 4.0, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 2.4, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 2.9, Мал хулгайлах 21.0, Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 50.0, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 44.9, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 19.8 хувиар тус тус буурсан. Харин Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 42.0 дахин, Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 2 дахин, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2.5 дахин, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4.7, Хүчиндэх 16.7, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 64.1, Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 23.1, Хулгайлах 41.2, Дээрэмдэх 44.9, Залилах 22.4, Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг 68.0, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 32.8, Авлигын эсрэг гэмт хэрэг 30.8, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 3.6, Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4.6, Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 61.5 хувиар тус тус өссөн.

Нутаг дэвсгэрээр нь авч үзвэл нийслэлд гэмт хэрэг Налайх дүүрэгт 2.5 хувь, Багахангай дүүрэгт 15.8 хувь, орон нутагт Завхан аймагт 13.1 хувь буурч, бусад аймаг, дүүрэгт 2.7-52.1 хувь өссөн. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 19.5 хувь нь Баянзүрх, 13.4 хувь нь Баянгол, 11.4 хувь нь Хан-Уул, 10.0 хувь нь Сүхбаатар, 8.7 хувь нь Сонгинохайрхан, 7.5 хувь нь Чингэлтэй, үлдсэн хувь нь бусад аймаг дүүрэгт 0.04-2.2 хувийг тус тус эзэлж байна.

Мөн нийслэлийн дүүргүүдэд 10 000 хүн ам тутамд дунджаар 169 гэмт хэрэг ногдож буй бөгөөд дээрх үзүүлэлтээр Сүхбаатар дүүрэг 315, Чингэлтэй дүүрэг 247, Баянгол дүүрэг 236, орон нутагт Дорноговь 116, Өмнөговь 105, Говьсүмбэр 103 гэмт хэрэг ногдож буйгаараа хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Үүнээс үзэхэд гэмт хэргийн гаралтад хүн амын тоо, оршин суугчдын нягтрал шууд нөлөөлж байна.

Улсын хэмжээнд 2024 онд нийт 7710 хүн эрүүлжүүлэгдэж, 37354 хүн саатуулагдсаны 78.5 хувь нь Улаанбаатар хотод, 21.5 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Шинжлэх ухаан, технологийн их сургуулиас хийсэн системийн динамик судалгаагаар согтууруулах ундаа худалдах цэгийг 10 хувиар бууруулахад гэмт хэрэг 8 хувь, цагийн хязгаарлалтыг нэмэгдүүлэхэд 12 хувиар буурах тооцоолол гарсан нь гэмт хэрэг, архидалт хоёрын харилцан хамаарлыг тодорхой харуулж байна.

Гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн 62.3 хувь нь 18-34 насны залуус, 56.4 хувь нь ажилгүй, 18.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, өөрөөр хэлбэл 75.0 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс байгаа нь хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшин, ажлын байрны хүртээмж нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд хэрхэн нөлөөлж болохыг харуулж байна.

Нийслэлийн хэмжээнд бүртгэгдэж байгаа гэмт хэргийн гаралтад дүүргүүдийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, дэд бүтэц, хороодын тоо, өрх, хүн ам, төрөлт, нас баралт, шилжилт



хөдөлгөөн, аж үйлдвэр, боловсрол, оршин суугчдын амьдралын чанар, орлого, нийгмийн халамж, ажил эрхлэлт, эмнэлэг, нийгмийн үйлчилгээ, оршин суугчдын амьдралын хэв маяг нөлөөлж байна.

Боловсрол, эрүүл мэндийн чанар хүртээмж, зах зээлийн багтаамж, дэд бүтцийн хөгжлийг дагаад 21 аймгийн төв, Улаанбаатар хот, аялал жуулчлалтай холбоотойгоор Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Өвөрхангай аймгийн Хархорин сумын төв, Хэнтий аймгийн Биндэр сум, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Уул уурхайн хөгжилтэй холбоотой Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумын төв, хилийн боомт, чөлөөт бүстэй холбоотой Өмнөговь аймгийн Цагаанхад, Гашуун сухайт суурин, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төв, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төв, үйлдвэржилттэй холбоотойгоор Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Дорноговь аймгийн Алтанширээ сум, Улаанбаатар хотын дагуул Шинэ Зуунмод хот, газар тариалангийн хөгжилтэй холбоотойгоор Ховд аймгийн Булган, Сэлэнгэ аймгийн Мандал суманд хүн ам ихээр төвлөрөн суурьших хандлагатай байна.

Ялангуяа орон нутгийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд урт хугацаандаа нөлөөлөх хүчин зүйл нь ашигт малтмал дагасан шилжилт хөдөлгөөн, уул уурхайн ажиллах хүчний төвлөрөл юм.

Ахуйн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлыг судалж үзэхэд анхаарал, болгоомжгүй байдал, уур бухимдал, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх зэрэг шалтгаанууд зонхилж байна.

Иймд иргэдэд туслах, тайлбарлах, зөвлөх, шаардлага, мэдэгдэл хүргүүлэн баг, хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, хамтарсан баг, хэсгийн ахлагч, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, малчдын нөхөрлөл зэрэг байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг баримтлах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын гол чиглэл болох юм.

Ялангуяа хүний амь нас эрсдэх, архидан согтуурснаас гэр бүлийн гишүүд, найз нөхөд бие биеийнхээ амь насыг хохироох, амиа хорлох, бага насны хүүхдийг хүчиндэх, хайхрамж болгоомжгүйгээс золгүй байдлаар амь насаа алдах эрсдэл буурахгүй байна.

Нийт зөрчлийн 90 хувийг эзэлдэг замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Зам тээврийн осол болон түүнд ногдуулж буй торгох шийтгэлийн үр нөлөөг корреляцийн шинжилгээгээр судалж үзэхэд ирэх 10 жилд торгуулийн хэмжээ өсөхийн хирээр ослын тоо дагаад тогтмол өсөх хандлагатай байна. Системийн динамик судалгаагаар торгуулийг нэмээд зөрчил буурахгүй гэсэн тооцоолол гарсан.

Торгуулийн хэмжээг өсгөхөд зам тээврийн ослын тоо богино хугацаандаа буурах боловч урт хугацаандаа өсөх тул өөр төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болж байна. Нөгөө талаар торгох шийтгэлийн биелэлт хангалтгүй буюу сүүлийн 5 жилд бэлэн бус хэлбэрээр оногдуулсан торгуулийг 10-аас дээш удаа төлөөгүй 23503, 20-оос дээш 5999, 50-аас дээш 553, 100-аас дээш удаа 72 жолооч тус тус төлөөгүй судалгаа гарсан.

Иймд жолооч үүргээ биелүүлээгүй, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаагүй, осол, зөрчилд удаа дараа холбогдсон, оногдуулсан торгуулийг хугацаандаа төлөөгүй бол ангилал ахиулах, такси, нийтийн тээврийн хэрэгсэл жолоодох, хот хооронд тээвэр хийх, жолооны үнэмлэх авах эрхийг хязгаарлах зэргээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

---oooOooo---

Хоёр. НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн хэмжээнд 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 197.671 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 89.295 буюу 45.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 108.376 буюу 54.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 20.122 буюу 9.2 хувиар буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 10100 буюу 12.8 хувиар өсөж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 30.222 буюу 21.8 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 16847 буюу 19.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 67268 буюу 78.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1165 буюу 1.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 40194 буюу 37.6 хувийг зөрчлийн хэрэг нээж, 66479 буюу 62.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 235 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 32123 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 7145 буюу 28.6 хувиар өсөж, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 71.9 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (нийслэл).





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 29239 буюу 91.0 хувь нь хөнгөн, 2884 буюу 9.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 28.0, хүнд хэрэг 35.3 хувиар тус тус өссөн байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	379	631	66.5	2.0
	Үүнээс: Хүнийг алах	121	104	-14.0	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5207	5173	-0.7	16.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	59	34	-42.4	0.1
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	364	481	32.1	1.5
	Үүнээс: Хүчиндэх	287	365	27.2	1.1
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	275	444	61.5	1.4
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	-	13	-	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	24	39	62.5	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	47	55	17.0	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	16736	22718	35.7	70.7
8	Хулгайлах	3618	6041	67.0	18.8
	Дээрэмдэх	310	486	56.8	1.5
	Залилах	11220	13560	20.9	42.2
	Малын хулгай	38	23	-39.5	0.1
9	Эдийн засгийн гэмт хэрэг	142	255	79.6	0.8
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	483	293	-39.3	0.9
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	97	128	32.0	0.4
13	Авлигын гэмт хэрэг	2	9	4.5 дах	0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	201	191	-5.0	0.6
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	77	72	-6.5	0.2
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	7	16	2.3 дах	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	350	362	3.4	1.1



18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	581	1239	2.1 дах	3.9
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	581	1237	2.1 дах	3.9
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	4	3	-25.0	0.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 4955 буюу 15.4 хувь нь даваа гарагт, 4906 буюу 15.3 хувь нь мягмар гарагт, 5039 буюу 15.7 хувь нь лхагва гарагт, 4730 буюу 14.7 хувь нь пүрэв гарагт, 4521 буюу 14.1 хувь нь баасан гарагт, 4001 буюу 12.5 хувь нь бямба гарагт, 3971 буюу 12.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 12922 буюу 40.2 хувь нь 06:00-14:00 цагт, 9237 буюу 28.8 хувь нь 14:00-19:00 цагт, 3437 буюу 10.7 хувь нь 19:00-22:00 цагт, 6527 буюу 20.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	14	17	14	15	9	20	23	112
01:00	151	135	122	150	145	172	162	1037
02:00	130	157	176	155	142	142	142	1044
03:00	74	74	69	61	72	83	93	526
04:00	106	133	117	106	112	111	113	798
05:00	136	150	148	142	158	136	148	1018
06:00	49	30	38	39	27	39	37	259
07:00	149	150	164	153	125	121	143	1005
08:00	263	276	264	250	206	205	200	1664
09:00	85	61	76	85	57	52	69	485
10:00	446	461	451	426	405	351	352	2892
11:00	406	339	405	393	338	301	254	2436
12:00	140	132	148	128	120	99	89	856
13:00	594	494	538	489	488	335	387	3325
14:00	462	437	470	468	415	323	317	2892
15:00	173	185	168	176	184	130	145	1161
16:00	392	395	400	342	344	283	288	2444
17:00	317	359	372	343	287	256	261	2195
18:00	70	101	84	82	76	73	59	545
19:00	208	217	204	193	195	191	163	1371
20:00	260	240	260	221	237	216	192	1626
21:00	50	67	61	51	70	82	59	440
22:00	141	155	135	121	143	144	132	971
23:00	139	141	155	141	166	136	143	1021
Нийт	4955	4906	5039	4730	4521	4001	3971	32123

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 9948 буюу 31.0 хувь нь гэр орон сууцанд, 7490 буюу 23.3 хувь нь гудамж талбайд, 3669 буюу 11.4 хувь нь олон нийтийн газарт, 240 буюу 0.7 хувь нь нийтийн тээвэрт, 202 буюу 0.6 хувь нь төрийн байгууллагад, 176 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 3081 буюу 9.6 хувь нь аж ахуйн нэгжид, 1248 буюу 3.9 хувь нь авто замд, 6069 буюу 19.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.




1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 2492 буюу 7.8 хувь нь согтуугаар, 4722 буюу 14.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1414 буюу 4.4 хувь нь бүлэглэн, 971 буюу 3.0 хувь нь хүүхэд оролцож, 697 буюу 2.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 10960 буюу 34.1 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 56309 хэрэгт хэрэг бүртгэлт, 2247 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 58556 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 16964 урьд оны үлдэгдэл хэрэг, 37434 энэ оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 88, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 4070 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 29870 буюу 51.0 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 15262 буюу 51.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 8551 буюу 28.6 хувийг шүүхэд шилжүүлж,
- 214 буюу 0.7 хувийг хэрэгсэхгүй болгож,
- 5492 буюу 18.4 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
- 351 буюу 1.2 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 51.0 хувь, хуулийн анхны хугацаанд 95.0 хувийг шийдвэрлэж 1287 хүнд холбогдох 29718 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлд 42.1 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 13.5 нэгжээр буурч, улсын хэмжээний илрүүлтээс 4.9 нэгжээр бага байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 30700 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 7160 хэрэг буюу 30.4 хувиар өсөж, үүнээс 12930 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 163 буюу 1.2 хувиар буурсан.



Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 15474 хүн гэмт хэрэгт холбогдон яллагдагчаар татагдсан нь өмнөх онтой харьцуулахад 140 буюу 0.9 хувиар буурсан.

Яллагдагчдын 4166 буюу 26.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 175 буюу 4.4 хувиар өсөж, 1147 буюу 7.4 хувийг 0-17 насны хүүхэд эзэлж байгаа нь 237 буюу 26.0 хувиар өссөн байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 31297 иргэн, 76 хуулийн этгээд хохирч, үүнээс 527 хүн нас барж, 6037 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал нийт хохирогч 6671 буюу 27.1 хувиар, хуулийн этгээд 12 буюу 18.8 хувиар, гэмтсэн хүн 413 буюу 7.3 хувиар, нас барсан хүн 133 буюу 33.8 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 623.0 тэрбум төгрөгийн хохирлын 262.2 тэрбум төгрөг буюу 42.1 хувийг нөхөн төлүүлж, 2849.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 248.7 тэрбум төгрөг буюу 66.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 99.0 тэрбум төгрөг буюу 60.7 хувиар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 1539.9 сая төгрөг буюу 35.1 хувиар буурсан байна.


Тав. Зөрчил.

Нийслэлийн хэмжээнд нийт 2.534.424 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 185.611 буюу 7.9 хувиар, 2.527.688 зөрчлийг шийдвэрлэсэн нь 182.292 буюу 7.8 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 2.350.519 буюу 93.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 87.213 буюу 3.4 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 7396 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2448 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 80.112 буюу 3.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 2448956 иргэн, 64312 хуулийн этгээдийг 50.5 тэрбум төгрөгөөр торгох, 6527 хүнийг баривчлуулах, 6222 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 1641 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 195718 буюу 8.7 хувиар өсөж, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 11265 буюу 64.4 хувиар, баривчлуулсан шийтгэл 1739 буюу 21.0 хувиар тус тус буурсан байна.

2024 онд улсын хэмжээнд нийт 5014 хүн эрүүлжүүлж, 30343 хүнийг саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 4876 буюу 49.3 хувиар, саатуулсан хүн 424 буюу 1.4 хувиар тус тус буурсан байна.



Зургаа. Дүгнэлт.

Улаанбаатар хотын хэмжээнд цагдаагийн байгууллагаас 2024 онд хүлээн авсан гомдол, мэдээллийн тоо өнгөрсөн оноос 41.4 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 35.1 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 45.8 хувиар тус тус буурсан.

2024 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 71.9 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн байх бөгөөд 2013 оноос хойш цагдаагийн байгууллагын статистик мэдээгээр энэхүү үзүүлэлт тогтмол 60 хувиас буурахгүй байна.

Улаанбаатар хотод бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 28.6 хувиар өсөж, үйлдэгдэж буй гэмт хэргийн дунджаар 86.8 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд эзэлсэн байна.

Бүртгэгдэж буй 10 хэрэг тутмын 2 нь хулгайлах, 4 нь залилах, 2 нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг байна. 2024 онд Хүнийг алах 14.0, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 0.7, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 42.4, Мал хулгайлах 39.5, Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 50.0, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 39.3, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 5.0, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 6.5, Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 25.0 хувиар тус тус буурсан.

Харин Авлигын эсрэг гэмт хэрэг 3.5 дахин, Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 2.3 дахин, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2.1 дахин, Хүчиндэх 27.2, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 61.5, Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 62.5, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 17.0, Хулгайлах 18.8, Дээрэмдэх 1.5, Залилах 42.2, Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг 79.6, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 32.0, Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3.4 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 91.0 хувь нь хөнгөн, 9.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 21.9 хувиар, хүнд гэмт хэрэг 35.3 хувиар тус тус өссөн.



Гэмт хэрэг өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн өсөлттэй холбоотой юм.

Нутаг дэвсгэрээр нь авч үзвэл Налайх дүүрэгт гэмт хэрэг 3.8 хувиар буурч, бусад дүүрэгт 13.2-34.3 хувиар өссөн. Нийслэлд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 29.8 хувь нь Баянзүрх, 20.4 хувь нь Баянгол, 17.4 хувь нь Хан-Уул, 15.2 хувь нь Сүхбаатар, 13.3 хувь нь Сонгинохайрхан, 11.5 хувь нь Чингэлтэй, үлдсэн хувь нь бусад дүүрэгт бүртгэгджээ.

2024 оны байдлаар нийслэлийн дүүргүүдэд 10 000 хүн ам тутамд 185 гэмт хэрэг ногдож буй бөгөөд дээрх үзүүлэлтээр Сүхбаатар дүүрэг 315, Баянгол дүүрэг 236, Чингэлтэй дүүрэг 247 гэмт хэрэг ногдож буйгаараа хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Үүнээс үзэхэд нийслэлийн гэмт хэргийн гаралтад хүн амын тоо, оршин суугчдын нягтрал шууд нөлөөлж байна.

Улсын хэмжээнд 2024 онд нийт 7710 хүн эрүүлжүүлж, 37354 хүн саатуулагдсаны 78.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Шинжлэх ухаан, технологийн их сургуулиас хийсэн системийн динамик судалгаагаар согтууруулах ундаа худалдах цэгийг 10 хувиар бууруулахад гэмт хэрэг 8 хувь, цагийн хязгаарлалтыг нэмэгдүүлэхэд 12 хувиар буурах тооцоолол гарсан нь гэмт хэрэг, архидалт хоёрын харилцан хамаарлыг тодорхой харуулж байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 31.0 хувь нь гэр орон сууцанд, 23.3 хувь нь гудамж талбайд, 11.4 хувь нь олон нийтийн газарт, 0.7 хувь нь нийтийн тээвэрт, 0.6 хувь нь төрийн байгууллагад, 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 9.6 хувь нь аж ахуйн нэгжид, 3.9 хувь нь авто замд, 19.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн 53.5 хувь нь 18-29 насны залуус, 60.5 хувь нь ажилгүй, 20.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, өөрөөр хэлбэл 81.4 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс байгаа нь хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшин, ажлын байрны хүртээмж нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд хэрхэн нөлөөлж болохыг харуулж байна.

Нийслэлийн хэмжээнд бүртгэгдэж байгаа гэмт хэргийн гаралтад дүүргүүдийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, дэд бүтэц, хороодын тоо, өрх, хүн ам, төрөлт, нас баралт, шилжилт хөдөлгөөн, аж үйлдвэр, боловсрол, оршин суугчдын амьдралын чанар, орлого, нийгмийн халамж, ажил эрхлэлт, эмнэлэг, нийгмийн үйлчилгээ, оршин суугчдын амьдралын хэв маяг нөлөөлж байна.

Боловсрол, эрүүл мэндийн чанар хүртээмж, зах зээлийн багтаамж, дэд бүтцийн хөгжлийг дагаад Улаанбаатар хот, нийслэл хотын дагуул Шинэзуунмод хотод хүн ам ихээр төвлөрөн суурьших хандлагатай байна.

---0000000---

2.1. БАЯНГОЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Баянгол дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 29841 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 16124 буюу 54.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 13717 буюу 46.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 4427 буюу 12.9 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 6093 буюу 30.8 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1666 буюу 11.5 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2087 буюу 13.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 13172 буюу 85.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 163 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 5844 буюу 43.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 7672 буюу 56.6 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 27 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 5974 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1518 буюу 34.1 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 18.6 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүрэг).





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	238	326	88	37.0	18-р хороо	154	227	73.0	47.4
2-р хороо	306	570	264	86.3	19-р хороо	152	155	3.0	2.0
3-р хороо	217	327	110	50.7	20-р хороо	206	325	119.0	57.8
4-р хороо	253	182	-71	-28.1	21-р хороо	290	116	-174.0	-60.0
5-р хороо	171	281	110	64.3	22-р хороо	103	112	9.0	8.7
6-р хороо	184	225	41	22.3	23-р хороо	48	57	9.0	18.8
7-р хороо	163	136	-27	-16.6	24-р хороо	114	202	88.0	77.2
8-р хороо	168	192	24	14.3	25-р хороо	181	101	-80.0	-44.2
9-р хороо	113	213	100	88.5	26-р хороо	57	107	50.0	87.7
10-р хороо	74	150	76	2.0 дах	27-р хороо	25	60	35.0	2.4 дах
11-р хороо	119	202	83	69.7	28-р хороо	37	102	65.0	2.8 дах
12-р хороо	96	139	43	44.8	29-р хороо	140	335	195.0	2.4 дах
13-р хороо	136	214	78	57.4	30-р хороо	12	40	28.0	3.3 дах
14-р хороо	124	213	89	71.8	31-р хороо	49	64	15.0	30.6
15-р хороо	149	98	-51	-34.2	32-р хороо	25	79	54.0	3.2 дах
16-р хороо	159	189	30	18.9	33-р хороо	19	41	22.0	2.1 дах
17-р хороо	168	169	1	0.6	34-р хороо	6	25	19.0	4.2 дах

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 5617 буюу 94.0 хувь нь хөнгөн, 357 буюу 6.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 33.0, хүнд хэрэг 52.6 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	59	105	78.0	1.8
	Үүнээс: Хүнийг алах	25	20	-20.0	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	812	929	14.4	15.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1			0.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	55	70	27.3	1.2
	Үүнээс: Хүчиндэх	45	49	8.9	0.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	37	67	81.1	1.1
	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг		3		0.1
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	6	10	66.7	0.2



6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	8	10	25.0	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3186	4387	37.7	73.4
7	Үүнээс: Хулгайлах	567	1232	59.0	20.6
	Дээрэм	67	125	42.0	2.1
	Залилан	2251	2516	13.7	42.1
8	Эдийн засгийн гэмт хэрэг	20	39	95.0	0.7
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	73	45	-38.4	0.8
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	16	27	68.8	0.5
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	31	68	2.2 дах	1.1
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	7	1	-85.7	0.0
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	62	34	-45.2	0.6
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	84	179	2.1 дах	3.0
14	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	84	179	2.1 дах	3.0

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 885 буюу 14.8 хувь нь даваа гарагт, 933 буюу 15.6 хувь нь мягмар гарагт, 926 буюу 15.5 хувь нь лхагва гарагт, 907 буюу 15.2 хувь нь пүрэв гарагт, 845 буюу 14.1 хувь нь баасан гарагт, 733 буюу 12.3 хувь нь бямба гарагт, 745 буюу 12.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2601 буюу 43.5 хувь нь 06:00-14:00 цагт, 1605 буюу 26.9 хувь нь 14:00-19:00 цагт, 416 буюу 7.0 хувь нь 19:00-22:00 цагт, 1352 буюу 22.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	4	3	3	3	2	6	6	27
01:00	38	28	25	30	27	36	41	225
02:00	38	43	37	43	41	44	38	284
03:00	8	15	13	12	13	26	21	108
04:00	20	28	27	15	28	15	31	164
05:00	30	37	53	34	45	33	50	282
06:00	7	11	5	8	8	7	7	53
07:00	49	62	50	51	45	48	45	350
08:00	73	75	62	68	54	45	48	425
09:00	14	7	14	28	12	5	10	90
10:00	80	83	88	87	60	68	68	534
11:00	80	75	93	79	68	53	53	501
12:00	21	25	29	15	18	19	17	144
13:00	88	71	82	71	86	46	60	504
14:00	100	81	96	109	99	59	66	610
15:00	37	36	36	40	41	25	27	242
16:00	55	69	55	45	49	56	38	367
17:00	40	62	52	41	39	36	28	298
18:00	12	17	13	12	15	14	5	88
19:00	27	26	25	32	21	21	22	174
20:00	19	38	22	28	28	23	20	178
21:00	9	9	7	8	13	9	9	64
22:00	17	18	15	23	14	17	17	121
23:00	19	14	24	25	19	22	18	141
Нийт	885	933	926	907	845	733	745	5974



Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1304 буюу 21.8 хувь нь гэр орон сууцанд, 1356 буюу 22.7 хувь нь гудамж талбайд, 1023 буюу 17.1 хувь нь олон нийтийн газарт, 35 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 20 буюу 0.3 хувь нь төрийн байгууллагад, 41 буюу 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 738 буюу 12.3 хувь нь аж ахуйн нэгжид, 182 буюу 3.0 хувь нь авто замд, 1275 буюу 21.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 296 буюу 5.0 хувь нь согтуугаар, 850 буюу 14.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 121 буюу 2.0 хувь нь бүлэглэн, 59 буюу 1.0 хувь нь хүүхэд оролцож, 65 буюу 1.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1957 буюу 32.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 9808 хэрэгт хэрэг бүртгэлт, 244 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 10052 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 2978 урьд оны үлдэгдэл хэрэг, 5958 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 11, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 1105 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 3788 буюу 37.7 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 1750 буюу 46.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 1031 буюу 27.2 хувийг шүүхэд шилжүүлж;
- 16 буюу 0.4 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 946 буюу 25.0 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 45 буюу 1.2 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 37.7 хувь, хуулийн анхны хугацаанд 84.7 хувийг шийдвэрлэж 202 хүнд холбогдох 6428 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянгол дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1480 буюу 24.8 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 32.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 19.4 нэгжээр буурсан. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 9.4 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 5781 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 1433 хэрэг буюу 33.0 хувиар өссөн, 1893 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 375 буюу 16.5 хувиар буурсан байна.

Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2175 хүн шалгагдсан нь өмнөх оноос 13.4 хувиар буурсан. Яллагдагчдын 1620 буюу 74.5 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 1.0 хувиар, 555 буюу 25.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 36.6 хувиар тус тус буурч, 83 буюу 3.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 9.2 хувиар өссөн байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 5813 иргэн, 10 хуулийн этгээд хохирч, 68 хүн нас барж, 1069 хүн гэмтсэн нь өмнөх оноос, хохирсон хүн 1449 буюу 33.2 хувиар, нас барсан хүн 19 буюу 38.8 хувиар, гэмтсэн хүн 140 буюу 15.1 хувиар тус тус өссөн.

4.2. Учирсан хохирол.



буурсан байна.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 74.3 тэрбум төгрөгийн хохирлын 33.2 тэрбум төгрөг буюу 44.7 хувийг нөхөн төлүүлж, 4.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 12.9 тэрбум төгрөг буюу 21.0 хувиар өсөж, нөхөн төлүүлсэн хохирол 16.0 тэрбум төгрөг буюу 32.6 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 4001.5 сая төгрөг буюу 99.9 хувиар

Тав. Зөрчил.

Нийслэлийн Баянгол дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 32178 зөрчил шалгасан нь өмнөх оноос 95951 буюу 74.9 хувиар, 31788 зөрчлийг шийдвэрлэсэн нь 96091 буюу 75.1 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 6593 буюу 20.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 16021 буюу 49.8 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 752 буюу 2.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 290 буюу 0.9 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 8522 буюу 26.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.





Зөрчил гаргасан 31197 иргэн, 75 хуулийн этгээдийг 1560.1 сая төгрөгөөр торгож, 515 хүнийг баривчлуулах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 93340 буюу 74.9 хувиар, баривчлуулсан шийтгэл 373 буюу 42.0 хувиар тус тус буурсан байна.

Зургаа. Дүгнэлт.

Баянгол дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 29841 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 16124 буюу 54.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 13717 буюу 46.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 4427 буюу 11.5 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 6093 буюу 30.8 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1666 буюу 11.5 хувиар өссөн байна.

Өнгөрсөн онд нийт 5974 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1518 буюу 32.7 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 32.7 хувь бөгөөд 19.4 нэгжээр буурсан байна. Нийт гэмт хэргийн 3410 буюу 57.1 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 775 буюу 13.0 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 80 буюу 1.3 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Хулгайлах 2.1 дахин, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 2.2 дахин, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2.1 дахин, Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 66.7, Дээрэмдэх 86.6, Залилах 11.8, Эдийн засгийн гэмт хэрэг 95.0, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 68.8 хувиар тус тус өсөж, Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 66.1, Хүчиндэх 6.7, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 59.5, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 62.5, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 38.4, Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 45.2 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 296 буюу 4.9 хувь нь согтуугаар, 850 буюу 14.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 121 буюу 2.0 хувь нь бүлэглэн, 59 буюу 1.0 хувь нь хүүхэд оролцож, 65 буюу 1.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 4496 буюу 75.2 хувь нь Даваа-Баасан гарагт, 2601 буюу 53.5 хувь нь 06:00-14:00 цагуудад, 3935 буюу 82.0% нь гэр, орон сууц, олон нийтийн газар, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн хороодод гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 1553 буюу 71.4 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 1092 буюу 50.2 хувь нь 18-29 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 74338.7 сая төгрөгийн хохирлын 33213.1 сая төгрөг буюу 44.7 хувийг нөхөн төлүүлж, 4.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 12915.4 сая төгрөг буюу 21.0 хувиар өсөж, нөхөн төлүүлсэн хохирол 16081.0 сая төгрөг буюу 32.6 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 4001.5 сая төгрөг буюу 99.9 хувиар буурсан байна.

---oooOooo---

2.2. БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 51513 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 23697 буюу 46.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 27816 буюу 54.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 854 буюу 1.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 3745 буюу 11.9 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 2891 буюу 13.9 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 5017 буюу 22.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 17346 буюу 76.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 338 буюу 1.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 8323 буюу 30.3 хувийг зөрчлийн хэрэг нээж, 19045 буюу 69.5 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 66 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 8702 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 2572 буюу 42.0 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 27.1 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүрэг).





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	224	218	-6	-2.7	23-р хороо	143	180	37	25.9
2-р хороо	190	234	44	23.2	24-р хороо	53	94	41	77.4
3-р хороо	238	320	82	34.5	25-р хороо	101	182	81	80.2
4-р хороо	188	337	149	79.3	26-р хороо	197	453	256	2.3 дах
5-р хороо	130	240	110	84.6	27-р хороо	366	157	-209	-57.1
6-р хороо	227	307	80	35.2	28-р хороо	134	91	-43	-32.1
7-р хороо	239	326	87	36.4	29-р хороо	64	89	25	39.1
8-р хороо	357	300	-57	-16	30-р хороо	109	305	196	2.8 дах
9-р хороо	131	176	45	34.4	31-р хороо	58	92	34	58.6
10-р хороо	138	271	133	96.4	32-р хороо	63	92	29	46
11-р хороо	188	307	119	63.3	33-р хороо	20	55	35	2.8 дах
12-р хороо	120	198	78	65	34-р хороо	22	94	72	4.3
13-р хороо	145	228	83	57.2	35-р хороо	23	64	41	2.8 дах
14-р хороо	297	543	246	82.8	36-р хороо	72	139	67	93.1
15-р хороо	107	143	36	33.6	37-р хороо	46	132	86	2.9 дах
16-р хороо	223	329	106	47.5	38-р хороо	53	160	107	3.0 дах
17-р хороо	101	123	22	21.8	39-р хороо	54	147	93	2.7 дах
18-р хороо	463	181	-282	-60.9	40-р хороо	63	93	30	47.6
19-р хороо	112	197	85	75.9	41-р хороо	75	100	25	33.3
20-р хороо	107	173	66	61.7	42-р хороо	141	326	185	2.3 дах
21-р хороо	97	99	2	2.1	43-р хороо	82	145	63	76.8
22-р хороо	169	262	93	55					

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 8015 буюу 92.1 хувь нь хөнгөн, 687 буюу 7.9 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 42.0, хүнд хэрэг 41.4 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	127	186	46.5	2.1
	Үүнээс: Хүнийг алах	22	18	-18.2	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1182	974	-17.6	11.2



	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	18	7	-61.1	0.1
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	118	147	24.6	1.7
	Үүнээс: Хүчиндэх	86	104	20.9	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	78	136	74.4	1.6
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	-	4	-	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3	11	3.7 дах	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	19	32	68.4	0.4
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	4202	6592	56.9	75.8
8	Үүнээс: Хулгайлах	855	1750	2.0 дах	20.1
	Дээрэмдэх	58	89	53.4	1.0
	Залилах	2919	4143	41.9	47.6
9	Эдийн засгийн гэмт хэрэг	26	58	2.2 дах	0.7
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	101	56	-44.6	0.6
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	16	32	2.0 дах	0.4
12	Авлигын эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дах	0.0
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	24	25	4.2	0.3
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	11	20	81.8	0.2
15	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.0
16	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	90	133	47.8	1.5
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	132	292	2.2 дах	3.4
17	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	132	291	2.2 дах	3.3

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	3	2	2	6	1	2	7	23
01:00	31	35	35	39	29	31	29	229
02:00	26	42	51	50	28	34	41	272
03:00	20	16	14	9	12	16	23	110
04:00	30	40	28	28	22	31	27	206
05:00	40	53	34	40	50	36	30	283
06:00	14	8	12	8	4	6	4	56
07:00	31	28	33	33	26	26	29	206
08:00	85	94	95	70	75	78	63	560
09:00	29	16	14	12	15	13	17	116
10:00	80	102	84	69	86	68	76	565
11:00	132	100	113	109	101	117	70	742
12:00	36	30	39	27	26	21	20	199
13:00	166	146	149	122	129	88	115	915
14:00	143	121	131	131	106	98	90	820
15:00	43	40	35	42	37	25	38	260
16:00	107	116	122	100	92	73	72	682
17:00	92	100	118	86	91	80	78	645
18:00	14	31	24	20	14	18	19	140
19:00	65	72	59	63	61	50	51	421
20:00	88	69	87	72	61	71	61	509
21:00	9	22	16	20	16	29	24	136
22:00	49	54	43	37	39	39	41	302
23:00	43	42	45	46	55	30	44	305
Нийт	1376	1379	1383	1239	1176	1080	1069	8702




Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1375 буюу 15.8 хувь нь даваа гарагт, 1380 буюу 15.9 хувь нь мягмар гарагт, 1383 буюу 15.9 хувь нь лхагва гарагт, 1239 буюу 14.2 хувь нь пүрэв гарагт, 1176 буюу 13.5 хувь нь баасан гарагт, 1080 буюу 12.4 хувь нь бямба гарагт, 1069 буюу 12.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 3359 буюу 38.6 хувь нь 06:00-14:00 цагт, 2547 буюу 29.3 хувь нь 14:00-19:00 цагт, 1066 буюу 12.3 хувь нь 19:00-22:00 цагт, 1730 буюу 19.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 3433 буюу 39.5 хувь нь гэр орон сууцанд, 2108 буюу 24.2 хувь нь гудамж талбайд, 901 буюу 10.4 хувь нь олон нийтийн газарт, 72 буюу 0.8 хувь нь нийтийн тээвэрт, 43 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 48 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 518 буюу 6.0 хувь нь аж ахуйн нэгжид, 295 буюу 3.4 хувь нь авто замд, 1284 буюу 14.8 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 548 буюу 6.3 хувь нь согтуугаар, 1730 буюу 19.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 779 буюу 9.0 хувь нь бүлэглэн, 226 буюу 2.6 хувь нь хүүхэд оролцож, 184 буюу 2.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 3715 буюу 42.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.




1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 14980 хэрэгт хэрэг бүртгэлт, 579 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 15559 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 4055 урьд оны үлдэгдэл хэрэг, 10597 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 18, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 889 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 8183 буюу 52.6 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 4382 буюу 53.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 2117 буюу 25.9 хувийг шүүхэд шилжүүлж;
- 47 буюу 0.6 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 1550 буюу 18.9 хувийг эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;



-87 буюу 1.1 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 52.6 хувь, хуулийн анхны хугацаанд 97.6 хувийг шийдвэрлэж 378 хүнд холбогдох 7764 хэргийн үлдэгдэлтэй байна.



2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 5219 буюу 60.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 43.9 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 13.3 нэгжээр буурсан. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 1.8 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 8411 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 2501 хэрэг буюу 42.3 хувиар, 3694 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 314 буюу 9.3 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Яллагдагч.


3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 4562 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 23.4 хувиар өссөн.

Яллагдагчдын 2537 буюу 55.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 11.2 хувиар, 2025 буюу 44.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 43.0 хувиар тус тус өсөж, 254 буюу 5.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 23.0 хувиар буурсан байна.




3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 8518 иргэн, 15 хуулийн этгээд хохирч, 136 хүн нас барж, 1155 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 2510 буюу 41.8 хувиар, хуулийн этгээд 7 буюу 87.5 хувиар, нас барсан хүн 10 буюу 7.9 хувиар тус тус өсөж, гэмтсэн хүн 106 буюу 8.4 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 99.0 тэрбум төгрөгийн хохирлын 45.4 тэрбум төгрөг буюу 45.9 хувийг нөхөн төлүүлж, 37.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой харьцуулахад хохирлын хэмжээ 23.5 тэрбум төгрөг буюу 31.2 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 23.6 тэрбум төгрөг буюу 2.1 дахин тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 42.4 сая төгрөг буюу 53.3 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 32923 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 142496 буюу 81.2 хувиар, 32673 зөрчлийг шийдвэрлэсэн нь 142220 буюу 81.3 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 144 буюу 0.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 15744 буюу 47.8 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1936 буюу 5.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 503 буюу 1.5 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 14596 буюу 44.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 30384 иргэн, 269 хуулийн этгээдийг 2013.7 сая төгрөгөөр торгож, 2016 хүнийг баривчлуулах, 4 хүнийг сургалтад хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад иргэнийг торгосон шийтгэл 137863 буюу 81.9 хувиар, баривчлуулсан шийтгэл 423 буюу 17.3 хувиар тус тус буурсан байна.

Нийт 3197 хүн саатуулагдаж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 55 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад саатуулагдсан хүн 403 буюу 14.4 хувиар өсөж, эрүүлжүүлэгдсэн хүн 786 буюу 93.5 хувиар буурсан байна.

Зургаа.Дүгнэлт.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 51513 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 23697 буюу 46.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 27816 буюу 54.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 1.6 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 11.9 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 2891 буюу 13.9 хувиар өссөн байна.

Өнгөрсөн онд нийт 8702 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 2572 буюу 42.0 хувиар буурч, хэргийн илрүүлэлт 43.9 хувьтай байгаа нь 13.3 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.



Нийт гэмт хэргийн 75.8 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 11.2 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 3.4 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн өмнөх онтой харьцуулахад Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 3.7 дахин, Хулгайлах 2.0 дахин, Эдийн засгийн гэмт хэрэг 2.2 дахин, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 2.0 дахин, Авлигын эсрэг гэмт хэрэг 3.0 дахин, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2.2 дахин, Хүчиндэх 20.9, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 74.4, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 68.4, Дээрэмдэх 53.4, Залилах 41.9, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4.2, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 81.8, Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 47.8 хувиар тус тус өсөж, Хүнийг алах 18.2, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 17.6, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 61.1, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 44.6 хувиар тус тус буурсан байна.

Тус дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэргийн 548 буюу 6.3 хувь нь согтуугаар, 1730 буюу 19.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 779 буюу 9.0 хувь нь бүлэглэн, 226 буюу 2.6 хувь нь хүүхэд оролцож, 184 буюу 2.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 6553 буюу 75.3 хувь нь Даваа-Баасан гарагт, 5906 буюу 67.9 хувь нь 06:00-19:00 цагуудад, 6825 буюу 78.4 хувь нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлж, гэмт хэргийн гаралт ихэссэн 4, 8, 11, 13, 37, 38, 39, 42 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 3095 буюу 67.8 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 3818 буюу 83.7 хувь нь 18-39 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 47.8 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 0.4 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 5.9 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1.5 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 44.3 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---

2.3. СҮХБААТАР ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 23.222 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 12.330 буюу 53.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 10.892 буюу 46.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 5586 буюу 19.4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 14 буюу 0.1 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 5572 буюу 33.8 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2570 буюу 21.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 8932 буюу 76.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 217 буюу 1.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 4206 буюу 39.0 хувийг зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн, 6563 буюу 60.9 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзаж, 11 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 4458 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 626 буюу 16.3 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 13.9 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүрэг).





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	729	1174	445	61.0	11-р хороо	303	342	39	12.9
2-р хороо	51	105	54	2.1 дах	12-р хороо	79	85	6	7.6
3-р хороо	209	384	175	83.7	13-р хороо	72	107	35	48.6
4-р хороо	76	125	49	64.5	14-р хороо	76	104	28	36.8
5-р хороо	84	100	16	19.0	15-р хороо	69	51	-18	-26.1
6-р хороо	210	265	55	26.2	16-р хороо	109	123	14	12.8
7-р хороо	152	184	32	21.1	17-р хороо	43	42	-1	-2.3
8-р хороо	918	619	-299	-32.6	18-р хороо	79	73	-6	-7.6
9-р хороо	220	215	-5	-2.3	19-р хороо	65	76	11	16.9
10-р хороо	203	206	3	1.5	20-р хороо	85	78	-7	-8.2

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4085 буюу 91.6 хувь нь хөнгөн, 373 буюу 8.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 16.9, хүнд хэрэг 10.7 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	33	83	2.5 дах	1.9
	Үүнээс: Хүнийг алах	12	9	-25.0	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	634	801	26.3	18.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	6	7	16.7	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	41	45	9.8	1.0
	Үүнээс: Хүчиндэх	33	31	-6.1	0.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	58	84	44.8	1.9
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	-	3	-	0.1
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	8	3	-62.5	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	3	1	-66.7	0.0
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2708	3035	12.1	68.1



Үүнээс:	Хулгайлах	618	649	5.0	14.6
	Дээрэмдэх	45	67	48.9	1.5
	Залилах	1821	1936	6.3	43.4
9	Эдийн засгийн гэмт хэрэг	38	55	44.7	1.2
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	2	1	-50.0	0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	67	51	-23.9	1.1
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	25	31	24.0	0.7
13	Авлигын гэмт хэрэг	-	4	-	0.1
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	51	37	-27.5	0.8
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	7	3	-57.1	0.1
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	74	65	-12.2	1.5
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	81	155	91.4	3.5
18	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	81	155	91.4	3.5
19	Цэргийн гэмт хэрэг	1	-	-	0.0

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 708 буюу 15.9 хувь нь даваа гарагт, 650 буюу 14.6 хувь нь мягмар гарагт, 671 буюу 15.1 хувь нь лхагва гарагт, 717 буюу 16.1 хувь нь пүрэв гарагт, 625 буюу 14.0 хувь нь баасан гарагт, 560 буюу 12.6 хувь нь бямба гарагт, 527 буюу 11.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2014 буюу 45.2 хувь нь 06:00-14:00 цагт, 1187 буюу 26.6 хувь нь 14:00-19:00 цагт, 350 буюу 7.9 хувь нь 19:00-22:00 цагт, 907 буюу 20.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00		1	1			2	1	5
01:00	22	28	20	27	32	32	36	197
02:00	16	18	26	28	23	19	15	145
03:00	13	10	10	14	14	12	14	87
04:00	16	26	14	14	22	25	10	127
05:00	23	17	23	18	14	20	22	137
06:00	10	4	10	10	6	11	6	57
07:00	16	15	38	17	20	15	11	132
08:00	34	29	19	35	17	27	17	178
09:00	25	22	16	21	14	22	23	143
10:00	92	76	83	75	56	52	59	493
11:00	41	46	41	63	43	33	33	300
12:00	31	32	35	41	26	25	21	211
13:00	98	74	84	78	68	51	47	500
14:00	50	54	47	60	58	39	41	349
15:00	26	22	26	29	21	24	15	163
16:00	68	51	55	43	54	40	47	358
17:00	45	39	34	36	33	26	30	243
18:00	8	12	7	16	11	10	10	74
19:00	21	18	25	37	22	26	17	166
20:00	22	21	20	23	13	17	22	138
21:00	6	7	6	7	9	7	4	46
22:00	14	15	15	9	27	18	12	110
23:00	11	13	16	16	22	7	14	99
Нийт	708	650	671	717	625	560	527	4458




Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 789 буюу 17.7 хувь нь гэр орон сууцанд, 1088 буюу 24.4 хувь нь гудамж талбайд, 594 буюу 13.3 хувь нь олон нийтийн газарт, 15 буюу 0.3 хувь нь нийтийн тээвэрт, 46 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 29 буюу 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 644 буюу 14.4 хувь нь аж ахуйн нэгжид, 156 буюу 3.5 хувь нь авто замд, 1097 буюу 24.6 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 332 буюу 7.4 хувь нь согтуугаар, 463 буюу 10.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 112 буюу 2.5 хувь нь бүлэглэн, 164 буюу 3.7 хувь нь хүүхэд оролцож, 70 буюу 1.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1413 буюу 31.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 7396 хэрэгт хэрэг бүртгэлт, 327 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 7723 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 2312 урьд оны үлдэгдэл хэрэг, 4900 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 10, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 501 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 4137 буюу 53.6 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 1778 буюу 43.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 965 буюу 23.3 хувийг шүүхэд шилжүүлж;
- 37 буюу 0.9 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 1289 буюу 31.2 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 68 буюу 1.6 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 53.6 хувь, хуулийн анхны хугацаанд 88.6 хувийг шийдвэрлэж 222 хүнд холбогдох 3804 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Сүхбаатар дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 2167 буюу 48.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 45.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 11.1 нэгжээр буурсан. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 3.6 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 4190 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 874 хэрэг буюу 26.4 хувиар, 1915 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 32 буюу 1.7 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2252 хүн шалгагдсан нь өмнөх оноос 13.7 хувиар буурсан. Яллагдагчдын 1933 буюу 85.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 12.5 хувиар, 319 буюу 14.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 20.6 хувиар тус тус буурч, 206 буюу 9.1 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 60.9 хувиар өссөн байна.




3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4315 иргэн, 20 хуулийн этгээд хохирч, 67 хүн нас барж, 902 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 581 буюу 15.6 хувиар, нас барсан хүн 26 буюу 63.4 хувиар, гэмтсэн хүн 226 буюу 33.4 хувиар тус тус өссөн.



4.2. Учирсан хохирол.



/Сая төгрөгөөр/


■ 2023 он ■ 2024 он

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 163.6 тэрбум төгрөгийн хохирлын 31.1 тэрбум төгрөг буюу 19.0 хувийг нөхөн төлүүлж, 2541.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 83.1 тэрбум төгрөг буюу 2.0 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 8439.2 сая төгрөг буюу 37.2 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 2488.6 сая төгрөг буюу 47.7 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 27672 зөрчил шалгасан нь өмнөх оноос 71043 буюу 72.0 хувиар, 26990 зөрчлийг шийдвэрлэсэн нь 71509 буюу 72.6 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 14734 буюу 53.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 6876 буюу 24.8 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 874 буюу 3.2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 267 буюу 1.0 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 4921 буюу 17.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 26264 иргэн, 121 хуулийн этгээдийг 1355.4 сая төгрөгөөр торгож, 604 хүнийг баривчлуулах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 67749 буюу 72.1 хувиар, баривчлуулсан шийтгэл 371 буюу 38.1 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Сүхбаатар дүүрэгт нийт 12 хүн саатуулсан нь өмнөх оноос 10 буюу 6.0 дахин өссөн байна.

Зургаа. Дүгнэлт.

Тус дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээллээс үзэхэд сүүлийн 4 жил (2021-2024)-д тогтмол буюу жилд дунджаар 23.5 хувиар өссөн ба цаашид ч мөн өсөх төлөв ажиглагдаж байна. Мөн дүүрэгт 2024 онд 4458 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 626 буюу 16.3 хувиар өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 34.6 хувь бөгөөд 11.1 нэгжээр буурсан.

Нийт гэмт хэргийн дийлэнх буюу 67.2 хувь нь 1, 3, 6, 8, 9, 11 дүгээр хороо буюу төрийн болон төрийн бус байгууллага, бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж ихээр төвлөрсөн, хүн амын нягтаршил ихтэй нутаг дэвсгэрт бүртгэгджээ.

Өнгөрсөн онд бүртгэгдсэн гэмт хэргийн 1936 буюу 43.4 хувийг “Залилах” гэмт хэрэг эзэлж, өмнөх оноос 6.3 хувиар өссөн байна. Энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэх болсон шалтгаан нь хүн амын өсөлт, шилжилт, хөдөлгөөн, дэд бүтэц, технологийн хурдацтай хөгжил зэрэг нөхцөл байдлуудтай холбоотой гэж үзэж байна.

Мөн нийт гэмт хэргийн 31.7 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн нь нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлээс хамаарахын зэрэгцээ иргэдийн эдийн засгийн сонирхол, ухамсарт байдал, техник, технологийн хурдацтай хөгжлийг дагаад нийгмийн бүхий л харилцаа цахим хэлбэрт шилжсэнтэй холбогдон дүгнэж болохоор байна.

Гэмт этгээдүүд цахим орчинд иргэдийн хувийн мэдээллийг хууль бусаар авч, бусдыг залилах, хууль бус цахим худалдаа явуулах зэрэг олон төрөл хэлбэрээр залилах гэмт хэрэг үйлдэх нь энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлтийг бууруулах гол шалтгаан нөхцөл болоод байна.

Залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдад техник технологи, программ хангамж ашиглах, сурган дадлагажуулах, энэ төрлийн гэмт хэрэгт эрсдэлийн



үнэлгээ хийж, өртөж хохирч болзошгүй иргэд болон газар орон, цаг хугацааг тодорхойлох, эрсдэлийн талаар мэдээлэл өгөх, банк санхүүгийн байгууллагуудтай хамтран санхүүгийн урсгалд хяналт тавих шаардлагатай.

---oooOooo---

2.4. СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 42578 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 15125 буюу 35.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 27453 буюу 64.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 4559 буюу 9.7 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 6485 буюу 19.1 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1926 буюу 14.6 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 1425 буюу 9.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 12892 буюу 89.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 128 буюу 0.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 8296 буюу 30.6 хувийг зөрчлийн хэрэг нээж, 18763 буюу 69.3 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 22 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 3898 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 513 буюу 15.2 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 12.1 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүрэг).





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	73	64	-9	-12.3	23-р хороо	30	47	17	56.7
2-р хороо	79	83	4	5.1	24-р хороо	80	105	25	31.3
3-р хороо	43	67	24	55.8	25-р хороо	56	77	21	37.5
4-р хороо	74	80	6	8.1	26-р хороо	73	73	0	0.0
5-р хороо	60	64	4	6.7	27-р хороо	108	122	14	13.0
6-р хороо	109	103	-6	-5.5	28-р хороо	44	80	36	81.8
7-р хороо	77	95	18	23.4	29-р хороо	164	188	24	14.6
8-р хороо	48	77	29	60.4	30-р хороо	33	39	6	18.2
9-р хороо	99	99	0	0.0	31-р хороо	35	54	19	54.3
10-р хороо	78	89	11	14.1	32-р хороо	158	195	37	23.4
11-р хороо	59	93	34	57.6	33-р хороо	120	149	29	24.2
12-р хороо	104	144	40	38.5	34-р хороо	71	83	12	16.9
13-р хороо	51	65	14	27.5	35-р хороо	24	22	-2	-8.3
14-р хороо	84	113	29	34.5	36-р хороо	51	77	26	51.0
15-р хороо	69	71	2	2.9	37-р хороо	216	204	-12	-5.6
16-р хороо	60	77	17	28.3	38-р хороо	46	53	7	15.2
17-р хороо	63	102	39	61.9	39-р хороо	35	24	-11	-31.4
18-р хороо	101	104	3	3.0	40-р хороо	62	73	11	17.7
19-р хороо	204	183	-21	-10.3	41-р хороо	48	62	14	29.2
20-р хороо	152	155	3	2.0	42-р хороо	33	39	6	18.2
21-р хороо	107	93	-14	-13.1	43-р хороо	36	31	-5	-13.9
22-р хороо	68	80	12	17.6					

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3346 буюу 85.8 хувь нь хөнгөн, 552 буюу 14.2 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 13.1, хүнд хэрэг 29.3 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	54	107	98.1	2.7
	Үүнээс: Хүнийг алах	33	24	-27.3	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1159	967	-16.6	24.8
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	17	9	-47.1	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	68	92	35.3	2.4
	Үүнээс: Хүчиндэх	59	73	23.7	1.9



4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	18	36	2.0 дах	0.9
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	6	6.0 дах	0.2
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	9	3	-66.7	0.1
7	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		1		0.0
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1827	2329	27.5	59.7
8	Үүнээс: Хулгайлах	678	730	7.7	18.7
	Дээрэмдэх	102	126	23.5	3.2
	Залилах	828	1122	35.5	28.8
9	Эдийн засгийн гэмт хэрэг	13	16	23.1	0.4
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	60	39	-35.0	1.0
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.1
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	27	16	-40.7	0.4
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	26	17	-34.6	0.4
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	18	39	2.2 дах	1.0
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	101	226	2.2 дах	5.8
15	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	101	226	2.2 дах	5.8

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 604 буюу 15.5 хувь нь даваа гарагт, 606 буюу 15.5 хувь нь мягмар гарагт, 660 буюу 16.9 хувь нь лхагва гарагт, 538 буюу 13.8 хувь нь пүрэв гарагт, 531 буюу 13.6 хувь нь баасан гарагт, 447 буюу 11.5 хувь нь бямба гарагт, 512 буюу 13.1 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1269 буюу 32.5 хувь нь 06:00-14:00 цагт, 1099 буюу 28.2 хувь нь 14:00-19:00 цагт, 670 буюу 17.2 хувь нь 19:00-22:00 цагт, 860 буюу 22.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	5	6	7	3	4	4	6	35
01:00	14	11	13	19	18	20	15	110
02:00	16	20	15	7	15	13	18	104
03:00	11	8	6	8	10	3	9	55
04:00	11	18	16	14	12	15	14	100
05:00	22	21	20	15	21	11	24	134
06:00	6	2	5	5	4	7	5	34
07:00	18	16	11	14	11	10	21	101
08:00	21	28	31	21	14	15	28	158
09:00	3	4	8	7	5	4	10	41
10:00	40	43	46	43	51	37	33	293
11:00	45	31	40	39	30	18	22	225
12:00	12	12	10	18	13	13	9	87
13:00	50	50	58	58	44	32	38	330
14:00	45	41	59	45	27	24	29	270
15:00	19	24	19	7	18	14	16	117
16:00	51	46	65	48	49	29	49	337
17:00	47	54	52	44	39	32	37	305
18:00	11	12	8	11	12	8	8	70
19:00	29	46	34	20	25	40	28	222
20:00	74	51	71	39	61	44	39	379
21:00	9	13	12	10	8	9	8	69
22:00	16	24	27	19	17	15	18	136
23:00	29	25	27	24	23	30	28	186
Нийт	604	606	660	538	531	447	512	3898




Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1411 буюу 36.2 хувь нь гэр орон сууцанд, 961 буюу 24.7 хувь нь гудамж талбайд, 345 буюу 8.8 хувь нь олон нийтийн газарт, 23 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 12 буюу 0.3 хувь нь төрийн байгууллагад, 18 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 254 буюу 6.5 хувь нь аж ахуйн нэгжид, 225 буюу 5.8 хувь нь авто замд, 649 буюу 16.6 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 345 буюу 8.9 хувь нь согтуугаар, 527 буюу 13.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 101 буюу 2.6 хувь нь бүлэглэн, 146 буюу 3.7 хувь нь хүүхэд оролцож, 104 буюу 2.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 809 буюу 20.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 7485 хэрэгт хэрэг бүртгэлт, 488 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 7973 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 2030 урьд оны үлдэгдэл хэрэг, 5176 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 11, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 756 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 4456 буюу 55.9 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 2521 буюу 56.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 1565 буюу 35.1 хувийг шүүхэд шилжүүлж;
- 46 буюу 1.0 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 279 буюу 6.3 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 45 буюу 1.0 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 55.9 хувь, хуулийн анхны хугацаанд 97.9 хувийг шийдвэрлэж 137 хүнд холбогдох 3581 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1745 буюу 44.8 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 46.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 10.9 нэгжээр буурсан. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 4.6 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 3706 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 616 хэрэг буюу 19.9 хувиар өсөж, 1729 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 49 буюу 2.8 хувиар буурсан байна.

Гурав. Яллагдагч.


3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 1975 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 13.1 хувиар.

Яллагдагчдын 1558 буюу 78.9 хувь нь эрэгтэй хүн эзэлж байгаа нь 17.0 хувиар, 178 буюу 9.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 15.6 хувиар тус тус буурч, 417 буюу 21.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 5.0 хувиар өссөн байна.



3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 3820 иргэн, 6 хуулийн этгээд хохирч, 112 хүн нас барж, 1151 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 461 буюу 13.7 хувиар, нас барсан хүн 46 буюу 69.7 хувиар тус тус өсөж, гэмтсэн хүн 140 буюу 10.8 хувиар буурсан.

4.2. Учирсан хохирол.



/Сая төгрөгөөр/



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 17.5 тэрбум төгрөгийн хохирлын 6.8 тэрбум төгрөг буюу 38.9 хувийг нөхөн төлүүлж, 198.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 1.1 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 1.6 тэрбум төгрөг буюу 32.9 хувиар, битүүмжилсэн хөрөнгө

60.8 сая төгрөг буюу 44.1 хувиар тус тус өссөн байна.


Тав. Зөрчил.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 51299 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 64989 буюу 55.9 хувиар, 50637 зөрчлийг шийдвэрлэсэн нь 65145 буюу 56.3 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 19847 буюу 38.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 20496 буюу 40.0 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1872 буюу



3.6 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 802 буюу 1.6 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 8282 буюу 16.1 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 49.002 иргэн, 31 хуулийн этгээдийг 1400.3 сая төгрөгөөр торгож, 1603 хүнийг баривчлуулах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 63.104 буюу 56.3 хувиар, хуулийн этгээд 15 буюу 32.6 хувиар, баривчлуулсан шийтгэл 152 буюу 8.7 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Сонгинохайрхан дүүрэгт нийт 781 хүн согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн эрүүлжүүлэгдэж, 6663 хүн саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 1126 буюу 59.0 хувиар, саатуулсан хүн 336 буюу 4.8 хувиар тус тус буурсан байна.

Зургаа. Дүгнэлт

Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 42.578 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 15.125 буюу 35.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 27453 буюу 64.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 4559 буюу 9.7 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 6485 буюу 19.1 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1926 буюу 14.6 хувиар өссөн байна.

Тус дүүргийн цагдаагийн газарт 3898 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 513 буюу 15.2 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 46.7 хувь буюу 10.9 нэгжээр буурсан.

Нийт гэмт хэргийн 2339 буюу 59.7 хувийг өмчлөх эрхийн эсрэг, 967 буюу 24.8 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 226 буюу 5.8 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 6.0 дахин, кибер аюулгүй байдлын эсрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 2 дахин, хүний амьд явах эрхийн эсрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, хүчиндэх, хулгайлах, дээрэмдэх, залилах, эдийн засгийн гэмт хэрэг 7.7-98.1 хувиар өсөж, хүнийг алах, гэр бүлийн



хүчирхийлэл үйлдэх, хүүхдийн эсрэг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 16.6-66.7 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 345 буюу 8.9 хувь нь согтуугаар, 527 буюу 13.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 101 буюу 2.6 хувь нь бүлэглэн, 146 буюу 3.7 хувь нь хүүхэд оролцож, 104 буюу 2.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 1266 буюу 32.5 хувь нь мягмар, лхагва гарагт, 2368 буюу 60.7 хувь нь 06:00-19:00 цагуудад, 2626 буюу 67.4 хувь нь гэр, орон сууц, гудамж талбай, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн бол гэмт хэрэгт Яллагдагчдын 1051 буюу 53.2 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 834 буюу 42.2 хувь нь 18-34 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд холбогдож байгаа нь бол нийт гэмт хэргийн 22,6 хувийг 12,19,20,32,37 дугаар хороодод бүртгэгдсэн бол дээрх хороод нь хүн ам ихтэй, байшин, гэр хороолол, үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд зонхилсон бөгөөд байнгын бус оршин суугч ихтэй архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэгүүд зэргээс хамааран хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон гэр бүлийн хүчирхийлэл, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг ихээр бүртгэгдэх шалтгаан болж байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 9033 буюу 33.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 12011 буюу 44.3 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1041 буюу 3.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 177 буюу 0.7 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 4828 буюу 17.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---

2.5. ХАН-УУЛ ДҮҮРГЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Хан-Уул дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 24939 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 11496 буюу 46.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 13443 буюу 53.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 91 буюу 0.4 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2733 буюу 16.9 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 2642 буюу 29.8 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 3072 буюу 28.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 7731 буюу 70.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 184 буюу 1.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 5229 буюу 39.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 7999 буюу 60.4 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 19 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 5101 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1127 буюу 28.4 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 15.9 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүрэг).





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	183	241	58	31.7	14-р хороо	57	96	39	68.4
2-р хороо	221	238	17	7.7	15-р хороо	414	652	238	57.5
3-р хороо	436	415	-21	-4.8	16-р хороо	236	106	-130	-55.1
4-р хороо	224	183	-41	-18.3	17-р хороо	177	236	59	33.3
5-р хороо	49	73	24	49.0	18-р хороо	112	263	151	2.3 дах
6-р хороо	75	83	8	10.7	19-р хороо	118	224	106	89.8
7-р хороо	40	31	-9	-22.5	20-р хороо	580	574	-6	-1.0
8-р хороо	90	150	60	66.7	21-р хороо	127	238	111	87.4
9-р хороо	54	67	13	24.1	22-р хороо	38	69	31	81.6
10-р хороо	74	120	46	62.2	23-р хороо	73	216	143	2.9 дах
11-р хороо	319	370	51	16.0	24-р хороо	100	237	137	2.3 дах
12-р хороо	51	58	7	13.7	25-р хороо	95	118	23	24.2
13-р хороо	31	43	12	38.7					

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4689 буюу 91.9 хувь нь хөнгөн, 412 буюу 8.1 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 30.0 хувиар, хүнд хэрэг 8.1 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	76	75	-1.3	1.5
	Үүнээс: Хүнийг алах	13	14	7.7	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	621	614	-1.1	12.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	8	60.0	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	47	53	12.8	1.0
	Үүнээс: Хүчиндэх	37	44	18.9	0.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	48	81	68.8	1.6
5	Хувь хүний улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		2		0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	5	8	60.0	0.2
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1	5	5.0 дах	0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2814	3884	38.0	76.1
8	Хулгайлах	431	996	2.3 дах	19.5
	Дээрэмдэх	13	40	3.0 дах	0.8



	Залилах	2059	2370	15.1	46.5
9	Эдийн засгийн гэмт хэрэг	24	42	75.0	0.8
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	81	34	-58.0	0.7
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	22	18	-18.2	0.4
12	Авлигын эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.0
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	38	25	-34.2	0.5
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	7	18	2.5 дах	0.4
15	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	79	55	-30.4	1.1
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	109	186	70.6	3.6
16	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	109	185	69.7	3.6
17	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1			

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 785 буюу 15.4 хувь нь даваа гарагт, 739 буюу 15.4 хувь нь мягмар гарагт, 753 буюу 14.8 хувь нь лхагва гарагт, 728 буюу 14.3 хувь нь пүрэв гарагт, 796 буюу 15.6 хувь нь баасан гарагт, 675 буюу 13.2 хувь нь бямба гарагт, 624 буюу 12.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2220 буюу 43.5 хувь нь 06:00-14:00 цагт, 1525 буюу 29.9 хувь нь 14:00-19:00 цагт, 443 буюу 8.7 хувь нь 19:00-22:00 цагт, 913 буюу 17.9 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	1	2	1	3	1	3	2	13
01:00	32	26	16	19	27	35	24	179
02:00	19	19	22	19	24	21	18	142
03:00	11	13	18	11	14	16	13	96
04:00	22	8	18	15	13	11	16	103
05:00	16	12	6	21	18	16	9	98
06:00	10	2	1	2	2	2	6	25
07:00	21	20	16	20	13	11	22	123
08:00	29	30	32	28	32	27	24	202
09:00	9	3	11	11	7	6	7	54
10:00	104	108	93	103	111	95	76	690
11:00	69	51	80	60	57	54	52	423
12:00	22	19	26	14	19	10	12	122
13:00	105	77	89	72	101	72	65	581
14:00	61	75	75	63	66	62	56	458
15:00	34	40	32	39	40	25	34	244
16:00	55	70	53	62	55	45	40	380
17:00	56	46	53	74	42	42	43	356
18:00	11	18	10	13	13	13	9	87
19:00	30	24	30	19	37	30	26	196
20:00	25	26	27	29	34	22	22	185
21:00	8	8	9	4	15	12	6	62
22:00	18	20	12	13	32	22	20	137
23:00	18	22	23	14	23	23	22	145
Нийт	786	739	753	728	796	675	624	5101

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1996 буюу 39.1 хувь нь гэр орон сууцанд, 1091 буюу 21.4 хувь нь гудамж талбайд, 294 буюу 5.8 хувь нь олон нийтийн газарт, 50 буюу 1.0 хувь нь нийтийн тээвэрт, 27 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 22 буюу 0.4 хувь нь




төрийн бус байгууллагад, 489 буюу 9.6 хувь нь аж ахуйн нэгжид, 194 буюу 3.8 хувь нь авто замд, 938 буюу 18.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 323 буюу 6.3 хувь нь согтуугаар, 475 буюу 9.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 150 буюу 2.9 хувь нь бүлэглэн, 275 буюу 5.4 хувь нь хүүхэд оролцож, 109 буюу 2.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1827 буюу 35.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 9976 хэрэгт хэрэг бүртгэлт, 369 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 10345 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 3731 урьд оны үлдэгдэл хэрэг, 6005 тухайн оны дугаартай хэрэг, 25 урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 584 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 4975 буюу 48.1 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 2865 буюу 57.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 1131 буюу 22.7 хувийг шүүхэд шилжүүлж;
- 54 буюу 1.1 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 850 буюу 17.1 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 75 буюу 1.5 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 48.1 хувь, хуулийн анхны хугацаанд 99.4 хувийг шийдвэрлэж, 213 хүнд холбогдох 5486 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Хан-Уул нийт бүртгэгдсэн хэргийн 2161 буюу 42.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 34.4 хувьтай байгаа нь өмнөх оноос 16.0 нэгжээр буурсан. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 7.7 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 4872 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 990 хэрэг буюу 25.5 хувиар өсөж, 1675 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 279 буюу 14.3 хувиар буурсан байна.

Гурав. Яллагдагч.


3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2062 хүн шалгагдсан нь өмнөх оноос 5.6 хувиар буурсан.

Яллагдагчдын 1748 буюу 84.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 5.5 хувиар, 314 буюу 15.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 6.3 хувиар тус тус буурсан бол 285 буюу 13.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 4.6 дахин нэмэгдсэн байна.



3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4999 иргэн, 17 хуулийн этгээд хохирч, 80 хүн нас барж, 746 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 1115 буюу 28.7 хувиар, нас барсан хүн 1 буюу 1.3 хувиар, гэмтсэн хүн 95 буюу 14.6 хувиар тус тус өссөн байна.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 128.8 тэрбум төгрөгийн хохирлын 86.3 тэрбум төгрөг буюу 67.0 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 21.8 тэрбум төгрөг буюу 20.4 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 30.8 тэрбум төгрөг буюу 55.5 хувиар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 14.8 сая төгрөг буюу 33.2 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 17703 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 81283 буюу 82.1 хувиар, 17183 зөрчлийг шийдвэрлэсэн нь 80945 буюу 82.5 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 4351 буюу 24.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 6301 буюу 35.6 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 108 буюу 0.6 хувь нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 872 буюу 4.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 6071 буюу 34.3 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 16431 иргэн, 130 хуулийн этгээдийг 1066.0 сая төгрөгөөр торгож, 620 хүнийг баривчлуулж, 2 хүнийг сургалтад хамруулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 78521 буюу 82.7 хувиар, баривчлуулсан шийтгэл 261 буюу 29.6 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Хан-Уул дүүрэгт нийт 2603 хүн саатуулагдсан нь өнгөрсөн оноос 780 буюу 42.8 хувиар өссөн бол согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн эрүүлжүүлэгдсэн хүн 196 бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 375 буюу 65.7 хувиар буурсан байна.

Зургаа. Дүгнэлт.

Хан-Уул дүүргийн цагдаагийн газарт 5101 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1127 буюу 28.4 хувь, хэргийн илрүүлэлт 34.4 хувь бөгөөд өмнөх оноос 16 хувиар буурсан.

Нийт гэмт хэргийн 76.1 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 12 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 3.6 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Дээрэмдэх 3.0 дахин, Хулгайлах 2.3 дахин, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 38 (үүнээс Залилах 15.1), Хүчиндэх 18.9, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 70.6 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн 323 буюу 6.3 хувь нь согтуугаар, 475 буюу 9.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 150 буюу 2.9 хувь нь бүлэглэн, 275 буюу 5.4 хувь нь хүүхэд оролцож, 109 буюу 2.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1827 буюу 35.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3801 буюу 74.5 хувь нь Даваа-Баасан гарагт, 3745 буюу 73.4 хувь нь 06:00-19:00 цагуудад, 3381 буюу 66.2 хувь нь гэр, орон сууц, гудамж талбай, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлж, гэмт хэргэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэг өссөн 14, 18, 19, 21, 22, 23, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 1083 буюу 21.2 хувь нь эрхэлсэн тодорхой ажил, орлогогүй иргэд, 1504 буюу 29.4 хувь нь 16-34 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.



Нийт бүртгэгдсэн зөрчлийн 24.6 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 35.6 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 4.9 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 0.6 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 34.3 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---

2.6. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 19726 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 8421 буюу 42.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 11305 буюу 57.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 4955 буюу 20.1 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 5494 буюу 32.7 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 539 буюу 6.8 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2156 буюу 26.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 5750 буюу 71.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 110 буюу 1.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 5157 буюу 46.3 хувийг зөрчлийн хэрэг нээж, 5958 буюу 53.4 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 35 буюу 0.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 3369 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 703 буюу 26.4 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 10.5 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүрэг).





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	207	273	66	31.9	13-р хороо	115	286	171	2.5 дах
2-р хороо	209	270	61	29.2	14-р хороо	86	94	8	9.3
3-р хороо	212	277	65	30.7	15-р хороо	98	103	5	5.1
4-р хороо	224	244	20	8.9	16-р хороо	86	101	15	17.4
5-р хороо	312	378	66	21.2	17-р хороо	69	70	1	1.4
6-р хороо	114	175	61	53.5	18-р хороо	101	130	29	28.7
7-р хороо	83	95	12	14.5	19-р хороо	127	106	-21	-16.5
8-р хороо	38	61	23	60.5	20-р хороо	8	26	18	3.2 дах
9-р хороо	57	61	4	7.0	21-р хороо	31	53	22	71.0
10-р хороо	103	126	23	22.3	22-р хороо	13	37	24	2.8 дах
11-р хороо	97	115	18	18.6	23-р хороо	35	26	-9	-25.7
12-р хороо	157	145	-12	-7.6	24-р хороо	84	117	33	39.3

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 2957 буюу 87.8 хувь нь хөнгөн, 412 буюу 12.2 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 20.0 хувиар, хүнд хэрэг 2.0 дахин тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	16	66	4.1 дах	2.0
	Үүнээс: Хүнийг алах	11	14	27.3	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	576	621	7.8	18.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	9	2	-77.8	0.1
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	26	51	96.2	1.5
	Үүнээс: Хүчиндэх	20	43	2.1 дах	1.3
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	32	36	12.5	1.1
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.0
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	7	3	-57.1	0.1
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1776	2266	27.6	67.3
	Үүнээс: Хулгайлах	416	613	47.4	18.2



	Дээрэмдэх	21	38	81.0	1.1
	Залилах	1217	1368	12.4	40.6
8	Эдийн засгийн гэмт хэрэг	20	36	80.0	1.1
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	79	59	-25.3	1.8
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	12	12	0.0	0.4
11	Авлигын эсрэг гэмт хэрэг		1		0.0
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 40.0, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 47.6, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 58.1, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 35.2 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн бүтцэд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 41.8 буюу хамгийн өндөр хувийг эзэлж буй нь зөвхөн хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаагаар бус, нийгэм эдийн засаг, боловсрол, хүмүүнлэгийн хөгжлийн цогц хандлагаар шийдэгдэх ба бууруулах боломж нь эдийн засгийн тогтвортой байдал, иргэдийн хууль сахих сэтгэлгээг хөгжүүлэх нь түлхүүр юм. Өөрөөр хэлбэл орлогын бага байдал, ажлын байрны хомсдол нь иргэдийг хулгай, дээрэмдэх зэрэгт хүргэдэг, инфляци валютын ханшны хэлбэлзэл нь хүмүүсийн амьжиргааг тэгш бус болгож, гэмт хэрэг үйлдэхэд хөтөлдөг, “Амжилтыг өмчийн хэмжээгээр хэмждэг” нийгмийн үзэл нь зарим хүмүүсийг хууль бус аргаар баяжихад хөтөлдөг, нэг удаагийн гэмт хэргээс ашиг олсон хүн үүнийг давтан хийх магадлал өндөр.

Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газраар авч үзвэл 73.7 хувь нь гэр орон сууцанд болон бусад газарт даваа, мягмар, лхагва гарагт 13:00-14:00, 16:00-17:00, 19:00-20:00, 22:00-23:00 цагуудад давтамжтай бүртгэгдсэн байна.

Орон нутагт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 4370 бүртгэгдсэн нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 55.3 хувийн өсөлттэй ба иргэдийн архи, согтууруулах ундааны хэрэглээ их улмаар гэмт хэрэгт холбогдох явдал ихсэх хандлагатай байна. Аймгуудын өсөлтийг харьцуулахад Говь-Алтай 1.5 дахин, Өвөрхангай аймаг 1.2 дахин, Баян-Өлгий аймаг 1 дахин, Дорнод аймаг 95 хувь бусад аймгууд 10-80 хувийн өссөн дүнтэй бүртгэгдсэн байна.

Иймд архи согтууруулах ундааны хяналтыг бэхжүүлэх, бүтээгдэхүүн худалдаалах цаг хугацаа (шөнө оройн цагаар худалдан борлуулахгүй байх), зөвшөөрөгдсөн иргэн, аж ахуйн нэгж, насны хязгаар (21-ээс дээш насны иргэдэд худалдан борлуулах) зэрэгт чандлан хязгаарлах нь

Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдож байгаа иргэдийн 4894 буюу 50 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 5108 буюу 52.0 хувь 18-34 насны сурч боловсрох, ажил хөдөлмөрлөх насны иргэд байгаа нь бүс нутгийн хөгжил, дэд бүтэц, аж үйлдвэр, амьжиргааны түвшин, ажлын байрны хүртээмжтэй холбогдож байна. Орон нутагт хүн амын нягтаршил бага хэдий ч ажилгүйдэл, боловсролын тэгш бус байдал гэмт явдлын гаралтад нөлөөлж байна.

3.1. АРХАНГАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Архангай аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 3027 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1121 буюу 37.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1906 буюу 63.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 102 буюу 3.5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 64 буюу 3.5 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 38 буюу 3.5 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 463 буюу 43.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 599 буюу 56.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 4 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1710 буюу 90.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 82 буюу 4.3 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 94 буюу 5.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 447 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 50 буюу 12.6 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 3.6 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг.





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Батцэнгэл	18	17	-1	-5.6	11	Хангай	5	6	1.0	20.0
2	Булган	9	13	4	44.4	12	Хашаат	15	6	-9.0	-60.0
3	Жаргалант	5	15	10	3.0 дах	13	Хотонт	19	18	-1.0	-5.3
4	Их тамир	32	28	-4	-12.5	14	Цахир	2	7	5.0	3.5 дах
5	Өгийнуур	8	13	5	62.5	15	Цэнхэр	28	32	4.0	14.3
6	Өлзийт	25	13	-12	-48.0	16	Цэцэрлэг	10	8	-2.0	-20.0
7	Өндөр-Улаан	24	19	-5	-20.8	17	Чулуут	4	6	2.0	50.0
8	Тариат	37	18	-19	-51.4	18	Эрдэнэбулган	118	190	72.0	61.0
9	Төвшрүүлэх	13	13	0	0.0	19	Эрдэнэмандал	17	11	-6.0	-35.3
10	Хайрхан	8	14	6	75.0						

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 316 буюу 70.7 хувь нь хөнгөн, 131 буюу 29.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 7.1 хувиар, хүнд хэрэг 28.4 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	6	7	16.7	1.6
	Үүнээс: Хүнийг алах	3	3	0.0	0.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	130	125	-3.8	28.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3			
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	9	10	11.1	2.2
	Үүнээс: Хүчиндэх	6	9	50.0	2.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	3	3	0.0	0.7
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1			
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	159	185	16.4	41.4
6	Үүнээс: Хулгайлах	70	55	-21.4	12.3
	Дээрэмдэх	1	5	5.0 дах	1.1
	Залилах	32	61	90.6	13.6
7	Эдийн засгийн гэмт хэрэг	1			
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.4
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.2
10	Авлигын эсрэг гэмт хэрэг		1		
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	3	-25.0	0.7
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	56	34	-39.3	7.6



13	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		1		
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.2
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	24	74	3.1 дах	16.6
15	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	24	74	3.1 дах	16.6

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 68 буюу 15.2 хувь нь даваа гарагт, 73 буюу 16.3 хувь нь мягмар гарагт, 72 буюу 16.1 хувь нь лхагва гарагт, 73 буюу 16.3 хувь нь пүрэв гарагт, 50 буюу 11.2 хувь нь баасан гарагт, 65 буюу 14.5 хувь нь бямба гарагт, 46 буюу 10.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 111 буюу 24.8 хувь нь 06:00-14:00 цагт, 110 буюу 24.6 хувь нь 14:00-19:00 цагт, 76 буюу 17.0 хувь нь 19:00-22:00 цагт, 150 буюу 33.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00		1	2			3		6
01:00	3	8	8	5	2	3	4	33
02:00	3	5	7	5	2	3	1	26
03:00	1		1	2	2	4	1	11
04:00	1		1	2		2	4	10
05:00	2			1		1		4
06:00					2	1		3
07:00		1				1	1	3
08:00	1	1	2					4
09:00	2	4	3	2	2	5	3	21
10:00	3	6	4	4	3	1	3	24
11:00	3		2	5	3		1	14
12:00	4	2	2	4				12
13:00	6	5	7	5	2		5	30
14:00	9	4	5	5	1	3	3	30
15:00	1	3	2			5	3	14
16:00	5	6	1	4	3	5	2	26
17:00	6	6	3	4	5	3	5	32
18:00	2	1	1		1	3		8
19:00	3	2	3	4	2	4	2	20
20:00	4	7	8	10	9	7	5	50
21:00		2	1	1	1	1		6
22:00	4	4	3	5	3	5	2	26
23:00	5	5	6	5	7	5	1	34
Нийт	68	73	72	73	50	65	46	447

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 129 буюу 28.8 хувь нь гэр орон сууцанд, 42 буюу 9.4 хувь нь гудамж талбайд, 21 буюу 4.7 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 6 буюу 1.3 хувь нь төрийн байгууллагад, 6 буюу 1.3 хувь нь аж ахуйн нэгжид, 71 буюу 15.9 хувь нь авто замд, 171 буюу 38.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 130 буюу 29.1 хувь нь согтуугаар, 37 буюу 8.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 20 буюу 4.5 хувь нь бүлэглэн, 37 буюу 8.3 хувь нь хүүхэд оролцож, 36 буюу 8.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 54 буюу 12.1 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 660 хэрэгт хэрэг бүртгэлт, 134 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 794 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 213 урьд оны үлдэгдэл хэрэг, 568 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 13 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 578 буюу 72.8 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 245 буюу 42.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 324 буюу 56.1 хувийг шүүхэд шилжүүлж;
- 1 буюу 0.2 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 7 буюу 1.2 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 1 буюу 0.2 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 72.8 хувь, хуулийн анхны хугацаанд 99.1 хувийг шийдвэрлэж, 14 хүнд холбогдох 222 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Архангай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 189 буюу 42.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 62.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 5.6 нэгжээр буурсан. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад ижил түвшинд байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 313 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 49 хэрэг буюу 18.6 хувиар, 196 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 16 буюу 8.9 хувиар тус тус өссөн байна.



Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 356 хүн шалгагдсан нь өмнөх оноос 2.5 хувиар буурсан.

Яллагдагчдын 318 буюу 89.3 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 7.0 хувиар, 9 буюу 2.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 40.0 хувиар тус тус буурч, 38 буюу 10.7 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 65.2 хувиар өссөн байна.


3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 450 иргэн, 1 хуулийн этгээд хохирч, 22 хүн нас барж, 163 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 39 буюу 9.5 хувиар, гэмтсэн хүн 5 буюу 3.2 хувиар тус тус өсөж, нас барсан хүн ижил түвшинд байна.





4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 3393.9 сая төгрөгийн хохирлын 2486.0 сая төгрөг буюу 73.3 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 2000.1 сая төгрөг буюу 2.4 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 1814.3 сая төгрөг буюу 3.7 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Архангай аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 37.448 зөрчил шалгасан нь өмнөх оноос 7294 буюу 16.3 хувиар, 37.362 зөрчлийг шийдвэрлэсэн нь 7324 буюу 16.4 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 32.568 буюу 87.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1727 буюу 4.6 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 206 буюу 0.6 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 73 буюу 0.2 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 2874 буюу 7.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 36.496 иргэн, 2 хуулийн этгээдийг 1405.8 сая төгрөгөөр торгож, 202 хүнийг баривчлуулах, 597 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 61 хүнийг баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 7116 буюу 16.3 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 10 буюу 1.6 хувиар, баривчлуулсан шийтгэл 265 буюу 56.7 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Архангай аймагт нийт 302 хүн саатуулагдан, 102 эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос саатуулсан хүн 114 буюу 27.4 хувиар, эрүүлжүүлэгдсэн хүн 101 буюу 49.8 хувиар тус тус буурсан байна.



Зургаа. Дүгнэлт.

Архангай аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 3027 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1121 буюу 37.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1906 буюу 63.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 102 буюу 3.5 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 64 буюу 3.5 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 38 буюу 3.5 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн онд нийт 447 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 50 буюу 12.6 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 62.6 хувь бөгөөд 5.6 нэгжээр буурсан байна.

Нийт гэмт хэргийн 185 буюу 41.4 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 125 буюу 28.0 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 74 буюу 16.6 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 16.7 хувиар, Хүчиндэх 50.0 хувиар, Дээрэмдэх 5.0 дахин, Залилах 90.6, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3.1 дахин тус тус өсөж, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3.8, Хулгайлах 21.4, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 33.3, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 25.0, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 39.3 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 130 буюу 29.1 хувь нь согтуугаар, 37 буюу 8.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 20 буюу 4.5 хувь нь бүлэглэн, 37 буюу 8.3 хувь нь хүүхэд оролцож, 36 буюу 8.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 336 буюу 75.1 хувь нь Даваа-Баасан гарагт, 261 буюу 58.3 хувь нь 22:00-06:00, 06:00-14:00 цагуудад, 342 буюу 76.5% нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн сумдад гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 236 буюу 66.2 хувь нь малчин болон тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 222 буюу 62.3 хувь нь 25-39 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 3393.9 сая төгрөгийн хохирлын 2486.0 сая төгрөг буюу 73.2 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 2000.2 сая төгрөг буюу 2.4 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 1814.3 сая төгрөг буюу 3.7 дахин тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 31224 буюу 83.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 1727 буюу 4.6 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 206 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 73 буюу 0.2 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 2663 буюу 7.1 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---

3.2. БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Баян-Өлгий аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 3493 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 903 буюу 25.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2590 буюу 74.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 94 буюу 2.8 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 144 буюу 5.9 хувиар тус тус өссөн бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 50 буюу 5.2 хувиар буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 446 буюу 52.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 402 буюу 47.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 7 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2213 буюу 86.6 хувийг зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн, 291 буюу 11.4 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзаж, 50 буюу 2.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 447 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 40 буюу 9.8 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 3.6 хувийг эзэлж байна.


1.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 323 буюу 72.3 хувь нь хөнгөн, 124 буюу 27.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 6.6, хүнд хэрэг 19.2 хувиар тус тус өссөн байна.





1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.5. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алтай	6	5	-1	-16.7	8	Дэлүүн	12	20	8	66.7
2	Алтанцөгц	10	3	-7	-70.0	9	Ногооннуур	9	18	9	2.0 дах
3	Баяннуур	12	9	-3	-25.0	10	Өлгий	279	271	-8	-2.9
4	Булган	6	9	3	50.0	11	Сагсай	13	22	9	69.2
5	Буянт	15	15	-	0.0	12	Толбо	6	25	19	4.2 дах
6	Цэнгэл	18	29	11	61.1	13	Улаанхус	11	11	-	0.0
7	Бугат	10	10	-	0.0						

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	3	-	-	0.0
	Үүнээс: Хүнийг алах	1	-	-	0.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	106	119	12.3	26.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	4	-	-	0.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	12	11	-8.3	2.5
	Үүнээс: Хүчиндэх	9	11	22.2	2.5
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	6	7	16.7	1.6
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	-	2	-	0.4
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2	-	-	0.0
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	-	-	0.0
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	223	198	-11.2	44.3
	Үүнээс: Хулгайлах	68	89	30.9	19.9
	Дээрэмдэх	3	1	-66.7	0.2
	Залилах	105	72	-31.4	16.1
	Мал хулгайлах	9	20	2.2 дах	4.5
9	Эдийн засгийн гэмт хэрэг	8	8	0.0	1.8
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	-	-	0.0
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	0.9
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	14	24	71.4	5.4
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	9	11	22.2	2.5
14	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.2
15	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	3	-25.0	0.7



16	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	9	58	6.4 дах	13.0
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	9	58	6.4 дах	13.0
17	Цэргийн гэмт хэрэг	1	1	0.0	0.2

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 75 буюу 16.8 хувь нь даваа гарагт, 78 буюу 17.4 хувь нь мягмар гарагт, 71 буюу 15.9 хувь нь лхагва гарагт, 64 буюу 14.3 хувь нь пүрэв гарагт, 61 буюу 13.6 хувь нь баасан гарагт, 55 буюу 12.3 хувь нь бямба гарагт, 43 буюу 9.6 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 95 буюу 21.3 хувь нь 06:00-14:00 цагт, 133 буюу 29.8 хувь нь 14:00-19:00 цагт, 76 буюу 17.0 хувь нь 19:00-22:00 цагт, 143 буюу 32.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00			2	1				3
01:00	5	7	2	5	3	5	3	30
02:00		2	3	4	3	3	4	19
03:00		4	2	3		5	2	16
04:00		2	2					4
05:00	2				2		2	6
06:00	1	2			1			4
07:00	2	1	1		1		1	6
08:00					1	1		2
09:00			1					1
10:00	5	3	8		4	6	1	27
11:00	3	1	2	4	3	3		16
12:00	1	2	2		2			7
13:00	4	8	1	7	6	3	3	32
14:00	7	3	7	4	4	4	1	30
15:00	1	4	4	1	1	1	2	14
16:00	11	3	10	6	3	2	7	42
17:00	5	8	5	3	8	7	2	38
18:00	1	1		1	4	1	1	9
19:00	6	9	6	7	4	3	2	37
20:00	9	7	3	8	4	2	3	36
21:00			1			1	1	3
22:00	3	5	3	3	3	1	4	22
23:00	9	6	6	7	4	7	4	43
Нийт	75	78	71	64	61	55	43	447

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 142 буюу 31.8 хувь нь гэр орон сууцанд, 33 буюу 7.4 хувь нь гудамж талбайд, 42 буюу 9.4 хувь нь олон нийтийн газарт, 8 буюу 1.8 хувь нь нийтийн тээвэрт, 22 буюу 4.9 хувь нь төрийн байгууллагад, 8 буюу 1.8 хувь нь төрийн бус байгууллагад, 19 буюу 4.3 хувь нь аж ахуйн нэгжид, 61 буюу 13.6 хувь нь авто замд, 112 буюу 25.1 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 97 буюу 21.7 хувь нь согтуугаар, 51 буюу 11.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 36 буюу 8.0 хувь нь бүлэглэн, 35 буюу 7.8 хувь нь хүүхэд оролцож, 41 буюу 9.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 69 буюу 15.4 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 610 хэрэгт хэрэг бүртгэлт, 111 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 721 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 164 урьд оны үлдэгдэл хэрэг, 537 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 20 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 564 буюу 78.2 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 174 буюу 30.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 344 буюу 61.0 хувийг шүүхэд шилжүүлж;
- 11 буюу 2.0 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 32 буюу 5.7 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 3 буюу 0.5 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 78.2 хувь, хуулийн анхны хугацаанд 97.0 хувийг шийдвэрлэж 6 хүнд холбогдох 156 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Баян-Өлгий аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 180 буюу 40.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 74.5 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.3 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 11.9 нэгжээр их байна.



Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 345 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 4 хэрэг буюу 1.1 хувиар, 257 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 2 буюу 0.8 хувиар тус тус буурсан байна.



Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 403 хүн шалгагдсан нь өмнөх оноос 8.6 хувиар өссөн.

Яллагдагчдын 358 буюу 88.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 6.2 хувиар, 45 буюу 11.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 32.4 хувиар тус тус өсөж, 43 буюу 10.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 24.6 хувиар буурсан байна.


3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 423 иргэн хохирч, 13 хүн нас барж, 151 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 17 буюу 4.2 хувиар, нас барсан хүн 5 буюу 62.5 хувиар, гэмтсэн хүн 29 буюу 23.8 хувиар тус тус өссөн.





4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1623.0 сая төгрөгийн хохирлын 816.4 сая төгрөг буюу 50.3 хувийг нөхөн төлүүлж, 69.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 726.1 сая төгрөг буюу 80.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 241.3 сая төгрөг буюу 42.0 хувиар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 32.5 сая төгрөг буюу 31.8 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Баян-Өлгий аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 19943 зөрчил шалгасан нь өмнөх оноос 10349 буюу 34.2 хувиар, 19956 зөрчлийг шийдвэрлэсэн нь 10332 буюу 34.1 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 17801 буюу 89.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 385 буюу 1.9 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 459 буюу 2.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1297 буюу 6.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 18936 иргэн, 10 хуулийн этгээдийг 1177.2 сая төгрөгөөр торгож, 447 хүнийг баривчлуулах, 562 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 10410 буюу 35.5 хувиар, баривчлуулсан шийтгэл 57 буюу 11.3 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 125 буюу 28.6 хувиар өссөн байна.

2024 онд Баян-Өлгий аймагт нийт 360 хүн саатуулсан нь өмнөх оноос 22 буюу 6.5 хувиар өссөн байна.



Зургаа. Дүгнэлт.

Тус аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээллээс үзэхэд сүүлийн 3 жил (2022-2024)-д тогтмол буюу жилд дунджаар 35.7 хувиар өссөн ба цаашид ч мөн өсөх төлөв ажиглагдаж байна. Мөн аймагт 2024 онд 447 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 40 буюу 9.8 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 3.6 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн онд бүртгэгдсэн гэмт хэргийн 44.3 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 26.6 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 13.0 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг тус тус эзэлж, нийт гэмт хэргийн 60.6 хувь нь Өлгий, 6.5 хувь нь Цэнгэл, 5.6 хувь нь Толбо, 4.9 хувь нь Сагсай, 4.5 хувь нь Дэлүүн буюу хүн ам ихээр суурьшсан сумдад үйлдэгджээ.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс “Хулгайлах” гэмт хэрэг өмнөх оноос 30.9 хувиар өссөн байх тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сайн дурын холбоо болон теле-камерын хяналтыг ашиглах, явган болон авто эргүүлийг тогтмол ажиллуулах шаардлагатай байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 78.0 хувь нь Даваа-Баасан гарагт, 61.8 хувь нь 14:00-19:00, 22:00-06:00 цаг, 48.6 хувь нь гэр орон сууц, олон нийтийн газар, гудамж талбайд үйлдэгдсэн байх тул тухайн цаг хугацаа, байршлуудад хяналт тавих эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, иргэд олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

Нийт гэмт хэргийн 21.7 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байх тул Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх, архи, согтууруулах ундааг худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж, ахуй нэгжийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, архины хор уршгийг сурталчлах олон талт нөлөөллийн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх нь энэ төрлийн гэмт хэргийг бууруулахад үр дүнтэй.

---oooOooo---

3.3. БАЯНХОНГОР АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Баянхонгор аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 4506 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1532 буюу 34.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2974 буюу 66.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 219 буюу 5.1 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 293 буюу 23.6 хувиар тус тус өссөн бол зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 73 буюу 2.4 хувиар буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 570 буюу 38.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 892 буюу 60.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 6 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2450 буюу 83.9 хувийг зөрчлийн хэрэг нээж, 270 буюу 9.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 202 буюу 6.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 577 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 182 буюу 46.1 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.6 хувийг эзэлж байна.

1.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 454 буюу 78.7 хувь нь хөнгөн, 123 буюу 21.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 45.5 хувиар, хүнд хэрэг 48.2 хувиар тус тус өссөн байна.





1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.5. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Баян-Овоо	8	10	2	25.0	11	Галуут	13	19	6	46.2
2	Баацагаан	1	1	0	0.0	12	Гурванбулаг	14	13	-1	-7.1
3	Баянбулаг	27	19	-8	-29.6	13	Жаргалант	3	8	5	2.7 дах
4	Баянговь	11	20	9	81.8	14	Жинст	6	5	-1	-16.7
5	Баянлиг	5	2	-3	-60.0	15	Заг	8	14	6	75.0
6	Баян-Өндөр	3	3	0	0.0	16	Өлзийт	9	3	-6	-66.7
7	Баянцагаан	2	4	2	2.0 дах	17	Хүрээмарал	10	18	8	80.0
8	Богд	3	8	5	2.7 дах	18	Шинэжинст	7	7	0	0.0
9	Бөмбөгөр	6	5	-1	-16.7	19	Эрдэнэцогт	3	10	7	3.3 дах
10	Бууцагаан	46	50	4	8.7	20	Баянхонгор	210	358	148	70.5

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	7	15	2.1 дах	2.6
	Үүнээс: Хүнийг алах	5	4	-20.0	0.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	138	149	8.0	25.8
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	7	3.5 дах	1.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	22	29.4	3.8
	Үүнээс: Хүчиндэх	14	18	28.6	3.1
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	3	3	0.0	0.5
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		6		1.0
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	176	280	59.1	48.5
6	Хулгайлах	63	63	0.0	10.9
	Дээрэмдэх	4	7	75.0	1.2
	Залилах	46	146	3.2 дах	25.3
	Малын хулгай	33	22	-33.3	3.8



7	Эдийн засгийн гэмт хэрэг	2	5	2.5 дах	1.0
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.7
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.2
10	Авлигын гэмт хэрэг	1	1	0.0	0.2
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.7
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	13	10	-23.1	1.7
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	26	77	3.0 дах	13.3
13	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	26	77	3.0 дах	13.3

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 100 буюу 17.3 хувь нь даваа гарагт, 91 буюу 15.8 хувь нь мягмар гарагт, 88 буюу 15.2 хувь нь лхагва гарагт, 86 буюу 14.9 хувь нь пүрэв гарагт, 73 буюу 12.7 хувь нь баасан гарагт, 67 буюу 11.6 хувь нь бямба гарагт, 72 буюу 12.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 118 буюу 20.4 хувь нь 06:00-14:00 цагт, 191 буюу 33.1 хувь нь 14:00-19:00 цагт, 88 буюу 15.3 хувь нь 19:00-22:00 цагт, 180 буюу 31.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	1				2		2	5
01:00	5	7	6	7	5	5	8	43
02:00	3	7	5	6	5	2	5	33
03:00	4	2	3	2	3		1	15
04:00	2	1	5		2	1	1	12
05:00				1	1	1	3	6
06:00		1						1
07:00	2			2	1	1	2	8
08:00	1		4	2			1	8
09:00		1	2		1			4
10:00	6	3	2	2	4	3	1	21
11:00	1	5	3	1	2	5	3	20
12:00	2	5	3	1	4	3	3	21
13:00	5	2	6	4	6	7	5	35
14:00	8	6	12	6	5	9	6	52
15:00	2	8	4	4	1	4	2	25
16:00	14	8	5	8	5	6	3	49
17:00	11	7	5	9	11	2	5	50
18:00	3	3	3	2		3	1	15
19:00	7	5	1	6	3	3	4	29
20:00	6	12	8	7	5	4	5	47
21:00	4	1	2	2		2	1	12
22:00	7	3	2	10	4	4	5	35
23:00	6	4	7	4	3	2	5	31
Нийт	100	91	88	86	73	67	72	577




Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 118 буюу 20.5 хувь нь гэр орон сууцанд, 86 буюу 14.9 хувь нь гудамж талбайд, 53 буюу 9.2 хувь нь олон нийтийн газарт, 13 буюу 2.2 хувь нь төрийн байгууллагад, 4 буюу 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 19 буюу 3.3 хувь нь аж ахуйн нэгжид, 74 буюу 12.8 хувь нь авто замд, 210 буюу 36.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 177 буюу 30.7 хувь нь согтуугаар, 88 буюу 15.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 34 буюу 5.9 хувь нь бүлэглэн, 21 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 28 буюу 4.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 141 буюу 24.4 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 954 хэрэгт хэрэг бүртгэлт, 131 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1085 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 207 урьд оны үлдэгдэл хэрэг, 874 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 1, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 3 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 771 буюу 71.1 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:


-415 буюу 53.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-312 буюу 40.5 хувийг шүүхэд шилжүүлж;

-1 буюу 0.1 хувийг хэрэгсэхгүй болгож;

-42 буюу 5.4 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;

-1 буюу 0.1 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 71.1 хувь, хуулийн анхны хугацаанд 77.2 хувийг шийдвэрлэж, 15 хүнд холбогдох 322 хэргийн үлдэгдэлтэй байна.






2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Баянхонгор аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 235 буюу 40.7 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 52.9 хувьтай байгаа нь өмнөх оноос 10.1 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 9.7 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 456 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 208 хэрэг буюу 83.9 хувиар, 241 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 135 буюу 2.3 дахин тус тус өссөн байна.



Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 370 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 23.3 хувиар өссөн.

Яллагдагчдын 295 буюу 79.7 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 10.1 хувиар, 75 буюу 20.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 2.3 дахин тус тус өсөж, 22 буюу 5.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 47.6 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 534 иргэн, 1 хуулийн этгээд хохирч, 23 хүн нас барж, 181 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 125 буюу 30.6 хувиар, нас барсан хүн 9 буюу 64.3 хувиар, гэмтсэн хүн 11 буюу 6.5 хувиар тус тус өссөн.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2393.2 сая төгрөгийн хохирлын 625.6 сая төгрөг буюу 26.1 хувийг нөхөн төлүүлж, 57.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 699.2 сая төгрөг буюу 22.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 160.7 сая төгрөг буюу 20.4 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 32.8 сая төгрөг буюу 36.3 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил.

Баянхонгор аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 30768 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 4618 буюу 13.1 хувиар, 30690 зөрчлийг шийдвэрлэсэн нь 4544 буюу 12.9 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 26711 буюу 86.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1596 буюу 5.2 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 258 буюу 0.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2203 буюу 7.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 29598 иргэн, 6 хуулийн этгээдийг 1211.7 сая төгрөгөөр торгож, 408 хүнийг баривчлуулах, 389 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 288 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг



торгосон шийтгэл 4353 буюу 12.8 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 256 буюу 39.7 хувиар, баривчлуулсан шийтгэл 228 буюу 35.8 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Баянхонгор аймагт нийт 111 хүн эрүүлжүүлж, 430 хүнийг саатуулсан нь эрүүлжүүлэгдсэн хүн өмнөх оны мөн үеийн түвшинд, саатуулсан хүн 7 буюу 1.7 хувиар өссөн байна.

Зургаа. Дүгнэлт.

Баянхонгор аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 4506 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1468 буюу 32.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2922 буюу 64.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 5.1 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 23.2 хувиар тус тус өссөн бол зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2.4 хувиар буурсан байна.

Өнгөрсөн онд нийт 577 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 182 буюу 46.1 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 52.9 хувь бөгөөд 10.0 нэгжээр өссөн байна.

Нийт гэмт хэргийн 280 буюу 48.5 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 149 буюу 25.8 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 77 буюу 13.3 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 3.5 дахин, Залилах 3.2 дахин, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 3 дахин, Эдийн засгийн эсрэг 2.5 дахин, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 8.0, Хүчиндэх 28.6, Дээрэмдэх 75.0 хувиар тус тус өсөж, Хүнийг алах 20.0, Мал хулгайлах 33.3, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг 50.0, Хүрээлэн байгаа орчны эсрэг 23.1 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн 177 буюу 30.7 хувь нь согтуугаар, 88 буюу 15.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 34 буюу 5.9 хувь нь бүлэглэн, 21 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 28 буюу 4.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 438 буюу 75.9 хувь нь Даваа-Баасан гарагт, 371 буюу 64.3 хувь нь 14:00-19:00, 22:00-06:00 цагуудад, 492 буюу 85.3% нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн сумдад гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 158 буюу 42.7 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 199 буюу 67.5 хувь нь 18-34 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2393.1 сая төгрөгийн хохирлын 625.6 сая төгрөг буюу 26.1 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 160.7 сая төгрөг буюу 20.4 хувиар буурч бусад аймгийн цагдаагийн газраас хамгийн бага үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 86.8 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 5.2 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 0.8 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 7.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---

3.4. БУЛГАН АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Булган аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 2600 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 752 буюу 28.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1848 буюу 71.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 237 буюу 8.4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 54 буюу 6.7 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 183 буюу 9.0 хувиар тус тус буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 388 буюу 53.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 328 буюу 45.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 4 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1708 буюу 93.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 92 буюу 5.0 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 35 буюу 1.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 411 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 19 буюу 4.8 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 3.3 хувийг эзэлж байна.


1.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 309 буюу 75.2 хувь нь хөнгөн, 102 буюу 24.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 2.3, хүнд хэрэг 13.3 хувиар тус тус өссөн байна.





1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.5. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баян-Агт	11	9	-2	-18.2
2	Баяннуур	8	8		0.0
3	Бугат	17	26	9	52.9
4	Булган	121	137	16	13.2
5	Бүрэг хангай	16	14	-2	-12.5
6	Гурванбулаг	17	16	-1	-5.9
7	Дашинчилэн	11	19	8	72.7
8	Могод	16	8	-8	-50.0
9	Орхон	40	29	-11	-27.5
10	Рашаант	12	13	1	8.3
11	Сайхан	34	14	-20	-58.8
12	Сэлэнгэ	17	19	2	11.8
13	Тэшиг	7	10	3	42.9
14	Хангал	26	32	6	23.1
15	Хишигөндөр	14	13	-1	-7.1
16	Хутаг-Өндөр	25	44	19	76.0

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	9	10	11.1	2.4
	Үүнээс: Хүнийг алах	6	2	-66.7	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	105	130	23.8	31.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	2	-33.6	0.5
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	15	19	26.7	4.6
	Үүнээс: Хүчиндэх	13	14	7.7	3.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	5	5	0.0	1.2
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.5
6	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		2		0.5
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	186	124	-33.3	30.2
	Үүнээс: Хулгайлах	77	46	-40.3	11.2
	Дээрэмдэх		1		0.2
	Залилах	36	46	27.8	11.2



8	Эдийн засгийн гэмт хэрэг		2		0.5
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5			0.0
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.5
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	8	2.0 дах	1.9
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	35	36	2.9	8.8
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			0.0
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	25	71	2.8 дах	17.3
14	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	25	71	2.8 дах	17.3

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 62 буюу 15.1 хувь нь даваа гарагт, 66 буюу 16.1 хувь нь мягмар гарагт, 57 буюу 13.8 хувь нь лхагва гарагт, 47 буюу 11.4 хувь нь пүрэв гарагт, 57 буюу 13.9 хувь нь баасан гарагт, 64 буюу 15.6 хувь нь бямба гарагт, 58 буюу 14.1 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 93 буюу 22.6 хувь нь 06:00-14:00 цагт, 135 буюу 32.9 хувь нь 14:00-19:00 цагт, 69 буюу 16.8 хувь нь 19:00-22:00 цагт, 114 буюу 27.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00							1	1
01:00	5		4	4	1	2	3	19
02:00	3	1	1	4	4	3	4	20
03:00	3	1		2	1	1	2	10
04:00	2	2	1	1	1		3	10
05:00	1	2		1	1		2	7
06:00			1			1		2
07:00		1	3		2		2	8
08:00			1	1		1		3
09:00		1	3		2	2	1	9
10:00	6	6	1	1	2	4	3	23
11:00	1	3	2			4	2	12
12:00	1	1		1	5	3	1	12
13:00	3	6	3	5	3	3	1	24
14:00	6	1	1	2	5	6	2	23
15:00		2	2	1	1		2	8
16:00	9	4	11	6	8	7	9	54
17:00	4	8	4	2	2	5	4	29
18:00	3	5	3	4	2	3	1	21
19:00	5	5	3	3	6	6	5	33
20:00	4	5	2	4	4	4	5	28
21:00		2	3	1	1		1	8
22:00	3	5	4	2	2	4	3	23
23:00	3	5	4	2	4	5	1	24
Нийт	62	66	57	47	57	64	58	411

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 136 буюу 33.1 хувь нь гэр орон сууцанд, 21 буюу 5.1 хувь нь гудамж талбайд, 10 буюу 2.4 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 4 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.2 хувь нь төрийн бус байгууллагад, 8 буюу 2.0 хувь нь аж ахуйн нэгжид, 64 буюу 15.6 хувь нь авто замд, 166 буюу 40.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 80 буюу 19.5 хувь нь согтуугаар, 44 буюу 10.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 23 буюу 5.6 хувь нь бүлэглэн, 10 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 39 буюу 9.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 40 буюу 9.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 721 хэрэгт хэрэг бүртгэлт, 52 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 773 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 306 урьд оны үлдэгдэл хэрэг, 441 энэ оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 26 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 500 буюу 64.7 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:


-211 буюу 42.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-281 буюу 56.2 хувийг шүүхэд шилжүүлж;

-2 буюу 0.4 хувийг хэрэгсэхгүй болгож;

-5 буюу 1.0 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;

-1 буюу 0.2 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 64.7 хувь, хуулийн анхны хугацаанд 490 буюу 98.0 хувийг шийдвэрлэж 5 хүнд холбогдох 280 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Булган аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 124 буюу 30.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 60.1 хувьтай байгаа нь өмнөх оноос 4.0 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 2.5 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 368 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 31 хэрэг буюу 9.2 хувиар, 221 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 32 буюу 16.9 хувиар тус тус өссөн байна.



Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 298 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 1.0 хувиар өссөн.

Яллагдагчдын 37 буюу 12.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 23.3 хувиар өсөж, 261 буюу 87.6 хувь нь эрэгтэй хүн эзэлж байгаа нь 1.5 хувиар буурч, 21 буюу 7.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь ижил түвшинд байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 379 иргэн хохирч, 22 хүн нас барж, 157 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 19 буюу 4.8 хувиар буурч, нас барсан хүн 7 буюу 46.7 хувиар, гэмтсэн хүн 23 буюу 17.2 хувиар тус тус өссөн.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2159.5 сая төгрөгийн хохирлын 1338.2 сая төгрөг буюу 62.0 хувийг нөхөн төлүүлж, 298.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 418.4 сая төгрөг буюу 16.2 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 504.4 сая төгрөг буюу 60.5 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 114.7 сая төгрөг буюу 62.5 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Булган аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 40460 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 2507 буюу 6.6 хувиар, 40435 зөрчлийг шийдвэрлэсэн нь 2542 буюу 6.7 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 37016 буюу 91.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1353 буюу 3.3 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 201 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 14 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1876 буюу 4.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.





Зөрчил гаргасан 39511 иргэн, 2 хуулийн этгээдийг 1368.3 сая төгрөгөөр торгож, 222 хүнийг баривчлуулж, 648 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассагч, 51 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассагч шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос хуулийн этгээд 1 буюу 2.0 дахин, иргэнийг торгосон шийтгэл 2639 буюу 7.2 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 82 буюу 14.5 хувиар тус тус өсөж, баривчлуулсан шийтгэл 232 буюу 51.1 хувиар буурсан байна.

2024 онд Булган аймагт нийт 122 хүн эрүүлжүүлэгдэж, 212 хүн саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 21 буюу 20.8 хувиар өсөж, саатуулсан хүн 55 буюу 20.6 хувиар буурсан байна.

Зургаа. Дүгнэлт.

Булган аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 2600 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 752 буюу 28.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1848 буюу 71.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 237 буюу 8.4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 54 буюу 6.7 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 183 буюу 9.0 хувиар буурсан байна.

Тус аймгийн цагдаагийн газарт 411 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 19 буюу 4.8 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 60.1 хувь бөгөөд 4.0 нэгжээр өссөн.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 130 буюу 31.6 хувь нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 124 буюу 30.2 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, 71 буюу 17.3 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2.8 дахин, хүүхдийн эсрэг, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 2 дахин, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, хүчиндэх, залилах, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2.9-27.8 хувиар тус тус өсөж, хүнийг алах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, өмчлөх эрхийн эсрэг, хулгайлах гэмт хэрэг 33.3-66.7 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 80 буюу 19.5 хувь нь согтуугаар, 44 буюу 10.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 23 буюу 5.6 хувь нь бүлэглэн, 10 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 39 буюу 9.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 130 буюу 31.6 хувь нь Мягмар, Бямба гарагт, 135 буюу 32.9 хувь нь 19:00-22:00 цагуудад, 389 буюу 94.6 хувь нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн Хутаг-Өндөр, Дашинчилэн, Бугат суманд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 139 буюу 46.6 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 80 буюу 26.8 хувь нь 30-44 насны хөдөлмөрлөх насны хүмүүс байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 37016 буюу 91.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 1353 буюу 3.3 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 201 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 14 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1876 буюу 4.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---0000000---

3.5. ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Говь-Алтай аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 1999 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 622 буюу 31.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1377 буюу 68.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 279 буюу 12.2 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 392 буюу 22.2 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 113 буюу 22.2 хувиар өссөн байна.


2024 онд 1139 хэрэгт хэрэг бүртгэлт, 123 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1262 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 339 урьд оны үлдэгдэл хэрэг, 904 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 19 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 885 буюу 70.1 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 390 буюу 44.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 429 буюу 48.5 хувийг шүүхэд шилжүүлж;
- 9 буюу 1.0 хувийг хэрэгсэхгүй болгож;

-57 буюу 6.4 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн, нийт шалгасан хэргийн 70.1 хувь, хуулийн анхны хугацаанд 93.2 хувийг шийдвэрлэж, 18 хүнд холбогдох 387 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Дорнод аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 198 буюу 30.7 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 67.0 хувьтай байгаа нь өмнөх оноос 4.7 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 4.4 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 522 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 92 хэрэг буюу 21.4 хувиар, 350 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 82 буюу 30.6 хувиар тус тус өссөн байна.



Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 522 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 18.4 хувиар өссөн.

Яллагдагчдын 55 буюу 10.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 5.8 хувиар, 467 буюу 89.5 хувь нь эрэгтэй хүн эзэлж байгаа нь 20.1 хувиар тус тус өсөж, 22 буюу 4.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 12.0 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.






Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 608 иргэн, 22 хүн нас барж, 267 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 70 буюу 13.0 хувиар, нас барсан хүн 3 буюу 15.8 хувиар, гэмтсэн хүн 31 буюу 13.1 хувиар тус тус өссөн.

4.2. Учирсан хохирол.



сая төгрөг буюу 89.8 хувиар буурсан байна.




Иргэдэд учирсан 3513.3 сая төгрөгийн хохирлын 2510.1 сая төгрөг буюу 71.4 хувийг нөхөн төлүүлж, 17.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 694.3 сая төгрөг буюу 24.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 590.5 сая төгрөг буюу 30.8 хувиар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 157.7

Тав. Зөрчил.

Дорнод аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 32602 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 1997 буюу 6.5 хувиар, 32278 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1778 буюу 5.8 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 26450 буюу 81.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 4363 буюу 13.4 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 330 буюу 1.0 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1 буюу 0.0 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1458 буюу 4.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 31114 иргэн, 2 хуулийн этгээдийг 1126.3 сая төгрөгөөр торгож, 444 хүнийг баривчлуулж, 630 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 81 хүнийг баривчлуулж,



тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулсан нь өмнөх оноос тогосон хуулийн этгээд 3 буюу 60.0 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 335 буюу 34.7 хувиар тус тус буурч, иргэнийг торгосон шийтгэл 2024 буюу 7.0 хувиар, баривчлуулсан шийтгэл 4 буюу 0.9 хувиар тус тус өссөн байна.

2024 онд Дорнод аймагт нийт 403 хүн эрүүлжүүлэгдэж, 567 хүн саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 1072 буюу 72.7 хувиар буурч, саатуулсан хүн 149 буюу 35.6 хувиар өссөн байна.

Зургаа. Дүгнэлт.

Дорнод аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 4232 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1529 буюу 36.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2703 буюу 63.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 670 буюу 18.8 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 277 буюу 22.1 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 393 буюу 17.0 хувиар тус тус өссөн байна.

Тус аймгийн цагдаагийн газарт 646 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 113 буюу 21.2 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 67.0 хувь бөгөөд 4.7 нэгжээр өссөн.

Нийт гэмт хэргийн 247 буюу 38.2 хувийг өмчлөх эрхийн эсрэг, 219 буюу 33.9 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 94 буюу 14.6 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3.1 дахин, хүнийг алах 2.7 дахин, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, хүчиндэх, хулгайлах, залилах, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг 2.5-40.0 хувиар өсөж, дээрэмдэх, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 7.7-55.6 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 277 буюу 42.9 хувь нь согтуугаар, 60 буюу 9.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 27 буюу 4.2 хувь нь бүлэглэн, 19 буюу 2.9 хувь нь хүүхэд оролцож, 40 буюу 6.2 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл, 69 буюу 10.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 217 буюу 33.6 хувь нь даваа, лхагва гарагт, 265 буюу 41.0 хувь нь 22:00-06:00 цагуудад, 515 буюу 79.7 хувь нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлж, Гурван загал, Матад, Сэргэлэн сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 343 буюу 65.7 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 175 буюу 33.5 хувь нь 25-34 насны сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, залуучууд байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 26450 буюу 81.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 4363 буюу 13.4 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 330 буюу 1.0 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1 буюу 0.0 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1458 буюу 4.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---

3.10. ДУНДГОВЬ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг


1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Дундговь аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 1826 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 788 буюу 43.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1038 буюу 56.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 163 буюу 9.8 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 153 буюу 24.1 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 10 буюу 1.0 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 294 буюу 39.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 433 буюу 58.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 12 буюу 1.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 897 буюу 87.3 хувийг зөрчлийн хэрэг нээж, 107 буюу 10.4 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 23 буюу 2.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 282 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 36 буюу 14.6 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.2 хувийг эзэлж байна.





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Адаацаг	17	5	-12	-70.6
2	Баянжаргалан	7	10	3	42.9
3	Говь-угтаал	3	9	6	3.0 дах
4	Гурвансайхан	21	9	-12	-57.1
5	Дэлгэрхангай	7	8	1	14.3
6	Дэлгэрцогт	10	10		
7	Дэрэн	9	8	-1	-11.1
8	Луус	9	7	-2	-22.2
9	Өлзийт	8	16	8	2.0 дах
10	Өндөршил	4	8	4	2.0 дах
11	Сайнцагаан	113	156	43	38.1
12	Сайхан овоо	6	6	0	0.0
13	Хулд	13	11	-2	-15.4
14	Цагаандэлгэр	4	1	-3	-75.0
15	Эрдэнэдалай	15	18	3	20.0

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 236 буюу 83.7 хувь нь хөнгөн, 46 буюу 16.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 8.8, хүнд хэрэг 58.6 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	3	6	2.0 дах	2.1
	Үүнээс: Хүнийг алах	1	5	5.0 дах	1.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	117	155	32.5	55.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	4	2.0 дах	1.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	6	6	0.0	2.1
	Үүнээс: Хүчиндэх	3	6	2.0 дах	2.1



4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		2		0.7
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	85	56	-34.1	19.9
5	Үүнээс: Хулгайлах	40	16	-60.0	5.7
	Дээрэмдэх	3	2	-33.3	0.7
	Залилах	32	26	-18.8	9.2
6	Эдийн засгийн гэмт хэрэг	2	2	0.0	0.7
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2			
8	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	5	66.7	1.8
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг		2		0.7
10	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.4
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	28	47	67.9	16.7
11	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	28	47	67.9	16.7

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 41 буюу 14.5 хувь нь даваа гарагт, 41 буюу 14.5 хувь нь мягмар гарагт, 42 буюу 14.9 хувь нь лхагва гарагт, 46 буюу 16.3 хувь нь пүрэв гарагт, 40 буюу 14.2 хувь нь баасан гарагт, 43 буюу 15.2 хувь нь бямба гарагт, 29 буюу 10.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 50 буюу 17.7 хувь нь 06:00-14:00 цагт, 87 буюу 30.9 хувь нь 14:00-19:00 цагт, 58 буюу 20.6 хувь нь 19:00-22:00 цагт, 87 буюу 30.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00		1	2			1		4
01:00	1	1	3	4	4	2	3	18
02:00	1	5	1	3		1	1	12
03:00	1	2		1	1	2	1	8
04:00			1	2	1	2		6
05:00	1		1		2	1		5
06:00						1		1
07:00				2	1	2		5
08:00	1					1	1	3
09:00		2	2	1				5
10:00	1	2	1					4
11:00	3	2	2	1	3	1		12
12:00	3	1	2	1	1			8
13:00	5		1	2	1	1	2	12
14:00	4	2	2	5	2	4	2	21
15:00	1	1	4		1		2	9
16:00	4	3	2	1	4	1	4	19
17:00	2	6	6	5	5	2	1	27
18:00	2			4		2	3	11
19:00	4	4	3	5	3	7	3	29
20:00	3	5		5	2	6		21
21:00		1	1		2	1	3	8
22:00	1		3		2	2		8
23:00	3	3	5	4	5	3	3	26
Нийт	41	41	42	46	40	43	29	282



Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 105 буюу 37.2 хувь нь гэр орон сууцанд, 25 буюу 8.9 хувь нь гудамж талбайд, 13 буюу 4.6 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 9 буюу 3.2 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 14 буюу 5.0 хувь нь аж ахуйн нэгжид, 41 буюу 14.5 хувь нь авто замд, 73 буюу 25.9 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 127 буюу 45.0 хувь нь согтуугаар, 24 буюу 8.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 5 буюу 1.8 хувь нь бүлэглэн, 6 буюу 2.1 хувь нь хүүхэд оролцож, 42 буюу 14.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 28 буюу 9.9 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 426 хэрэгт хэрэг бүртгэлт, 94 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 520 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 120 урьд оны үлдэгдэл хэрэг, 376 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 2, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 22 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 395 буюу 76.0 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 138 буюу 34.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 241 буюу 61.0 хувийг шүүхэд шилжүүлж;
- 3 буюу 0.8 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 10 буюу 2.5 хувийг эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 3 буюу 0.8 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 76.0 хувь, хуулийн анхны хугацаанд 81.5 хувийг шийдвэрлэж, 12 хүнд холбогдох 123 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Дундговь аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 72 буюу 25.5 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 70.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.5 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 7.8 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 199 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 18 хэрэг буюу 9.9 хувиар, 140 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 19 буюу 15.7 хувиар тус тус өссөн байна.



Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 234 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 18.8 хувиар өссөн. Яллагдагчдын 211 буюу 90.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 21.3 хувиар өсөж, 23 буюу 9.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь мөн үеийн түвшинд, 6 буюу 2.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 33.3 хувиар буурсан байна.




3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 263 иргэн хохирч, 6 хүн нас барж, 181 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 7 буюу 2.7 хувиар, гэмтсэн хүн 40 буюу 28.4 хувиар тус тус өсөж, нас барсан хүн 7 буюу 58.3 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.



Иргэнд учирсан 808.5 сая төгрөгийн хохирлын 530.7 сая төгрөг буюу 65.6 хувийг нөхөн төлүүлж, 8.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой харьцуулахад хохирлын хэмжээ 248.7 сая төгрөг буюу 23.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 43.2 сая төгрөг буюу 7.5 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 26.8 сая төгрөг буюу 77.0 хувиар тус тус буурсан байна.


Тав. Зөрчил.

Дундговь аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 22699 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 602 буюу 2.7 хувиар, 22677 зөрчлийг шийдвэрлэсэн нь 611 буюу 2.8 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 18640 буюу 82.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 686 буюу 3.0 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 100 буюу 0.4



хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 3273 буюу 14.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 22184 иргэн, 10 хуулийн этгээдийг 1058.2 сая төгрөгөөр торгож, 120 хүнийг баривчилуулж, 335 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 28 хүний баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх онтой харьцуулахад иргэнийг торгосон шийтгэл 677 буюу 3.1 хувиар өсөж, баривчлуулсан шийтгэл 89 буюу 42.6 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 9 буюу 2.6 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Дундговь аймагт нийт 59 хүн саатуулагдаж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн зөрчил гаргасны улмаас 37 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад саатуулагдсан хүн 20 буюу 25.3 хувиар, эрүүлжүүлэгдсэн хүн 16 буюу 30.2 хувиар тус тус буурсан байна.

Зургаа. Дүгнэлт.

Дундговь аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 1826 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 788 буюу 43.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1038 буюу 56.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 9.8 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 24.1 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 1.0 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн онд нийт 282 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 36 буюу 14.6 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 70.4 хувьтай байгаа нь 3.5 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт гэмт хэргийн 155 буюу 55.0 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 56 буюу 19.9 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 47 буюу 16.7 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Хүнийг алах 5.0 дахин, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 2.0 дахин, Хүчиндэх 2.0 дахин, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 32.5, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 66.7, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 67.9 хувиар тус тус өсөж, Хулгайлах 60.0, Дээрэмдэх 33.3, Залилах 18.8 хувиар тус тус буурсан байна.



Гэмт хэргийн 127 буюу 45.0 хувь нь согтуугаар, 24 буюу 8.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 5 буюу 1.8 хувь нь бүлэглэн, 6 буюу 2.1 хувь нь хүүхэд оролцож, 42 буюу 14.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 213 буюу 75.5 хувь нь Даваа-Пүрэв, Бямба гарагт, 174 буюу 61.7 хувь нь 14:00-19:00, 22:00-06:00 цагуудад, 203 буюу 71.9% нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн сумдад гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 89 буюу 38.0 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 158 буюу 67.5 хувь нь 18-34 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 808.5 сая төгрөгийн хохирлын 530.7 сая төгрөг буюу 65.6 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 43.2 сая төгрөг буюу 7.5 хувиар буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 82.1 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 3.0 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 0.4 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 14.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---

3.11. ЗАВХАН АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг


1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Завхан аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 1921 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 488 буюу 25.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1433 буюу 74.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 335 буюу 14.8 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 38 буюу 7.2 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 297 буюу 17.2 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 292 буюу 62.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 179 буюу 38.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1332 буюу 93.3 хувийг зөрчлийн хэрэг нээж, 54 буюу 3.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 41 буюу 2.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 285 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 43 буюу 13.1 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.3 хувийг эзэлж байна.





1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алдархаан	15	20	5	33.3	13	Тосонцэнгэл	43	47	4	9.3
2	Асгат	4				14	Түдэвтэй	7	1	-6	-85.7
3	Баянтэс	9				15	Тэлмэн	10	15	5	50.0
4	Баянхайрхан	5	5	0	0.0	16	Тэс	5	1	-4	-80.0
5	Дөрвөлжин	5	8	3	60.0	17	Улиастай	111	100	-11	-9.9
6	Завханмандал	5	10	5	2.0 дах	18	Ургамал	3	5	2	66.7
7	Идэр	18	9	-9	-50.0	19	Цагаанхайрхан	5	2	-3	-60.0
8	Их уул	24	15	-9	-37.5	20	Цагаанчулуут	5	3	-2	-40.0
9	Нөмрөг	5	7	2	40.0	21	Цэцэн уул	3	6	3	2.0 дах
10	Отгон	17	4	-13	-76.5	22	Шилүүстэй	4	6	2	50.0
11	Сантмаргац	10	3	-7	-70.0	23	Эрдэнэхайрхан	4	6	2	50.0
12	Сонгино	8	8	0	0.0	24	Яруу	3	4	1	33.3

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 204 буюу 71.6 хувь нь хөнгөн, 81 буюу 28.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 19.4 хувиар буурч, хүнд хэрэг 8.0 хувиар өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	8	8	0.0	2.8
	Үүнээс: Хүнийг алах	4	6	50.0	2.1
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	103	84	-18.4	29.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	2	-33.3	0.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	12	9	-25.0	3.2
	Үүнээс: Хүчиндэх	8	8	0.0	2.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	5	6	20.0	2.1
	Хүний хувийн ул төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		4		1.4
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	142	102	-28.2	35.8
5	Хулгайлах	52	30	-42.3	10.5
	Залилах	32	35	9.4	12.3
6	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	10	1	-90.0	0.4



7	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.4
8	Авлигын эсрэг гэмт хэрэг		1		0.4
9	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	11	2	-81.8	0.7
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	21	15	-28.6	5.3
11	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	2		-100.0	0.0
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	13	52	4.0 дах	18.0
12	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	13	52	4.0 дах	18.0

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 44 буюу 15.4 хувь нь даваа гарагт, 43 буюу 15.1 хувь нь мягмар гарагт, 39 буюу 13.7 хувь нь лхагва гарагт, 54 буюу 18.9 хувь нь пүрэв гарагт, 36 буюу 12.6 хувь нь баасан гарагт, 28 буюу 9.8 хувь нь бямба гарагт, 41 буюу 14.4 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 72 буюу 25.3 хувь нь 06:00-14:00 цагт, 86 буюу 30.2 хувь нь 14:00-19:00 цагт, 37 буюу 13.0 хувь нь 19:00-22:00 цагт, 90 буюу 31.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	1			1			1	3
01:00	2	1	4	2	4	3	2	18
02:00	3	1	3	3	1	2	5	18
03:00	3	1	2	4	3	3		16
04:00		1			1			2
05:00					2			2
06:00	1			1		1		3
07:00				1		2		3
08:00			2	1				3
09:00	1		1	1		1	1	5
10:00	2	3		1			2	8
11:00	1	2	2	2	4			11
12:00	3	3	1	3	1	2	3	16
13:00	2	5	4	7	2	2	1	23
14:00	4	3	5	2	2	1	2	19
15:00	3	2	1	4	2	1	3	16
16:00	3	3	2	1	1	2	3	15
17:00	4	3	1	8	3	1	3	23
18:00	2	5	1	2	1	1	1	13
19:00	4	3	2	2	1		2	14
20:00	2		2	2	2	1	6	15
21:00	2	1		2	1	2		8
22:00		3	2	3	3		2	13
23:00	1	3	4	1	2	3	4	18
Нийт	44	43	39	54	36	28	41	285

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 77 буюу 27.0 хувь нь гэр орон сууцанд, 17 буюу 6.0 хувь нь гудамж талбайд, 13 буюу 4.6 хувь нь олон нийтийн газарт, 3 буюу 1.1 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 7 буюу 2.5 хувь нь аж ахуйн нэгжид, 52 буюу 18.2 хувь нь авто замд, 115 буюу 40.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 99 буюу 34.7 хувь нь согтуугаар, 18 буюу 6.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 26 буюу 9.1 хувь нь бүлэглэн, 9 буюу 3.2 хувь нь хүүхэд оролцож, 25 буюу 8.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 42 буюу 14.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.




1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 460 хэрэгт хэрэг бүртгэлт, 41 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 501 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 137 урьд оны үлдэгдэл хэрэг, 361 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 3 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 357 буюу 71.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 137 буюу 38.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 198 буюу 55.5 хувийг шүүхэд шилжүүлж;
- 1 буюу 0.3 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 17 буюу 4.8 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;

-4 буюу 1.1 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 71.3 хувь, хуулийн анхны хугацаанд 93.3 хувийг шийдвэрлэж, 12 хүнд холбогдох 145 хэргийн үлдэгдэлтэй байна.






Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Завхан аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 121 буюу 43.9 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 70.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 2.2 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 7.6 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 255 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 11 хэрэг буюу 4.1 хувиар, 179 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 2 буюу 1.1 хувиар тус тус буурсан байна.



Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 237 хүн шалгагдсан нь өмнөх оноос 9.9 хувиар буурсан.

Яллагдагчдын 218 буюу 92.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 9.9 хувиар, 19 буюу 8.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 9.5 хувиар, 14 буюу 5.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 36.4 хувиар тус тус буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 266 иргэн, 2 хуулийн этгээд хохирч, 14 хүн нас барж, 112 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 51 буюу 16.1 хувиар, гэмтсэн хүн 11 буюу 8.9 хувиар хувиар тус тус буурч, нас барсан хүн өмнөх оны түвшинд байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1765.7 сая төгрөгийн хохирлын 1251.5 сая төгрөг буюу 70.9 хувийг нөхөн төлүүлж, 809.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 133.5 сая төгрөг буюу 7.0 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 50.9 сая төгрөг буюу 4.2 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 15.6 сая төгрөг буюу 2.0 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Завхан аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 31185 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 1699 буюу 5.8 хувиар, 31129 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1660 буюу 5.6 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 26427 буюу 84.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 2518 буюу 8.1 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 163 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2077 буюу 6.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.





Зөрчил гаргасан 30454 иргэн, 3 хуулийн этгээдийг 1148.0 сая төгрөгөөр торгож, 168 хүнийг баривчлуулах, 431 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 56 баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулж, 17 хүнийг сургалтад хамруулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 1849 буюу 6.5 хувиар өсөж, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 75 буюу 14.8 хувиар, баривчлуулсан шийтгэл 186 буюу 52.5 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Завхан аймагт нийт 184 хүн саатуулагдсан нь өнгөрсөн оноос 64 буюу 53.3 хувиар өсөж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн зөрчил гаргасан, эрүүлжүүлэгдсэн хүн 28 бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 5 буюу 15.2 хувиар буурсан байна.

Зургаа. Дүгнэлт.

Тус аймагт 2024 онд 285 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 43 буюу 13.1 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 70.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 2.2 нэгжээр өссөн. Сүүлийн 20 жилийн (жилийн дундаж) статистикаар 302, сард 25 гэмт хэрэг үйлдэгджээ.

Нийт гэмт хэргийн 35.8 хувийг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 29.5 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 18.2 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн 18.2 хувь буюу өмнөх оны үеэс 4 дахин өсөж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчил нь бүртгэгдсэн зөрчлийн 84.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих эзэлж байна.

Иймд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон зайн дүн шинжилгээний программ хангамжийг ашиглан гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж замын нөхцөл байдлын судалгаа хийж байнга гардаг зам, уулзвар цэгүүдийн зураглал, байршлыг тодорхойлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, хяналтын камер байрлуулах, мэдээлэл хүргэх шаардлагатай байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 180 буюу 63.1 хувь нь даваа, мягмар, лхагва, пүрэв гарагт, 158 буюу 55.5 хувь нь 06:00-19:00 цаг, 77 буюу 27.0 хувь нь гэр орон сууц, 116 буюу 40.7 бусад газарт үйлдэгдсэн байх тул газар, нутгийн онцлогуудыг тогтоон, тухайн цаг хугацаа, байршлуудад хяналт тавих эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, иргэд олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

---oooOooo---



3.12. ОРХОН АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг


1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Орхон аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 5746 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 2091 буюу 36.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3655 буюу 63.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 19 буюу 0.3 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 226 буюу 12.1 хувиар тус тус өссөн бол зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 207 буюу 5.4 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 791 буюу 40.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1148 буюу 59.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 7 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 3051 буюу 85.8 хувийг зөрчлийн хэрэг нээж, 498 буюу 14.0 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 6 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 984 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 223 буюу 29.3 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 7.8 хувийг эзэлж байна.




1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Хороо	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баян-Өндөр	752	971	219	29.1
2	Жаргалант	9	13	4	44.4



1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 828 буюу 84.1 хувь нь хөнгөн, 156 буюу 15.9 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 27.6 хувиар, хүнд хэрэг 39.3 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	14	6	-57.1	0.6
	Үүнээс: Хүнийг алах	6	2	-66.7	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	258	354	37.2	36.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	6	8	33.3	0.8
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	25	14	-44.0	1.4
	Үүнээс: Хүчиндэх	16	12	-25.0	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2	3	50.0	0.3
5	Хувь хүний улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		3		0.3
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	9	2	-77.8	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	385	472	22.6	48.0
7	Хулгайлах	123	128	4.1	13.0
	Дээрэмдэх	15	13	-13.3	1.3
	Залилах	193	279	44.6	28.4
8	Эдийн засгийн гэмт хэрэг	3	3	0.0	0.3
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	14	9	-35.7	0.9
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	0.4
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	8	4	-50.0	0.4
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	6	6	0.0	0.6
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	2	0.0	0.2
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	34	97	2.9 дах	9.9
14	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	34	97	2.9 дах	9.9
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг		5		0.5

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 172 буюу 17.5 хувь нь даваа гарагт, 138 буюу 14.0 хувь нь мягмар гарагт, 136 буюу 13.8 хувь нь лхагва гарагт, 116 буюу 11.8 хувь нь пүрэв гарагт, 140 буюу 14.2 хувь нь баасан гарагт, 154 буюу 15.7 хувь нь бямба гарагт, 128 буюу 13.0 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 271 буюу 27.5 хувь нь 06:00-14:00 цагт, 250 буюу 25.4 хувь



нь 14:00-19:00 цагт, 127 буюу 13.0 хувь нь 19:00-22:00 цагт, 336 буюу 34.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	5	3	4	2	2	2	2	20
01:00	8	12	7	7	6	11	8	59
02:00	9	4	1	6	8	18	11	57
03:00	7	2	4		5	7	5	30
04:00	4		2	2	2	5	3	18
05:00	4	3	1	2	1	4		15
06:00				2	2	1		5
07:00	3			2	2	2	2	11
08:00	5	5	6	2	1	2	3	24
09:00	4	3	2	4	3	1		17
10:00	8	7	6	5	5	5	9	45
11:00	6	8	11	11	5	8	6	55
12:00	10	5	6	5	5	4	5	40
13:00	15	9	16	8	8	11	7	74
14:00	9	10	8	10	10	12	9	68
15:00	6	3	8	6	7	5	7	42
16:00	14	16	6	6	7	9	7	65
17:00	6	9	7	4	9	10	9	54
18:00	5	4	2	4	3	2	1	21
19:00	11	10	7	7	14	6	1	56
20:00	8	4	6	6	6	5	8	43
21:00	2	6	5	2	4	4	5	28
22:00	7	6	8	4	5	8	5	43
23:00	16	9	13	9	20	12	15	94
Нийт	172	138	136	116	140	154	128	984

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 295 буюу 30.0 хувь нь гэр орон сууцанд, 145 буюу 14.7 хувь нь гудамж талбайд, 155 буюу 15.8 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 13 буюу 1.3 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.2 хувь нь төрийн бус байгууллагад, 40 буюу 4.1 хувь нь аж ахуйн нэгжид, 97 буюу 9.8 хувь нь авто замд, 236 буюу 24.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 345 буюу 35.1 хувь нь согтуугаар, 125 буюу 12.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 53 буюу 5.4 хувь нь бүлэглэн, 24 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 66 буюу 6.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 264 буюу 26.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.




1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 1323 хэрэгт хэрэг бүртгэлт, 320 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1643 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 498 урьд оны үлдэгдэл хэрэг, 1094 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 51 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 1040 буюу 63.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 205 буюу 19.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 708 буюу 68.1 хувийг шүүхэд шилжүүлж;
- 2 буюу 0.2 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 119 буюу 11.4 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;

-6 буюу 0.6 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 63.3 хувь, хуулийн анхны хугацаанд 91.6 хувийг шийдвэрлэж, 27 хүнд холбогдох 632 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Орхон аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 397 буюу 40.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 61.3 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.5 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.3 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 751 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 284 хэрэг буюу 60.8 хувиар, 460 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 181 буюу 64.9 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 784 хүн яллагдагчаар татагдсан нь өмнөх оноос 21.0 хувиар өссөн.

Яллагдагчдын 668 буюу 85.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 23.5 хувиар, 116 буюу 14.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 8.4 хувиар тус тус өссөн, 37 буюу 4.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 31.5 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 936 иргэн, 2 хуулийн этгээд хохирч, 12 хүн нас барж, 405 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 164 буюу 21.2 хувиар, гэмтсэн хүн 88 буюу 27.8 хувиар тус тус өсөж, нас барсан хүн 4 буюу 25.0 хувиар буурсан.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 3955.9 сая төгрөгийн хохирлын 2889.2 сая төгрөг буюу 73.0 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 1760.6 сая төгрөг буюу 80.2 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 1310.5 сая төгрөг буюу 83.0 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Орхон аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 43.446 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 3741 буюу 7.9 хувиар, 43.457 зөрчлийг шийдвэрлэсэн нь 3751 буюу 7.9 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 40433 буюу 93.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1138 буюу 2.6 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 322 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1553 буюу 3.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 42092 иргэн, 11 хуулийн этгээдийг 1614.4 сая төгрөгөөр торгож, 503 хүнийг баривчлуулах, 833 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 16 хүнийг баривчлуулж,



тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 3125 буюу 6.9 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 299 буюу 26.4 хувиар, баривчлуулсан шийтгэл 340 буюу 40.3 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Орхон аймагт нийт 779 хүн саатуулагдсан нь өнгөрсөн оноос 11 буюу 1.4 хувиар, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн зөрчил гаргаж эрүүлжүүлэгдсэн хүн 57 бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 10 буюу 21.3 хувиар тус тус өссөн байна.

Зургаа. Дүгнэлт.

Орхон аймгийн цагдаагийн газарт 984 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 223 буюу 29.3 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 7.8 хувийг эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 472 буюу 48.0 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 354 буюу 36.0 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 97 буюу 9.9 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2.9 дахин, Хулгайлах гэмт хэрэг 4.1, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 37.2, Залилах гэмт хэрэг 44.6 хувиар тус тус өссөн бол Хүчиндэх гэмт хэрэг 25.0 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн 345 буюу 35.1 хувь нь согтуугаар, 125 буюу 12.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 53 буюу 5.4 хувь нь бүлэглэн, 24 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 66 буюу 6.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 264 буюу 26.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 71.3 хувь нь Даваа-Баасан гарагт, 87.0 хувь нь 06:00-19:00, 22:00-06:00 цагуудад, 84.4 хувь нь гэр, орон сууцанд, гудамж талбай, олон нийтийн газар, бусад газарт үйлдэгдсэн байгаад дүгнэлт хийх, тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын чанар, үр дүнг сайжруулах, хэсэгчилсэн арга хэмжээний тоонд бус үр дүнд онцгойлон анхаарч зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 48.9 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 49.6 хувь нь 18-39 насны сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

---0000000---

3.13. ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Өвөрхангай цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 4183 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 975 буюу 23.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3208 буюу 76.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 765 буюу 15.5 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 974 буюу 23.3 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 209 буюу 27.3 хувиар өссөн байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 676 буюу 72.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 247 буюу 26.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 9 буюу 1.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2870 буюу 90.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 191 буюу 6.0 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 105 буюу 3.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 695 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 179 буюу 34.7 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.5 хувийг эзэлж байна.

1.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 502 буюу 72.2 хувь нь хөнгөн, 193 буюу 27.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа нь өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 15.4 хувиар, хүнд хэрэг 2.4 дахин тус тус өссөн байна.





1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.5. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Арвайхээр	236	300	64	27.1	11	Нарийн тээл	7	20	13	2.8 дах
2	Баруунбаян-Улаан	1	2	1	2.0 дах	12	Өлзийт	7	5	-2	-28.6
3	Бат-Өлзий	45	41	-4	-8.9	13	Сант	4	7	3	75.0
4	Баянгол	3	3	0	0.0	14	Тарagt	13	21	8	61.5
5	Баян-Өндөр	3	5	2	66.7	15	Төгрөг	1	1	0	0.0
6	Богд	19	25	6	31.6	16	Уянга	24	26	2	8.3
7	Бүрд	8	12	4	50.0	17	Хайрхандулаан	10	19	9	90.0
8	Гучин ус	11	3	-8	-72.7	18	Хархорин	65	123	58	89.2
9	Есөнзүйл	8	6	-2	-25.0	19	Хужирт	41	60	19	46.3
10	Зүүнбаян-Улаан	10	16	6	60.0						

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	8	10	25.0	1.5
	Үүнээс: Хүнийг алах	3	5	66.7	0.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	194	247	27.3	35.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	4	2.0 дах	0.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	22	29.4	3.2
	Үүнээс: Хүчиндэх	13	8	-38.5	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2	15	7.5 дах	2.2
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	187	216	15.5	31.1
6	Хулгайлах	94	96	2.1	13.8
	Дээрэмдэх		2		0.3
	Залилах	56	81	44.6	11.7
7	Эдийн засгийн гэмт хэрэг		3		0.4
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	19	1	-94.7	0.1
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	0.6
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	18	5	-72.2	0.8
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	33	12	-63.6	1.7
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	36	158	4.3 дах	22.7
13	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	36	158	4.3 дах	22.7



1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 101 буюу 14.5 хувь нь даваа гарагт, 128 буюу 18.4 хувь нь мягмар гарагт, 108 буюу 15.5 хувь нь лхагва гарагт, 102 буюу 14.7 хувь нь пүрэв гарагт, 85 буюу 12.2 хувь нь баасан гарагт, 96 буюу 13.8 хувь нь бямба гарагт, 75 буюу 10.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 136 буюу 19.6 хувь нь 06:00-14:00 цагт, 208 буюу 29.9 хувь нь 14:00-19:00 цагт, 143 буюу 20.6 хувь нь 19:00-22:00 цагт, 208 буюу 29.9 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00		2	3	1	1			7
01:00	3	12	6	8	4	5	5	43
02:00	2	3	3		4	6	2	20
03:00		4		4	2	3	1	14
04:00	7	3	3		1	1	2	17
05:00			2	2			1	5
06:00		2		1	1			4
07:00	1		1			1	1	4
08:00		2	1	1		2	1	7
09:00	1	2		3	1	2		9
10:00	7	3	6	4	1	3	2	26
11:00	3	4	1	4	5	3	2	22
12:00	1	4	6	4	3	1	2	21
13:00	8	11	7	4	5	3	5	43
14:00	5	8	2	5	3	7	5	35
15:00	5	5	9	1	4	2		26
16:00	4	15	13	7	10	8	8	65
17:00	11	6	6	13	7	7	4	54
18:00	2	6	6	3	3	4	4	28
19:00	9	5	9	6	5	8	4	46
20:00	11	7	7	9	9	13	7	63
21:00	7	6	6	6	5	2	2	34
22:00	4	4	4	7	7	6	6	38
23:00	10	14	7	9	4	9	11	64
Нийт	101	128	108	102	85	96	75	695


Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 239 буюу 34.4 хувь нь гэр орон сууцанд, 131 буюу 18.8 хувь нь гудамж талбайд, 53 буюу 7.6 хувь нь олон нийтийн газарт, 10 буюу 1.4 хувь нь төрийн байгууллагад, 7 буюу 1.0 хувь нь төрийн бус байгууллагад, 15 буюу 2.2 хувь нь аж ахуйн нэгжид, 86 буюу 12.4 хувь нь авто замд, 154 буюу 22.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 331 буюу 47.6 хувь нь согтуугаар, 78 буюу 11.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 36 буюу 5.2 хувь нь бүлэглэн, 16 буюу 2.3 хувь нь хүүхэд оролцож, 71 буюу 10.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 83 буюу 11.9 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.


2024 онд 1103 хэрэгт хэрэг бүртгэлт, 182 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1285 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 355 урьд оны үлдэгдэл хэрэг, 900 тухайн оны дугаартай хэрэг, 1 урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 29 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 933 буюу 72.6 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-392 буюу 42.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-496 буюу 53.2 хувийг шүүхэд шилжүүлж;

-5 буюу 0.5 хувийг хэрэгсэхгүй болгож;

-40 буюу 4.3 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн, нийт шалгасан хэргийн 72.6 хувь, хуулийн анхны хугацаанд 73.6 хувийг шийдвэрлэж, 32 хүнд холбогдох 360 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Өвөрхангай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 212 буюу 30.5 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 66.9 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.0 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 4.3 нэгжээр их байна.



Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 520 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 130 хэрэг буюу 33.3 хувиар, 348 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 91 буюу 35.4 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 579 хүн шалгагдсан нь өмнөх оноос 36.9 хувиар өссөн.

Яллагдагчдын 515 буюу 88.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 41.9 хувиар, 64 буюу 11.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 6.7 хувиар тус тус өссөн, 20 буюу 3.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 47.4 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 593 иргэн, 3 хуулийн этгээд хохирч, 28 хүн нас барж, 279 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 79 буюу 15.4 хувиар, нас барсан хүн 12 буюу 75.0 хувиар, гэмтсэн хүн 41 буюу 17.2 хувиар тус тус өссөн.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1280.1 сая төгрөгийн хохирлын 852.1 сая төгрөг буюу 66.6 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 343.6 сая төгрөг буюу 36.7 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 139.9 сая төгрөг буюу 19.6 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Өвөрхангай аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 62845 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 7486 буюу 10.6 хувиар, 62569 зөрчлийг шийдвэрлэсэн нь 7470 буюу 10.7 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 54253 буюу 86.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1644 буюу 2.6 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 94 буюу 0.1 хувь нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 218 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 6636 буюу 10.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 61216 иргэн, 5 хуулийн этгээдийг 2106.8 сая төгрөгөөр торгож, 250 хүнийг баривчлуулах, 1056 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 40 хүнийг баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг



торгосон шийтгэл 6813 буюу 10.0 хувиар, баривчлуулсан шийтгэл 811 буюу 76.4 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 108 буюу 11.4 хувиар тус тус өссөн байна.

2024 онд Өвөрхангай аймагт нийт 154 хүн саатуулагдсан нь өнгөрсөн оноос 14 буюу 10.0 хувиар өсөж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн эрүүлжүүлэгдсэн хүн 9 бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 10 буюу 52.6 хувиар буурсан байна.

Зургаа. Дүгнэлт.

Өвөрхангай аймгийн цагдаагийн газарт 695 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 179 буюу 34.7 хувиар, хэргийн илрүүлэлт 1.0 хувиар тус тус өссөн байна.

Нийт гэмт хэргийн 31.1 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 35.5 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 22.7 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4.3 дахин, Хүнийг алах 66.7, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 27.3 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн 331 буюу 47.6 хувь нь согтуугаар, 78 буюу 11.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 36 буюу 5.2 хувь нь бүлэглэн үйлдэгдсэн байна.

	Үүнээс: Хүнийг алах	-	4	-	1.1
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	99	123	24.2	35.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	11	6	-45.5	1.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	13	12	-7.7	3.4
	Үүнээс: Хүчиндэх	11	12	9.1	3.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	1	4	4.0 дах	1.1
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.3
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	167	112	-32.9	32.2
6	Хулгайлах	40	37	-7.5	10.6
	Дээрэмдэх	1	2	2.0 дах	0.6



	Залилах	60	16	-73.3	4.6
	Малын хулгай	45	40	-11.1	11.5
7	Эдийн засгийн гэмт хэрэг	-	1	-	0.3
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	1	2	2.0 дах	0.6
9	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	16	7	-56.3	2.0
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	-	-	0.0
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	10	14	40.0	4.0
12	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	0.0
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	18	62	3.4 дах	17.8
13	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	18	62	3.4 дах	17.8
14	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.6

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 44 буюу 12.7 хувь нь даваа гарагт, 49 буюу 14.1 хувь нь мягмар гарагт, 53 буюу 15.2 хувь нь лхагва гарагт, 60 буюу 17.2 хувь нь пүрэв гарагт, 54 буюу 15.5 хувь нь баасан гарагт, 46 буюу 13.2 хувь нь бямба гарагт, 42 буюу 12.1 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 75 буюу 21.6 хувь нь 06:00-14:00 цагт, 102 буюу 29.3 хувь нь 14:00-19:00 цагт, 54 буюу 15.5 хувь нь 19:00-22:00 цагт, 117 буюу 33.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00			1	2	1		1	5
01:00	1	1	1	2		4	1	10
02:00	1	2	1	1	2	3	1	11
03:00		1			1		2	4
04:00	2		2	1	2		1	8
05:00		1	1	1	1		2	6
06:00			1				2	3
07:00	4		1		2			7
08:00	1	1		1		1		4
09:00		2	1	1	1	1	1	7
10:00	3	3	6	3	4	4	2	25
11:00		1	1	1	1		2	6
12:00	1		1	2		3	1	8
13:00	3	3	3			2	4	15
14:00	2	3	3		2	2	1	13
15:00	4	2	1	3	4		3	17
16:00	5	6	3	3	8	1	4	30
17:00	1		5	3	3	1	2	15
18:00	5	4	4	6	2	5	1	27
19:00	2	4	4	5	3	2	3	23
20:00	2	3	1	2	2	2	1	13
21:00		2	3	4	6	2	1	18
22:00	2	4	3	12	7	6	1	35
23:00	5	6	6	7	2	7	5	38
Нийт	44	49	53	60	54	46	42	348



Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 101 буюу 29.0 хувь нь гэр орон сууцанд, 43 буюу 12.4 хувь нь гудамж талбайд, 16 буюу 4.6 хувь нь олон нийтийн газарт, 5 буюу 1.4 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.3 хувь нь төрийн бус байгууллагад, 17 буюу 4.9 хувь нь аж ахуйн нэгжид, 61 буюу 17.5 хувь нь авто замд, 104 буюу 30.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 182 буюу 52.3 хувь нь согтуугаар, 22 буюу 6.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 30 буюу 8.6 хувь нь бүлэглэн, 19 буюу 5.5 хувь нь хүүхэд оролцож, 37 буюу 10.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 19 буюу 5.5 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.


2024 онд 431 хэрэгт хэрэг бүртгэлт, 140 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 571 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 158 урьд оны үлдэгдэл хэрэг, 395 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 18 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 416 буюу 72.9 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-114 буюу 27.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-297 буюу 71.4 хувийг шүүхэд шилжүүлж;

-4 буюу 1.0 хувийг хэрэгсэхгүй болгож;

-1 буюу 0.2 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 72.9 хувь, хуулийн анхны хугацаанд 79.8 хувийг шийдвэрлэж, 8 хүнд холбогдох 162 хэргийн үлдэгдэлтэй байна.






Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Увс аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 98 буюу 28.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 76.8 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.1 хувиар өссөн байна. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 14.2 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.



Хэрэг бүртгэлтийн 233 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 38 хэрэг буюу 14.0 хувиар, 179 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 29 буюу 13.9 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 327 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 11.6 хувиар өссөн. Яллагдагчдын 304 буюу 93.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 13.9 хувиар, 25 буюу 7.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 38.9 хувиар тус тус өсөж, 23 буюу 7.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 11.5 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 309 иргэн, 2 хуулийн этгээд хохирч, 15 хүн нас барж, 136 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 24 буюу 7.2 хувиар буурч, нас барсан хүн 6 буюу 66.7 хувиар, гэмтсэн хүн 30 буюу 28.3 хувиар тус тус өссөн.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2485.2 сая төгрөгийн хохирлын 2064.1 сая төгрөг буюу 83.1 хувийг нөхөн төлүүлж, 161.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 846.8 сая төгрөг буюу 51.7 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 795.5 сая төгрөг буюу 62.7 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 3.0 сая төгрөг буюу 1.9 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Увс аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 27535 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 4760 буюу 14.7 хувиар, 27484 зөрчлийг шийдвэрлэсэн нь 4787 буюу 14.8 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 23671 буюу 86.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 664 буюу 2.4 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 215 буюу 0.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2985 буюу 10.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 26557 иргэн, 7 хуулийн этгээдийг 1018.1 сая төгрөгөөр торгож, 209 хүнийг баривчлуулах, 616 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 95 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг



торгосон шийтгэл 4766 буюу 15.2 хувиар, баривчлуулсан шийтгэл 229 буюу 52.3 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 106 буюу 20.8 хувиар өссөн байна.

2024 онд Увс аймагт нийт 12 хүн эрүүлжүүлж, 53 хүнийг саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 8 буюу 40.0 хувиар, саатуулсан хүн 27 буюу 33.8 хувиар тус тус буурсан байна.

Зургаа. Дүгнэсэн.

Увс аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 2736 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 790 буюу 28.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1946 буюу 71.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 12.4 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 18.5 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 7.8 хувиар өссөн байна.

Өнгөрсөн онд нийт 348 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 15 буюу 4.5 хувиар өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 76.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Нийт гэмт хэргийн 112 буюу 32.2 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 123 буюу 35.3 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 62 буюу 17.8 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 8.0 дахин, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 4.0 дахин, Дээрэмдэх 2.0 дахин, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 2.0 дахин, Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3.4 дахин, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 24.2, Хүчиндэх 9.1, Залилах 73.3, Хүрээлэн байгаа орчны эсрэг 40.0 хувиар тус тус өсөж, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 45.5, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7.7, Хулгайлах 7.5, Мал хулгайлах 11.1, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 56.3 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн 182 буюу 52.3 хувь нь согтуугаар, 22 буюу 6.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 30 буюу 8.6 хувь нь бүлэглэн, 19 буюу 5.5 хувь нь хүүхэд оролцож, 37 буюу 10.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 19 буюу 5.5 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт нь бусад аймгаас өндөр байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 260 буюу 74.7 хувь нь Даваа-Баасан гарагт, 219 буюу 62.9 хувь нь 14:00-19:00, 22:00-06:00 цагуудад, 310 буюу 89.1 хувь нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн сумдад гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 140 буюу 42.8 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 203 буюу 62.1 хувь нь 18-39 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2485.2 сая төгрөгийн хохирлын 2064.1 сая төгрөг буюу 83.1 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 846.8 сая төгрөг буюу 51.7 хувиар өссөн дүнтэй байгаа нь бусад аймгуудын цагдаагийн газар, хэлтсээс нэгдүгээрт жагсаж байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 86.0 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 2.4 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 0.8 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 10.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.

3.19. ХОВД АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Ховд аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 4171 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1235 буюу 29.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2936 буюу 70.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 306 буюу 7.9 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 171 буюу 16.1 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 135 буюу 4.8 хувиар тус тус өссөн байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 653 буюу 55.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 525 буюу 44.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 9 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2425 буюу 83.4 хувийг зөрчлийн хэрэг нээж, 464 буюу 16.0 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 18 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 676 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 75 буюу 12.5 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.4 хувийг эзэлж байна.


1.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 552 буюу 81.7 хувь нь хөнгөн, 124 буюу 18.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 7.8 хувиар, хүнд хэрэг 39.3 хувиар тус тус өссөн байна.





1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.5. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Алтай	15	23	8	53.3
2	Булган	42	35	-7	-16.7
3	Буянт	25	31	6	24.0
4	Дарви	25	19	-6	-24.0
5	Дөргөн	6	10	4	66.7
6	Дуут	9	8	-1	-11.1
7	Жаргалант	339	451	112	33.0
8	Зэрэг	17	10	-7	-41.2
9	Манхан	20	12	-8	-40.0
10	Мөнххайрхан	9	3	-6	-66.7
11	Мөст	18	6	-12	-66.7
12	Мянгад	14	9	-5	-35.7
13	Үенч	14	8	-6	-42.9
14	Ховд	15	14	-1	-6.7
15	Цэцэг	14	19	5	35.7
16	Чандмань	11	13	2	18.2
17	Эрдэнэбүрэн	8	5	-3	-37.5

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	6	11	83.3	1.6
	Үүнээс: Хүнийг алах	3	1	-66.7	0.1
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	192	212	10.4	31.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	4	5	25.0	0.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	27	18	-33.3	2.7
	Үүнээс: Хүчиндэх	21	15	-28.6	2.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	11	17	54.5	2.5
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		2		0.3
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		2		0.3
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	285	285	0.0	42.2



Үүнээс:	Хулгайлах	84	82	-2.4	12.1
	Дээрэмдэх	5	3	-40.0	0.4
	Залилах	114	132	15.8	19.5
9	Эдийн засгийн гэмт хэрэг	7	5	-28.6	0.7
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.6
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	3	1	-66.7	0.1
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	15	12	-20.0	1.8
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	11	13	18.2	1.9
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	0.6
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	37	88	2.4 дах	13.0
15	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	28	47	67.9	7.0
16	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг		1		0.1

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 119 буюу 17.6 хувь нь даваа гарагт, 114 буюу 16.9 хувь нь мягмар гарагт, 111 буюу 16.4 хувь нь лхагва гарагт, 105 буюу 15.5 хувь нь пүрэв гарагт, 105 буюу 15.5 хувь нь баасан гарагт, 64 буюу 9.5 хувь нь бямба гарагт, 58 буюу 8.6 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 186 буюу 27.5 хувь нь 06:00-14:00 цагт, 230 буюу 34.0 хувь нь 14:00-19:00 цагт, 84 буюу 12.4 хувь нь 19:00-22:00 цагт, 176 буюу 26.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00			2	1	1	2	2	8
01:00	3	7	4	7	4	2	3	30
02:00	4	3	5	3	5	5	4	29
03:00	2	1	1	3	5	1	3	16
04:00	1	3	2	1	2		2	11
05:00	2	1	3	2			1	9
06:00		1						1
07:00		5	2	1	2		1	11
08:00	1	2	1	1	4			9
09:00	1	2	1	1	1	2	1	9
10:00	13	10	12	6	3	4	4	52
11:00	7	4	6	4	2	1	1	25
12:00	1	3	2	5	6	4	4	25
13:00	13	14	7	7	6	4	3	54
14:00	8	5	7	4	7	2	2	35
15:00	14	16	9	9	13	3	6	70
16:00	8	11	11	11	9	3	2	55
17:00	9	3	10	5	2	7	3	39
18:00	8	2	3	3	10	3	2	31
19:00	4	4	5	3	5	2	3	26
20:00	5	4	4	6	1	7	3	30
21:00	5	3	6	1	5	6	2	28
22:00	6	7	4	15	5	3	3	43
23:00	4	3	4	6	7	3	3	30
Нийт	119	114	111	105	105	64	58	676



Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 204 буюу 30.2 хувь нь гэр орон сууцанд, 112 буюу 16.6 хувь нь гудамж талбайд, 52 буюу 7.7 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 14 буюу 2.1 хувь нь төрийн байгууллагад, 6 буюу 0.9 хувь нь төрийн бус байгууллагад, 44 буюу 6.5 хувь нь аж ахуйн нэгжид, 50 буюу 7.4 хувь нь авто замд, 193 буюу 28.5 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 254 буюу 37.6 хувь нь согтуугаар, 63 буюу 9.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 23 буюу 3.4 хувь нь бүлэглэн, 16 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 46 буюу 6.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 120 буюу 17.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 980 хэрэгт хэрэг бүртгэлт, 138 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1118 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 285 урьд оны үлдэгдэл хэрэг, 829 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 4 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 739 буюу 66.1 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 284 буюу 38.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 419 буюу 56.7 хувийг шүүхэд шилжүүлж;
- 5 буюу 0.7 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 27 буюу 3.7 хувийг эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 4 буюу 0.5 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 66.1 хувь, хуулийн анхны хугацаанд 99.7 хувийг шийдвэрлэж, 23 хүнд холбогдох 395 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Ховд аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 256 буюу 37.9 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 55.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.4 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 7.2 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 547 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 123 хэрэг буюу 29.0 хувиар, 303 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 70 буюу 30.0 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 475 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 3.7 хувиар өссөн. Яллагдагчдын 424 буюу 89.3 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.9 хувиар, 51 буюу 10.7 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 2.0 хувиар тус тус өсөж, 21 буюу 4.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 50.0 хувиар буурсан байна.




3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 640 иргэн, 3 хуулийн этгээд хохирч, 13 хүн нас барж, 253 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 17 буюу 2.7 хувиар, гэмтсэн хүн 26 буюу 11.5 хувиар тус тус өсөж, нас барсан хүн 8 буюу 38.1 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2317.5 сая төгрөгийн хохирлын 1277.9 сая төгрөг буюу 55.1 хувийг нөхөн төлүүлж, 139.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой харьцуулахад хохирлын хэмжээ 51.7 сая төгрөг буюу 2.3 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 32.4 сая төгрөг буюу 2.6 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 84.5 сая төгрөг буюу 2.5 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Ховд аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 25.754 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 8472 буюу 24.8 хувиар, 25.772 зөрчлийг шийдвэрлэсэн нь 8465 буюу 24.7 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 23.543 буюу 91.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 197 буюу 0.8 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 293 буюу 1.1



хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 8 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1713 буюу 6.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 24.721 иргэн, 7 хуулийн этгээдийг 1073.7 сая төгрөгөөр торгож, 298 хүнийг баривчлуулж, 462 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 279 хүний баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 5 хүнийг сургалтад хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад иргэнийг торгосон шийтгэл 8194 буюу 24.9 хувиар, баривчлуулсан шийтгэл 211 буюу 41.5 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 341 буюу 42.5 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Ховд аймагт нийт 446 хүн саатуулагдаж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн 87 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад саатуулагдсан хүн 306 буюу 40.7 хувиар, эрүүлжүүлэгдсэн хүн 120 буюу 58.0 хувиар тус тус буурсан байна.

Зургаа. Дүгнэлт.

Ховд аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 4171 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1235 буюу 29.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2936 буюу 70.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 7.9 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 16.1 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 4.8 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн онд нийт 676 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 75 буюу 12.5 хувиар өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 55.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.5 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 7.2 нэгжээр бага байна.

Нийт гэмт хэргийн 212 буюу 31.4 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 285 буюу 42.2 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 88 буюу 13.0 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4.0 дахин, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2.4 дахин, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 10.4, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 25.0, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 54.5, Залилах 15.8, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 18.2 хувиар тус тус өсөж, Хүнийг алах 66.7, Хүчиндэх 28.6, Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 50.0, Хулгайлах 2.4, Дээрэмдэх 40.0, Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг 28.6, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 66.7, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 20.0 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн 254 буюу 37.6 хувь нь согтуугаар, 63 буюу 9.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 23 буюу 3.4 хувь нь бүлэглэн, 16 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 46 буюу 6.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 554 буюу 81.9 хувь нь Даваа-Баасан гарагт, 416 буюу 61.5 хувь нь 06:00-19:00 цагт, 509 буюу 75.3% нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн сумдад гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 223 буюу 46.9 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 337 буюу 70.9 хувь нь 18-34 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2317.5 сая төгрөгийн хохирлын 1277.9 сая төгрөг буюу 55.1 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 32.4 сая төгрөг буюу 2.6 хувиар өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 91.4 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 0.8 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1.1 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 6.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---

3.20. ХӨВСГӨЛ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Хөвсгөл аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 3267 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1218 буюу 37.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2049 буюу 62.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 388 буюу 10.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 486 буюу 19.2 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 98 буюу 8.7 хувиар өссөн байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 656 буюу 55.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 533 буюу 44.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 2 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1877 буюу 92.9 хувийг зөрчлийн хэрэг нээж, 117 буюу 5.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 27 буюу 1.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 693 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 93 буюу 15.5 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.5 хувийг эзэлж байна.


1.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 508 буюу 73.3 хувь нь хөнгөн, 185 буюу 26.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 4.7 хувиар, хүнд хэрэг 60.9 хувиар тус тус өссөн байна.





1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



1.5. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алаг-Эрдэнэ	46	62	16	34.8	13	Төмөрбулаг	11	8	-3	-27.3
2	Арбулаг	10	11	1	10.0	14	Түнэл	18	35	17	94.4
3	Баянзүрх	8	3	-5	-62.5	15	Улаан	15	12	-3	-20.0
4	Бүрэнтогтох	15	18	3	20.0	16	Ханх	2	4	2	2.0 дах
5	Галт	13	12	-1	-7.7	17	Цагаан-Уул	18	18	0	0.0
6	Жаргалант	12	13	1	8.3	18	Цагаан нуур	4	4	0	0.0
7	Их-Уул	11	12	1	9.1	19	Цагаан-Үүр	6	4	-2	-33.3
8	Мөрөн	282	360	78	27.7	20	Цэцэрлэг	9	10	1	11.1
9	Рашаант	11	12	1	9.1	21	Чандмань-Өндөр	12	13	1	8.3
10	Рэнчинлхүмбэ	15	6	-9	-60.0	22	Шинэ-Идэр	8	8	0	0.0
11	Тариалан	27	33	6	22.2	23	Эрдэнэбулган	10	10	0	0.0
12	Тосонцэнгэл	37	25	-12	-32.4						

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	11	14	27.3	2.0
	Үүнээс: Хүнийг алах	6	6	0.0	0.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	212	226	6.6	32.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	4	5	25.0	0.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	28	19	-32.1	2.7
	Үүнээс: Хүчиндэх	20	15	-25.0	2.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	6	7	16.7	1.0
5	Авлигын гэмт хэрэг	3	1	-66.7	0.1
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		2		0.3
7	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		1		0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	255	246	-3.5	35.5
8	Үүнээс: Хулгайлах	127	100	-21.3	14.4
	Дээрэмдэх	7	12	71.4	1.7
	Залилах	87	72	-17.2	10.4
9	Эдийн засгийн гэмт хэрэг	2	1	-50.0	0.1
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	2	-50.0	0.3
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	0.6
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	10	2	-80.0	0.3
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	33	58	75.8	8.4
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	5	5.0 дах	0.7



15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	34	105	3.1 дах	15.2
	Үүнээс: Автогээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	34	105	3.1 дах	15.2

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 110 буюу 15.9 хувь нь даваа гарагт, 104 буюу 15.0 хувь нь мягмар гарагт, 93 буюу 13.4 хувь нь лхагва гарагт, 107 буюу 15.4 хувь нь пүрэв гарагт, 88 буюу 12.7 хувь нь баасан гарагт, 97 буюу 14.0 хувь нь бямба гарагт, 94 буюу 13.6 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 156 буюу 22.5 хувь нь 06:00-14:00 цагт, 214 буюу 30.9 хувь нь 14:00-19:00 цагт, 97 буюу 14.0 хувь нь 19:00-22:00 цагт, 226 буюу 32.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	1	1	1	1	4	3	1	12
01:00	5	3	5	2	6	6	8	35
02:00	2	2	7	2	3	4	3	23
03:00	2	3	5	1	3	3	1	18
04:00	1	2	1	2	3	1	4	14
05:00	1	2	2		1	3		9
06:00		2		1	2	1		6
07:00	2		1	1	1			5
08:00	4			2	1	1	1	9
09:00	4		2	2	1	2		11
10:00	7	5	5	7	8	5	2	39
11:00	5	5	3	2	4	5	4	28
12:00	5	5	5	5	3	5	3	31
13:00	7	4	4	1	1	7	3	27
14:00	12	9	6	10	8	7	7	59
15:00	6	2	5	9	1	3	6	32
16:00	8	18	7	10	5	6	11	65
17:00	3	8	4	6	6	4	8	39
18:00	2	2	3	3	1		8	19
19:00	7	5	6	9	1	6	4	38
20:00	5	4	2	11	10	4	6	42
21:00	1	3	1	5	2	4	1	17
22:00	10	7	5	6	3	7	7	45
23:00	10	12	13	9	10	10	6	70
Нийт	110	104	93	107	88	97	94	693


Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 241 буюу 34.8 хувь нь гэр орон сууцанд, 110 буюу 15.9 хувь нь гудамж талбайд, 46 буюу 6.6 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 12 буюу 1.8 хувь нь төрийн байгууллагад, 4 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 20 буюу 2.9 хувь нь аж ахуйн нэгжид, 100 буюу 14.4 хувь нь авто замд, 159 буюу 22.9 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 256 буюу 36.9 хувь нь согтуугаар, 62 буюу 8.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 27 буюу 3.9 хувь нь бүлэглэн, 23 буюу 3.3 хувь нь хүүхэд оролцож, 57 буюу 8.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 48 буюу 6.9 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 848 хэрэгт хэрэг бүртгэлт, 191 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1039 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 246 урьд оны үлдэгдэл хэрэг, 791 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 1, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 1 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 742 буюу 71.4 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 193 буюу 26.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 539 буюу 72.7 хувийг шүүхэд шилжүүлж;
- 1 буюу 0.1 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 8 буюу 1.1 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
- 1 буюу 0.1 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 71.4 хувь, хуулийн анхны хугацаанд 98.2 хувийг шийдвэрлэж, 41 хүнд холбогдох 320 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Хөвсгөл аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 229 буюу 33.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 64.3 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.3 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.7 нэгжээр их байна.



Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.



Хэрэг бүртгэлтийн 521 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 129 хэрэг буюу 32.9 хувиар, 335 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 84 буюу 33.5 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 546 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 10.1 хувиар өссөн. Яллагдагчдын 47 буюу 8.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 9.3 хувиар, 499 буюу 91.4 хувь нь эрэгтэй хүн эзэлж байгаа нь 10.2 хувиар тус тус өсөж, 31 буюу 5.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 20.5 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 657 иргэн, 1 хуулийн этгээд хохирч, 26 хүн нас барж, 283 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 48 буюу 7.9 хувиар, нас барсан хүн 2 буюу 8.3 хувиар, гэмтсэн хүн 29 буюу 11.4 хувиар тус тус өссөн.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 3101.5 сая төгрөгийн хохирлын 1855.9 сая төгрөг буюу 59.8 хувийг нөхөн төлүүлж, 16.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 2018.6 сая төгрөг буюу 39.4 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 2014.5 сая төгрөг буюу 52.0 хувиар тус тус буурч, битүүмжилсэн хөрөнгө 7.2 сая төгрөг буюу 79.4 хувиар өссөн байна.

Тав. Зөрчил.

Хөвсгөл аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 23.710 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 7580 буюу 24.2 хувиар, 23.429 зөрчлийг шийдвэрлэсэн нь 7680 буюу 24.7 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 21.105 буюу 89.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 358 буюу 1.5 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 303 буюу 1.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1944 буюу 8.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 22561 иргэнийг 883.3 сая төгрөгөөр торгож, 211 хүнийг баривчлуулж, 638 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 19 хүнийг баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 7250



буюу 24.3 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 188 буюу 22.8 хувиар, баривчлуулсан шийтгэл 260 буюу 55.2 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Хөвсгөл аймагт нийт 17 хүн эрүүлжүүлэгдэж, 614 хүн саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 30 буюу 63.8 хувиар, саатуулсан хүн 210 буюу 25.5 хувиар тус тус буурсан байна.

Зургаа. Дүгнэлт.

Хөвсгөл аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 3267 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1218 буюу 37.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2049 буюу 62.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.

Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 388 буюу 10.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 486 буюу 19.2 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 98 буюу 8.7 хувиар өссөн байна.

Тус аймгийн цагдаагийн газарт 693 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 93 буюу 15.5 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 64.3 хувь бөгөөд 0.3 нэгжээр өссөн.

Нийт гэмт хэргийн 246 буюу 35.5 хувь нь өмчлөх эрхийн эсрэг, 226 буюу 32.6 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 105 буюу 15.2 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад кибер, аюулгүй байдлын эсрэг 5.0 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 3.1 дахин, хүрээлэн байгаа орчны эсрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, дээрэмдэх, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 6.6-75.8 хувиар тус тус өсөж, хүчиндэх, авлигын эсрэг гэмт хэрэг, хулгайлах, залилах, эдийн засгийн, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 3.5-80.0 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 256 буюу 36.9 хувь нь согтуугаар, 62 буюу 8.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 27 буюу 3.9 хувь нь бүлэглэн, 23 буюу 3.3 хувь нь хүүхэд оролцож, 57 буюу 8.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 217 буюу 31.3 хувь нь даваа, пүрэв 49 буюу 13.5 хувь 22:00-06:00 цагуудад, 510 буюу 73.6 хувь нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн Мөрөн, Алаг-Эрдэнэ, Түнэл сумдын нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 203 буюу 37.2 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 303 буюу 55.5 хувь нь 25-39 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 21105 буюу 89.0 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 358 буюу 1.5 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 303 буюу 1.3 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1944 буюу 8.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---00000000---

3.21. ХЭНТИЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Хэнтий аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 4667 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1788 буюу 38.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2879 буюу 61.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 472 буюу 9.2 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 27 буюу 1.5 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 445 буюу 13.4 хувиар тус тус буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 490 буюу 28.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1198 буюу 70.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 8 буюу 0.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2294 буюу 81.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 465 буюу 16.6 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 49 буюу 1.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 687 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 18 буюу 2.7 хувиар өсөж, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.5 хувийг эзэлж байна.

1.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 520 буюу 75.7 хувь нь хөнгөн, 167 буюу 24.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 9.7 хувиар өсөж, хүнд хэрэг 14.4 хувиар буурсан байна.





1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг



1.5. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (сумдаар).

Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2023 он	2024 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Батноров	35	62	27	77.1	11	Дадал	24	15	-9	-37.5
2	Батширээт	6	10	4	66.7	12	Дархан	8	11	3	37.5
3	Баянадарга	8	15	7	87.5	13	Дэлгэрхаан	24	17	-7	-29.2
4	Баянмөнх	6	8	2	33.3	14	Жаргалтхаан	18	13	-5	-27.8
5	Баян-Овоо	17	8	-9	-52.9	15	Мөрөн	34	16	-18	-52.9
6	Баянхутаг	29	9	-20	-69.0	16	Норовлин	16	16	0	0.0
7	Биндэр	16	19	3	18.8	17	Өмнөдэлгэр	33	46	13	39.4
8	Бор-Өндөр	66	76	10	15.2	18	Хэрлэн	284	322	38	13.4
9	Бэрх	2	2	0	0.0	19	Цэнхэрмандал	28	12	-16	-57.1
10	Галшир	15	10	-5	-33.3						

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	21	20	-4.8	2.9
	Үүнээс: Хүнийг алах	6	10	66.7	1.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	182	194	6.6	28.2
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	4	2	-50.0	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	14	26	85.7	3.8
	Үүнээс: Хүчиндэх	12	20	66.7	2.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	3	5	66.7	0.7
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1			
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	361	324	-10.2	47.0
6	Үүнээс: Хулгайлах	113	92	-18.6	13.4
	Дээрэмдэх	3	5	66.7	0.7
	Залилах	121	105	-13.2	15.2
7	Эдийн засгийн гэмт хэрэг	1	7	7.0 дах	1.0
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	8	2	-75.0	0.3
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2			
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	1			
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	11	5	-54.5	0.7



12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	10	21	2.1 дах	3.0
13	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		2		0.3
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.1
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	52	80	53.8	11.6
15	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	52	80	53.8	11.6

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 116 буюу 16.9 хувь нь даваа гарагт, 124 буюу 18.0 хувь нь мягмар гарагт, 123 буюу 17.9 хувь нь лхагва гарагт, 95 буюу 13.8 хувь нь пүрэв гарагт, 77 буюу 11.2 хувь нь баасан гарагт, 72 буюу 10.5 хувь нь бямба гарагт, 80 буюу 11.7 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 161 буюу 23.4 хувь нь 06:00-14:00 цагт, 204 буюу 29.7 хувь нь 14:00-19:00 цагт, 131 буюу 19.1 хувь нь 19:00-22:00 цагт, 191 буюу 27.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
01:00	4	3	8	3	3	7	5	33
02:00	1	1	1	2	5	5		15
03:00	2	1	2		3	1	2	11
04:00	2	4	4	3	2			15
05:00	2	6		2	2	1	2	15
06:00			1				1	2
07:00	3	4	4		2	1	1	15
08:00	2	1	2	2	2		1	10
09:00	3		1		1		1	6
10:00	10	8	4	5	3	6	5	41
11:00	3	2	4	3	1		2	15
12:00	6	5	5	2	2	2		22
13:00	8	7	9	8	9	3	6	50
14:00	7	16	5	11	5	2	6	52
15:00	3	4	3	2		3	1	16
16:00	6	8	9	13	9	6	9	60
17:00	8	8	12	9	2	6	7	52
18:00	4	7	3	4	2	2	2	24
19:00	5	6	10	2	6	3	4	36
20:00	12	9	10	9	4	9	14	67
21:00	4	4	6	3	4	5	2	28
22:00	9	4	7	6	3	3	4	36
23:00	12	16	13	6	7	7	5	66
Нийт	116	124	123	95	77	72	80	687

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 237 буюу 34.5 хувь нь гэр орон сууцанд, 98 буюу 14.3 хувь нь гудамж талбайд, 38 буюу 5.5 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 7 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.3 хувь нь төрийн бус байгууллагад, 37 буюу 5.4 хувь нь аж ахуйн нэгжид, 41 буюу 6.0 хувь нь авто замд, 226 буюу 32.9 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 255 буюу 37.1 хувь нь согтуугаар, 93 буюу 13.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 26 буюу 3.8 хувь нь бүлэглэн, 14 буюу 2.0 хувь нь хүүхэд оролцож, 43 буюу 6.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 69 буюу 10.0 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2024 онд 1122 хэрэгт хэрэг бүртгэлт, 267 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1389 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 350 урьд оны үлдэгдэл хэрэг, 997 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 42 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 962 буюу 69.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:


-453 буюу 47.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-486 буюу 50.5 хувийг шүүхэд шилжүүлж;

-2 буюу 0.2 хувийг хэрэгсэхгүй болгож;

-18 буюу 1.9 хувийг эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;

-3 буюу 0.3 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 69.3 хувь, хуулийн анхны хугацаанд 99.7 хувийг шийдвэрлэж, 111 хүнд холбогдох 449 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Хэнтий аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 322 буюу 46.9 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 61.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.1 нэгжээр буурсан. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.2 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 448 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 48 хэрэг буюу 9.7 хувиар, 275 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 30 буюу 9.8 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 550 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 6.2 хувиар өссөн.

Яллагдагчдын 467 буюу 84.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.7 хувиар, 83 буюу 15.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 40.7 хувиар тус тус өсөж, 18 буюу 3.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 633 иргэн, 1 хуулийн этгээд хохирч, 28 хүн нас барж, 203 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 63 буюу 9.1 хувиар, гэмтсэн хүн 1 буюу 0.5 хувиар, нас барсан хүн 29 буюу 50.9 хувиар тус тус буурсан байна.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 6315.8 сая төгрөгийн хохирлын 4272.5 сая төгрөг буюу 67.6 хувийг нөхөн төлүүлж, 4.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой харьцуулахад хохирлын хэмжээ 2176.2 сая төгрөг буюу 52.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 1685.8 сая төгрөг буюу 65.2 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 4.0 сая төгрөг буюу 6.6 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Хэнтий аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 42.775 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 9444 буюу 28.3 хувиар, 42.450 зөрчлийг шийдвэрлэсэн нь 9345 буюу 28.2 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 36.038 буюу 84.3 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 802 буюу 1.9 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 341 буюу 0.8 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 5594 буюу 13.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 41.464 иргэн, 5 хуулийн этгээдийг 1310.3 сая төгрөгөөр торгож, 315 хүнийг баривчлуулж, 658 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 8 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан нь өмнөх онтой харьцуулахад иргэнийг торгосон шийтгэл



9586 буюу 30.1 хувиар өсөж, баривчлуулсан шийтгэл 192 буюу 37.9 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 59 буюу 8.2 хувиар тус тус буурсан байна.

2024 онд Хэнтий аймагт нийт 280 хүн саатуулагдаж, согтууруулах ундаа хэтрүүлэн 378 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад саатуулагдсан хүн 87 буюу 45.1 хувиар, эрүүлжүүлэгдсэн хүн 25 буюу 7.1 хувиар тус тус өссөн байна.

Зургаа. Дүгнэлт.

Хэнтий аймгийн цагдаагийн газар нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 4667 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1788 буюу 38.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2879 буюу 61.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 9.2 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1.5 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 13.4 хувиар тус тус буурсан байна.

Өнгөрсөн онд нийт 687 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 18 буюу 2.7 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 61.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.1 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт гэмт хэргийн 194 буюу 28.2 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 324 буюу 47.2 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 80 буюу 11.6 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг 7.0 дахин, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2.1 дахин, Хүнийг алах 66.7, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 6.6, Хүчиндэх 66.7, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 66.7, Дээрэмдэх 66.7, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 53.8 хувиар тус тус өсөж, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 50.0, Хулгайлах 18.6, Залилах 13.2, Олон нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 75.0, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 54.5, Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 50.0 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн 255 буюу 37.1 хувь нь согтуугаар, 93 буюу 13.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 26 буюу 3.8 хувь нь бүлэглэн, 14 буюу 2.0 хувь нь хүүхэд оролцож, 43 буюу 6.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 458 буюу 66.6 хувь нь Даваа-Пүрэв гарагт, 395 буюу 57.5 хувь нь 14:00-19:00, 22:00-06:00 цагуудад, 561 буюу 81.6% нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэг ихээр бүртгэгдсэн сумдад гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 285 буюу 51.8 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 360 буюу 65.4 хувь нь 18-34 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 6315.8 сая төгрөгийн хохирлын 4272.5 сая төгрөг буюу 67.6 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 1685.8 сая төгрөг буюу 65.2 хувиар өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 84.3 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1.9 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 0.8 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 13.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.

---oooOooo---



Дөрөв. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

4.1. ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 191 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 8 буюу 4.0 хувиар, нийслэлийн хэмжээнд 104 бүртгэгдсэн нь 17 буюу 14.0 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 87 бүртгэгдсэн нь 9 буюу 11.5 хувиар өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	199	191	-4.0	0.6	0.4
Нийслэлд	121	104	-14.0	0.5	0.3
Орон нутагт	78	87	11.5	0.7	0.7

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2005-2024 он/.





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 29 буюу 15.2 хувь нь даваа гарагт, 23 буюу 12.0 хувь нь мягмар гарагт, 32 буюу 16.8 хувь нь лхагва гарагт, 34 буюу 17.8 хувь нь пүрэв гарагт, 24 буюу 12.6 хувь нь баасан гарагт, 23 буюу 12.0 хувь нь бямба гарагт, 26 буюу 13.6 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 47 буюу 24.6 хувь нь 06:00-14:00 цагт, 32 буюу 16.8 хувь нь 14:00-19:00 цагт, 34 буюу 17.8 хувь нь 19:00-22:00 цагт, 78 буюу 40.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00		1		1	1			3
01:00	1		2	1	1	3	4	12
02:00		1	2	1	1	3	2	10
03:00	1	2		1			1	5
04:00	2	2	1	3	1	2		11
05:00	2	1	1		2		2	8
06:00	1		1	1		1	1	5
07:00	1		1	1	4	1	1	9
08:00		1	1		1			3
09:00	1		1		1		1	4
10:00	1		3	3	1		1	9
11:00	1			1				2
12:00	2			2	1			5
13:00			3	3	1	1	2	10
14:00		1	1	3	1			6
15:00					1	1		2
16:00	3	1	1				1	6
17:00			3	2			2	7
18:00	1	1	1	3	2	3		11
19:00	3		5	2		1	1	12
20:00	3	2	3	3	2			13
21:00	2	2	1			2	2	9
22:00	1	3		1		2	2	9
23:00	3	5	1	2	3	3	3	20
Нийт	29	23	32	34	24	23	26	191

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 115 буюу 60.2 хувь нь гэр, орон сууцанд, 40 буюу 21.0 хувь нь гудамж талбайд, 8 буюу 4.2 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 5 буюу 2.6 хувь нь аж ахуйн нэгжид, 22 буюу 11.5 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 144 буюу 75.4 хувь нь согтуугаар, 1 буюу 0.5 хувь нь мансуурсан үедээ, 3 буюу 1.6 хувь нь галт зэвсгээр үйлдсэн, 3 буюу 1.6 хувь нь хүүхэд оролцож, 23 буюу 12.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 37 буюу 19.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 11 буюу 5.8 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.




1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 125 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 7 хэрэг буюу 5.9 хувиар, үүнээс 121 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 4 буюу 3.4 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 96.8 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.4 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 96.3 хувь байгаа нь 3.7 нэгжээр тус тус буурсан, орон нутгийн хэмжээнд 97.8 хувь байгаа нь 0.7 нэгжээр өссөн байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 204 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 11 буюу 5.1 хувиар буурсан. Яллагдагчдын 22 буюу 10.8 хувь нь эмэгтэй, 182 буюу 89.2 хувь нь эрэгтэй, 3 буюу 1.5 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх онтой харьцуулахад эрэгтэй хүн 4 буюу 2.2 хувиар, эмэгтэй хүн 7 буюу 24.1 хувиар тус тус буурч, хүүхэд өмнөх оны түвшинд байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 196 иргэн хохирсон нь өмнөх онтой харьцуулахад хохирсон хүн 7 буюу 3.4 хувиар буурсан байна.



3.2. Учирсан хохирол.



Иргэн учирсан 2424.3 сая төгрөгийн хохирлын 1843.8 сая төгрөг буюу 76.1 хувийг нөхөн төлүүлж, 139.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой харьцуулахад учирсан хохирол 698.8 сая төгрөг буюу 40.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 118.3 сая төгрөг буюу 6.9 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 38.9 сая төгрөг буюу 38.6 хувиар тус тус өссөн байна.

Дөрөв. Дүгнэлт.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 191 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 8 буюу 4.0 хувиар буурсан, хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 96.8 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.4 нэгжээр байна. Сүүлийн 20 жилийн (бүтэн жилийн дундаж) статистикаар 277, сард 23 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 95 буюу 49.8 хувь нь Даваа, Лхагва, Пүрэв гарагт, 125 буюу 65.4 хувь нь 22:00-14:00 цагуудад, 115 буюу 60.2 хувь нь гэр, орон сууцанд үйлдэгдсэн байна. Дээрх төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийн хувьд эрхэлсэн тодорхой ажилгүй иргэдийн дунд ахуйн хүрээний архидалт болон найз, нөхөд, төрөл садны холбоотой хүмүүсийн хоорондын хувийн таарамжгүй харьцаанаас үүдэлтэй, согтуурсан үедээ тухайн гэмт хэргийг үйлдэх нь их байна.

Энэхүү гэмт хэрэг нь хувь хүний сэтгэл санааны тогтворгүй байдал, нийгмийн сөрөг хандлага, аюулгүй орчин нөхцөлүүдээс олон хүчин зүйлүүдээс хамааралтай бөгөөд тухайн аюулгүй орчныг бүрдүүлэх суурьшлын бүсчлэлээ 800м²-аар хувааж, аюулгүй байдлын үнэлгээ хийн эрэмбэлэх, эрсдэл өндөртэй байршлуудад CPTED буюу хүрээлэн буй орчны загварчлалаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, хувь хүний төлөвшил, ухамсрыг бий болгох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран олон талд нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлж иргэд олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

---oooOooo---



1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1292 буюу 14.5 хувь нь даваа гарагт, 1273 буюу 14.2 хувь нь мягмар гарагт, 1264 буюу 14.1 хувь нь лхагва гарагт, 1249 буюу 14.0 хувь нь пүрэв гарагт, 1230 буюу 13.8 хувь нь баасан гарагт, 1396 буюу 15.6 хувь нь бямба гарагт, 1231 буюу 13.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1990 буюу 22.3 хувь нь 06:00-14:00 цагт, 1934 буюу 21.7 хувь нь 14:00-19:00 цагт, 1434 буюу 16.0 хувь нь 19:00-22:00 цагт, 3577 буюу 40.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	10	13	13	15	20	18	14	103
01:00	86	91	77	90	84	118	85	631
02:00	73	67	72	68	84	111	77	552
03:00	50	33	35	44	53	53	60	328
04:00	39	42	56	46	49	55	57	344
05:00	38	28	38	42	41	55	51	293
06:00	19	15	8	14	8	23	18	105
07:00	16	23	21	28	15	18	25	146
08:00	37	30	32	35	18	36	38	226
09:00	14	13	15	15	17	13	14	101
10:00	86	69	67	50	62	63	52	449
11:00	44	47	54	53	40	48	37	323
12:00	33	31	29	27	28	24	21	193
13:00	73	66	72	59	71	66	40	447
14:00	71	68	70	81	53	48	68	459
15:00	37	36	37	36	32	36	38	252
16:00	70	79	54	73	58	64	60	458
17:00	68	87	65	87	76	72	77	532
18:00	38	29	32	37	35	39	23	233
19:00	63	82	63	75	62	86	57	488
20:00	105	99	99	87	96	100	97	683
21:00	29	47	43	18	41	40	45	263
22:00	88	86	78	79	71	90	93	585
23:00	106	91	134	90	116	120	84	741
Нийт	1293	1272	1264	1249	1230	1396	1231	8935

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 3160 буюу 35.4 хувь нь гэр, орон сууцанд, 2526 буюу 28.3 хувь нь гудамж талбайд, 1392 буюу 15.6 хувь нь олон нийтийн газарт, 515 буюу 5.8 хувь нь аж ахуйн нэгжид, 1342 буюу 14.9 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3806 буюу 42.6 хувь нь согтуугаар, 366 буюу 4.1 хувь нь хүүхэд оролцож, 826 буюу 9.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1341 буюу 15.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 333 буюу 3.7 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 6934 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 523 хэрэг буюу 8.2 хувиар өсөж, үүнээс 4362 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 177 буюу 3.9 хувиар буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 62.9 хувь байгаа нь өмнөх оноос 7.9 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 54.6 хувь байгаа нь 10.2 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 79.8 хувь байгаа нь 6.4 нэгжээр тус тус буурсан байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь





Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 6916 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 308 буюу 4.3 хувиар буурсан. Яллагдагчдын 731 буюу 10.6 хувь нь эмэгтэй, 6185 буюу 89.4 хувь нь эрэгтэй, 404 буюу 5.8 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 292 буюу 4.5 хувь, эмэгтэй хүн 16 буюу 2.1 хувиар, хүүхэд 32 буюу 7.3 хувиар тус тус буурсан байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 9331 иргэн хохирч, үүнээс 11 нас барж, 9001 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 408 буюу 4.6 хувиар, гэмтсэн хүн 640 буюу 7.7 хувиар, нас барсан хүн 5 буюу 83.3 хувиар тус тус өссөн байна.

Гэмтсэн иргэдийн гэмтлийн зэргээр нь авч үзвэл 7418 буюу 82.4 хувь нь хөнгөн, 1077 буюу 12.0 хувь нь хүндэвтэр, 506 буюу 5.6 хувь нь хүнд зэргийн гэмтэл учирсан байна.



3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 14619.3 сая төгрөгийн хохирлын 11058.4 сая төгрөг буюу 75.6 хувийг нөхөн төлүүлж, 541.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 21780.4 сая төгрөг буюу 59.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 11614.5 сая төгрөг буюу 51.2 хувиар тус тус буурч, битүүмжилсэн хөрөнгө 497.3 сая төгрөг буюу 12.3 дахин өссөн байна.

Дөрөв. Дүгнэлт.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 8935 бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 4.7 хувиар өсөж, нийслэлийн хэмжээнд 5173 бүртгэгдсэн нь өмнөх оноос 87.2 хувиар буурч, орон нутгийн хэмжээнд 3761 бүртгэгдсэн нь 440 буюу 13.2 хувиар өсөж, бусад газар /хилийн чандад/-т 1 бүртгэгдсэн нь 2 буюу 66.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг Даваа-Ням гарагуудад ижил давтамжтай, 3577 буюу 40.0 хувь нь 22:00-06:00 цагт, 63.7 хувийг гэр орон сууц, гудамж талбайд, 42.6 хувийг согтуугаар, 15.0 хувийг гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 74.4 хувийг 18-39 насны эрэгтэй хүн, 39.2 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд үйлдсэн байна.

Гэмт хэргийн төрлөөс харахад 4.7 хувийг хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 81.0 хувийг хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг эзэлж байгаагаас гадна гэмт хэргийн 68.3 хувь нь 18-39 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуус үйлдсэн байгаад хүүхэд, залуусын хоорондын харилцаа хандлага, гэр бүлийн таарамжгүй харилцаа, хардалт, архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Архи, согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулж буй газруудад тавих хяналтыг сайжруулж, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, үйлчилгээ үзүүлдэг цэгийн тоо болон цагийн хуваарийг багасгах талаар нутаг дэвсгэрийн хэмжээнд гаргасан тооцоо судалгаа бүхий саналыг холбогдох төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлж, шийдвэрлүүлэх ажлыг идэвхжүүлэх шаардлагатай байна.



Согтууруулах ундааны хатуулгаас шалтгаалан онцгой албан татварын ялгамжтай оногдуулах Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хатуулаг ихтэй, эрүүл мэндэд хор хөнөөлтэй согтууруулах ундааны хэрэглээ багасахын хэрээр архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэн гарч байгаа гэмт хэрэг тэр дундаа хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо ч мөн адил буурах магадлалтай юм.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 2019 онд “Нэг хором” аяныг улсын хэмжээнд зохион байгуулсан нь үр дүнтэй ажил, арга хэмжээ болсон бөгөөд тухайн гэмт хэргийн хор холбогдол, харилцаа хандлагаас үүдэлтэй учирч буй хохирлыг харуулсан богино хэмжээний шторк, нэвтрүүлэг, сургалт сурталчилгаа, уриалга зэргийг оновчтой байдлаар хүргэсэн нь олон нийтэд хүрч, энэ төрлийн гэмт хэргийн гаралтад нөлөөлж 2018-2020 онд 9.5-10.4 хүртэл хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан.

Иймд цаашид иргэдийн нийгмийн сэтгэлзүй, иргэдийн урамсарт нөлөөлөхүйц арга, хэмжээ, аяныг нэг удаа явуулаад өнгөрөх биш тодорхой үе шаттайгаар зохион байгуулж явуулах нь үр дүнгээ өгч байна.

Хувь хүний халдашгүй эрхийг хуулиар хэрхэн хамгаалсан байдаг талаар болон гэмт хэргийн улмаас өөрт болон өөр хэн нэгэнд учирч болох хор холбогдол, эрсдэлүүдийн талаар мэдээ, мэдээлэл, контент, подкаст бэлтгэн хүргэж, хүүхэд, залууст эрх зүйн боловсрол, төлөвшил олгох чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарсан ажил, арга хэмжээг зохион байгуулах нь үр дүнтэй ажил болно гэж дүгнэж байна.

---0000000---



4.3. ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 658 бүртгэгдсэн нь өмнөх оноос 94 буюу 16.7 хувиар, нийслэлийн хэмжээнд 365 бүртгэгдсэн нь 78 буюу 27.2 хувиар, орон нутгийн хэмжээнд 293 бүртгэгдсэн нь 18 буюу 6.5 хувиар тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	564	658	16.7	1.6	1.5
Нийслэлд	287	365	27.2	1.1	1.1
Орон нутагт	275	293	6.5	2.6	2.3
Бусад	2	-	-	10.0	0.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2005-2024 он/.





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 85 буюу 12.9 хувь нь даваа гарагт, 77 буюу 11.7 хувь нь мягмар гарагт, 119 буюу 18.1 хувь нь лхагва гарагт, 93 буюу 14.1 хувь нь пүрэв гарагт, 100 буюу 15.2 хувь нь баасан гарагт, 95 буюу 14.5 хувь нь бямба гарагт, 89 буюу 13.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 155 буюу 23.6 хувь нь 06:00-14:00 цагт, 148 буюу 22.5 хувь нь 14:00-19:00 цагт, 77 буюу 11.7 хувь нь 19:00-22:00 цагт, 278 буюу 42.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	3					1		4
01:00	8	2	6	2	6	9	5	38
02:00	4	9	14	2	8	8	9	54
03:00	4	3	5	1	4	9	4	30
04:00	3	1	6	7	4	2	1	24
05:00	4	3	3	3	1	6	7	27
06:00	2	2	2	2	4	3	4	19
07:00	1	1	4	1	1	2	3	13
08:00	3	1	3	1	2	1	1	12
09:00	1		2		1	1		5
10:00	1	7	4	5	4	4	6	31
11:00	5	3	2	6	5	2	3	26
12:00	3	1		4	1	3	2	14
13:00	5	4	5	8	4	3	6	35
14:00	5	5	9	5	5	9	4	42
15:00	1	4	2	2	3	3	2	17
16:00	6	6	9	2	10	4	6	43
17:00	2	6	9	3	6	3	4	33
18:00	4	1	3	2	2		1	13
19:00	1	4	2	5	4	1	3	20
20:00	5	4	6	11	8	2	8	44
21:00	2	1	1	1	4	2	2	13
22:00	5	1	8	10	7	9	2	42
23:00	7	8	14	10	6	8	6	59
Нийт	85	77	119	93	100	95	89	658

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 414 буюу 62.9 хувь нь гэр, орон сууцанд, 75 буюу 11.4 хувь нь гудамж талбайд, 48 буюу 7.3 хувь нь олон нийтийн газарт, 3 буюу 0.5 хувь төрийн байгууллагад, 18 буюу 2.7 хувь нь аж ахуйн нэгжид, 3 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 5 буюу 0.7 хувь нь нийтийн тээвэрт, 92 буюу 14.0 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.



Нийт бүртгэгдсэн хэргийн 149 буюу 22.6 хувь нь согтуугаар, 23 буюу 3.5 хувь нь хүүхэд оролцож, 117 буюу 17.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 29 буюу 4.4 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 566 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 99 хэрэг буюу 21.2 хувиар өсөж, үүнээс 207 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 11 буюу 5.0 хувиар буурсан.


Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 36.6 хувь байгаа нь өмнөх оноос 10.1 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 24.2 хувь байгаа нь 15.4 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 53.3 хувь байгаа нь 2.3 нэгжээр тус тус буурсан байна.

Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 329 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 31 буюу 8.6 хувиар, 27 буюу 8.2 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь 25 буюу 48.1 хувиар тус тус буурсан байна

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 675 иргэн хохирч, 49 хүн гэмтэж, нь өмнөх оноос хохирсон хүн 110 буюу 19.5 хувиар, гэмтсэн хүн 4 буюу 8.9 хувиар тус тус өссөн.

Хохирсон иргэдийн 436 буюу 64.6 хувь нь 17 хүртэлх насны хүүхэд байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон 10 хүний 7 нь хүүхэд байна гэсэн үг юм.

Хохирсон хүүхдийг насаар нь авч үзвэл 29 буюу 4.3 хувь нь 7 хүртэлх, 173 буюу 25.6 хувь нь 8-13 насны, 234 буюу 34.7 хувь нь 14-17 насны хүүхэд байна.





Дөрөв. Дүгнэлт.

Улсын хэмжээнд хүчиндэх гэмт хэргийн эзлэх хувь 1.9 хувь, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг бүлэг дотор эзлэх хувь 77.6 хувьтай байна.

Өнгөрсөн онд нийт 566 гэмт хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 99 хэрэг буюу 21.2 хувиар өсөж, хэргийн илрүүлэлт 36.6 хувь байгаа нь өмнөх оноос 10.1 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 24.2 хувь байгаа нь 15.4 нэгжээр тус тус буурсан бол орон нутгийн хэмжээнд 12.3 хувь байгаа нь 5.2 нэгжээр өссөн байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 149 буюу 22.6 хувь нь согтуугаар, 23 буюу 3.5 хувь нь хүүхэд оролцож, 117 буюу 17.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 29 буюу 4.4 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэрэгт Яллагдагчдын 164 буюу 49.8 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 240 буюу 72.9 хувь нь 18-39 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Хохирсон иргэдийн 436 буюу 64.6 хувь нь 17 хүртэлх насны хүүхэд байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон 10 хүний 7 нь хүүхэд байна гэсэн үг юм. Хохирсон хүүхдийг насаар нь авч үзвэл 29 буюу 4.3 хувь нь 7 хүртэлх, 173 буюу 25.6 хувь нь 8-13 насны, 234 буюу 34.7 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Бага насны хүүхэд хүчингийн гэмт хэрэг эзлэх хувь хэт өндөр байгаад анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай болсныг харуулж байна.

Судалгааны дүнгээс харахад 62.9 хувь буюу 414 тохиолдолд хохирогч нь өөрийн амьдардаг гэртээ байх хугацаандаа энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг гэр бүлийн, ойр дотно, найз нөхдийн, хамаатан садны, танилын хүрээнд үйлдэгдэж байгааг харуулж байна. Энэ нь гэмт хэргийн илрүүлэлтэд ч сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр 2023 оны эцэст манай улс 3,504,741 хүн амтай байснаас 2,479,930 буюу 70.7 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 1,024,811 буюу 29.3 хувь нь орон нутагт амьдарч байна. Нийт хүн амын 70 орчим хувь нь амьдарч байгаатай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийн гаралтын 56.7 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна. Харин хүн амын 30 орчим хувь нь орон нутагт амьдарч байхад нийт гэмт хэргийн 43.3 орчим хувь нь бүртгэгдсэн байдал нь гэмт хэргийн илрүүлэлт орон нутагт сайн байна гэж дүгнэх нэг нөхцөл болох боломжтой юм. Эсрэгээрээ нийслэл дэх энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт харьцангуй бага байж болзошгүйг үгүйсгэх аргагүй байна.

НҮБ-ын Хүүхдийн сангаас бусад донор байгууллагуудтай хамтран дэлхийн 96 улсад хийсэн хүүхдийн эсрэг хүчирхийллийн хамрах хүрээг судалсан судалгааны тайланд дурдсанаар¹ “Дэлхийн 1 тэрбум буюу 2-17 насны бүх хүүхдийн талаас илүү хувь нь өнгөрсөн жилд ямар нэгэн байдлаар сэтгэл зүй, бие махбод, бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэсэн тооцоолол байна. Хэдийгээр их гардаг ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь ихэвчлэн нуугдмал, хүний нүднээс далд, мэдэгдэхгүй болж өнгөрдөг. Нуугдмал байдаг гэдэг нь олон тоо баримтаас ил харагддаг бөгөөд тухайлбал, хүүхдийн өөрөө мэдээлсэн бэлгийн хүчирхийлэл нь албан ёсны мэдэгдсэн хүчирхийллийн тооноос 30 дахин, бие махбодын хүчирхийлэл нь 75 дахин их байдаг гэсэн судалгаа байдаг ажээ. Тэр дундаа охид бэлгийн хүчирхийлэлд өртөх магадлал өндөртэй байдаг. Тухайлбал хүүхэд насандаа охидын 18 хувь нь, хөвгүүдийн 8 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртдөг гэсэн судалгаа байна. Охидын эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт этгээд нь зонхилон эрэгтэй хүмүүс байдаг. Охид нь өөрийн дотны хамтрагчийн хүчирхийлэлд өртөх (бэлгийн болон бие махбодын), таньдаг хүн эсвэл танихгүй хүнд хүчиндүүлэх,

¹ 22 https://www.unicef.org/mongolia/media/3051/file/INSPIRE-SevenStrategies_MN.pdf



эрт, хүчээр гэрлэх, хүүхдийн хөдөлмөр, бэлгийн мөлжлөгийн зорилготой хүний наймаанд өртөх, эм бэлэг эрхтэнг зэрэмдэглэх, зүсэх зан үйлд өртөх нь илүү байдаг. Эдгээр хүчирхийлэл нь охидын аюулгүй өсөн хөгжих ёстой орчин болох гэр орон, сургуулиас ирэх буцах зам, сургууль дээр, өөрийнх нь амьдарч буй орон нутагт зэрэг олон орчинд гарахаас гадна гамшгийн үед, дүрвэн суурьшилт болон мөргөлдөөний дараах нөхцөл байдлуудад тохиолддог байна. Хөвгүүдийн хувьд галт зэвсэг болон хутгатай холбоотой санаатай аллагын хэргийн хохирогч эсвэл гэмт этгээд болох магадлалтай байдаг” гэжээ.²

Энэ төрлийн гэмт хэргийн тоон мэдээллийн тухайд сүүлийн жилүүдэд харьцангуй их өсөж байгаа. Ялангуяа гэр хороололд амьдралын түвшин доогуур, эсхүл гэр бүлийн орчин архидалт ихтэй, хүүхдүүд нь хараа хяналтгүй, эсхүл эх нь ажил хийж хүүхдүүд нь төрсөн эцэг, эсхүл хойд эцэг, өвөө, ах, эсхүл садан төрлийн хамаарал бүхий эрэгтэй хүнтэй үлдэж байгаа хүүхдүүдийн орчинд илүү их үйлдэгдэж байна. Энэ төрлийн гэмт хэрэг Улаанбаатар хотын тухайд бүх дүүрэгт үйлдэгдэж байгаа боловч тоон мэдээллийн хувьд Сонгинохайрхан дүүрэгт илүү их зонхилж байна гэж үзэж байгаа. Энэ дүүрэгт амьдралын түвшин доогуур, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд ихтэй, өөрсдийн байр суурийг олоогүй, эрхэлсэн ажилгүй, орлого багатай гэр бүл их байдагтай холбоотой байна гэж үзэж байгаа.³

---0000000---

² Австрали-Монголын 50 жилийн ойд зориулсан тэтгэлгийн хүрээнд “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ”-ийн судалгааны тайлан.

³ Австрали-Монголын 50 жилийн ойд зориулсан тэтгэлгийн хүрээнд “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ”-ийн судалгааны тайлан.



4.4. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 7626 бүртгэгдсэн нь өмнөх оноос 2225 буюу 41.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 6041 бүртгэгдсэн нь 2423 буюу 67.0 хувиар тус тус өсөж, орон нутгийн хэмжээнд 1585 бүртгэгдсэн нь 198 буюу 11.1 хувиар буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	5401	7626	41.2	15.2	17.1
Нийслэлд	3618	6041	67.0	14.5	18.8
Орон нутагт	1783	1585	-11.1	16.9	12.6

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2005-2024 он/.





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1188 буюу 15.6 хувь нь даваа гарагт, 1150 буюу 15.1 хувь нь мягмар гарагт, 1128 буюу 14.8 хувь нь лхагва гарагт, 1077 буюу 14.1 хувь нь пүрэв гарагт, 1093 буюу 14.3 хувь нь баасан гарагт, 976 буюу 12.8 хувь нь бямба гарагт, 1014 буюу 13.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2609 буюу 34.2 хувь нь 06:00-14:00 цагт, 2193 буюу 28.8 хувь нь 14:00-19:00 цагт, 813 буюу 10.7 хувь нь 19:00-22:00 цагт, 2011 буюу 26.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	5	6	5	3	4	3	10	36
01:00	46	38	41	41	29	48	49	292
02:00	50	48	54	49	46	56	54	357
03:00	20	35	27	27	29	31	30	199
04:00	42	49	34	29	39	34	43	270
05:00	33	39	41	40	40	31	46	270
06:00	15	11	9	10	12	11	8	76
07:00	22	36	38	37	24	18	33	208
08:00	55	53	55	48	55	49	38	353
09:00	19	13	18	20	10	15	18	113
10:00	81	75	80	78	70	71	75	530
11:00	96	66	73	69	64	51	51	470
12:00	34	30	20	32	28	30	28	202
13:00	114	99	105	91	97	65	86	657
14:00	126	74	96	90	95	76	82	639
15:00	47	54	45	43	55	37	44	325
16:00	92	99	89	75	77	79	71	582
17:00	72	69	75	74	66	66	59	481
18:00	26	36	24	16	20	28	16	166
19:00	56	45	56	48	59	44	37	345
20:00	53	66	56	55	57	43	45	375
21:00	12	16	12	14	19	15	5	93
22:00	29	41	24	36	38	32	30	230
23:00	43	52	51	52	60	43	56	357
Нийт	1188	1150	1128	1077	1093	976	1014	7626

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 2158 буюу 28.3 хувь нь гэр, орон сууцанд, 2292 буюу 30.1 хувь нь гудамж талбайд, 1305 буюу 17.1 хувь нь олон нийтийн газарт, 760 буюу 10.0 хувь нь аж ахуйн нэгжид, 159 буюу 2.1 хувь нь нийтийн тээвэрт, 45 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 22 буюу 0.3 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.1 хувь нь авто замд, 883 буюу 11.5 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 448 буюу 5.9 хувь нь согтуугаар, 363 буюу 4.8 хувь нь хүүхэд оролцож, 454 буюу 6.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 342 буюу 4.5 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 7499 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 2340 хэрэг буюу 45.4 хувиар өсөж, үүнээс 2299 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 8 буюу 0.3 хувиар буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 30.7 хувь байгаа нь өмнөх оноос 14.1 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 23.9 хувь байгаа нь 17.5 нэгжээр тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 57.3 хувь байгаа нь 5.4 нэгжээр өссөн байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2818 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 403 буюу 12.5 хувиар буурсан. Яллагдагчдын 333 буюу 11.8 хувь нь эмэгтэй, 2485 буюу 88.2 хувь нь эрэгтэй, 523 буюу 18.6 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 395 буюу 13.7 хувиар, эмэгтэй хүн 8 буюу 2.3 хувиар, хүүхэд 18 буюу 3.3 хувиар тус тус буурсан байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 7660 иргэн, 10 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оноос хохирсон хүн 2185 буюу 39.9 хувиар өсөж, хуулийн этгээд 12 буюу 54.5 хувиар буурсан байна.

3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 24706.7 сая төгрөгийн хохирлын 9596.2 сая төгрөг буюу 38.8 хувийг нөхөн төлүүлж, 197.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 12641.6 сая төгрөг буюу 33.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 14650.7 сая төгрөг буюу 60.4 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 8.9 сая төгрөг буюу 4.3 хувиар тус тус буурсан байна.

Дөрөв. Дүгнэлт.

Хулгайлах гэмт хэрэг 2024 онд улсын хэмжээнд 7626 бүртгэгдсэний 79.2 хувь нь нийслэлд, 20.8 хувь нь орон нутагт үйлдэгдэж, өмнөх онтой харьцуулахад улсын хэмжээнд 41.2, нийслэлд 67.0 хувиар тус тус өссөн бол орон нутагт 11.1 хувиар буурчээ.

Энэ төрлийн гэмт хэргийн 73.9 хувь нь ажлын өдрүүдэд, 63 хувь нь 06:00-19:00 цагийн хооронд, 58.4 хувь нь гэр, орон сууц, гудамж талбайд үйлдэгдсэн байх тул тухайн цаг хугацаа, байршлуудад хяналт тавих эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, иргэд олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх нь шаардлагатай байна.

Улаанбаатар хотын хүн амын тоо 1990 онд 536594, суурьшлын бүс 7219 га байсан бол 2023 онд хүн ам 2050044, суурьшлын бүс 46546 га болсон, өөрөөр хэлбэл 33 жилийн дараа гэхэд нийслэлийн хүн амын тоо 3.8 дахин өсөж, суурьшлын бүс хэмжээ 6.4 дахин нэмэгджээ. Цаашид суурьшлын бүс, хүн амын тоо өсөн нэмэгдэхийн зэрэгцээ, энэ төрлийн гэмт хэргийн тоо дагаж нэмэгдэх төлөв ажиглагдаж байна.

Мөн гэмт хэргийн илрүүлэлт 30.7, хохирол нөхөн төлүүлэлт 38.8 хувьтай байх тул цаашид хиймэл оюун ухаанд суурилсан удирдлагын хяналтын нэгдсэн төв байгуулах нь хүний оролцоогүйгээр камерын бичлэгийг шүүх, 24 цагийн хяналтын систем, замын хөдөлгөөн зохицуулалт, зөрчил илрүүлэх, хүн хүчний зохицуулалт хийх, үр нөлөөтэй удирдлага зохион байгуулалтыг шуурхай хийх, олон нийтийг хамарсан аливаа үйл ажиллагааг хянах, бүлэг бөөгнөрлийг хугацаа алдалгүй мэдээлэх, илрүүлэх, эргүүл, постод зарлах мэдээллийг шуурхай хүргэх зэрэг хүний хүчийг хөнгөвчилсөн олон талын давуу талууд нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд ихээхэн хувь нэмрээ оруулах юм.



4.5. ХУВИЙН ӨМЧИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 4807 бүртгэгдсэн нь өмнөх оноос 90 буюу 1.9 хувиар, нийслэлийн хэмжээнд 3946 бүртгэгдсэн нь 789 буюу 25.0 хувиар тус тус өсөж, орон нутгийн хэмжээнд 861 бүртгэгдсэн нь 699 буюу 44.8 хувиар буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	4717	4807	1.9	13.3	10.8
Нийслэлд	3157	3946	25.0	12.6	12.3
Орон нутагт	1560	861	-44.8	14.8	6.9

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 728 буюу 15.1 хувь нь даваа гарагт, 729 буюу 15.2 хувь нь мягмар гарагт, 706 буюу 14.7 хувь нь лхагва гарагт, 676 буюу 14.1 хувь нь пүрэв гарагт, 656 буюу 13.6 хувь нь баасан гарагт, 626 буюу 13.0 хувь нь бямба гарагт, 686 буюу 14.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1694 буюу 35.2 хувь нь 06:00-14:00 цагт, 1331 буюу 27.7 хувь нь 14:00-19:00 цагт, 450 буюу 9.4 хувь нь 19:00-22:00 цагт, 1332 буюу 27.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	2	2		3	2	1	6	16
01:00	30	26	26	23	15	38	29	187
02:00	39	34	37	34	25	38	36	243
03:00	11	22	18	16	19	17	20	123
04:00	33	40	25	23	27	26	30	204
05:00	23	30	33	29	27	20	32	194
06:00	12	9	7	8	7	8	6	57
07:00	12	21	23	28	14	11	26	135
08:00	37	36	42	35	44	35	28	257
09:00	13	8	9	12	5	10	10	67
10:00	49	46	50	52	48	50	55	350
11:00	65	50	54	48	45	36	36	334
12:00	26	18	10	19	19	20	20	132
13:00	55	60	54	51	54	36	52	362
14:00	72	41	58	57	61	43	47	379
15:00	30	32	32	23	32	27	30	206
16:00	50	59	59	38	43	49	54	352
17:00	43	45	44	52	38	44	43	309
18:00	17	18	10	9	7	13	11	85
19:00	24	25	30	23	30	24	21	177
20:00	28	39	33	34	31	26	35	226
21:00	5	11	6	7	8	7	3	47
22:00	21	27	14	21	24	20	18	145
23:00	31	30	32	31	31	27	38	220
Нийт	728	729	706	676	656	626	686	4807

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1266 буюу 26.3 хувь нь гэр, орон сууцанд, 1285 буюу 26.7 хувь нь гудамж талбайд, 992 буюу 20.6 хувь нь олон нийтийн газарт, 560 буюу 11.6 хувь нь аж ахуйн нэгжид, 35 буюу 0.7 хувь нь нийтийн тээвэрт, 30 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 18 буюу 0.4 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.1 хувь нь авто замд, 619 буюу 12.9 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Нийт бүртгэгдсэн хэргийн 283 буюу 5.9 хувь нь согтуугаар, 241 буюу 5.0 хувь нь хүүхэд оролцож, 351 буюу 7.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 176 буюу 3.7 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 4738 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 219 хэрэг буюу 4.8 хувиар өсөж, үүнээс 1483 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 511 буюу 25.6 хувиар буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 31.3 хувь байгаа нь өмнөх оноос 12.8 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 25.5 хувь байгаа нь 15.3 нэгжээр тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 59.0 хувь байгаа нь 7.6 нэгжээр өссөн байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 1767 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 989 буюу 35.9 хувиар буурсан. Яллагдагчдын 269 буюу 15.2 хувь нь эмэгтэй, 1498 буюу 84.8 хувь нь эрэгтэй, 332 буюу 18.8 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 974 буюу 39.4 хувиар, эмэгтэй хүн 15 буюу 5.3 хувиар, хүүхэд 143 буюу 30.1 хувиар тус тус буурсан байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4844 иргэн, 4 хуулийн этгээд, 2075 эмэгтэй хүн, 397 хүүхэд хохирсон нь өмнөх оноос хохирсон хүн 35 буюу 0.7 хувиар, хүүхэд 180 буюу 82.9 хувиар тус тус өсөж, хуулийн этгээд 3 буюу 42.9 хувиар, эмэгтэй хүн 32 буюу 1.5 хувиар тус тус буурсан байна.



3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 15683.5 сая төгрөгийн хохирлын 6880.7 сая төгрөг буюу 43.9 хувийг нөхөн төлүүлж, 140.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 426.4 сая төгрөг буюу 2.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 2720.9 сая төгрөг буюу 65.4 хувиар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 40.5 сая төгрөг буюу 22.3 хувиар буурсан байна.

Дөрөв. Дүгнэлт.

Цагдаагийн байгууллагад 2024 онд “Хувийн өмчийг хулгайлах” гэмт хэрэг 4807 бүртгэгдсэний 82.1 хувь нь нийслэлд, 17.9 хувь нь орон нутагт үйлдэгдэж, энэ төрлийн гэмт хэрэг нийслэлд 25.0 хувиар өссөн нь хүн амын өсөлт, шилжилт, хөдөлгөөн, дэд бүтэц, суурьшлын бүсийн тэлэлт, эдийн засгийн тэнцвэргүй байдал, ажилгүйдэл зэрэг хүчин зүйлстэй холбон дүгнэж болохоор байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь өдөр бүр жигд үйлдэгддэг байх тул тодорхой нэг өдрийг онцгойлон эрсдэлтэй гэж үзэх боломжгүй бөгөөд харин гэмт хэргийн 35.2 хувь нь 06:00-14:00 цаг буюу сургууль, цэцэрлэгийн хичээл, ажлын цаг эхлэх үед бүртгэгддэг учир тухайн цаг хугацаа, байршлуудад хяналт тавих эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, иргэд олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Нийт гэмт хэргийн дийлэнх буюу 53 хувь нь гэр, орон сууц, гудамж талбайд үйлдэгдсэн байх тул эдгээр газруудад энэ төрлийн гэмт хэргийн эрсдэл өндөр байгааг илтгэж байна.

Мөн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 31.3 хувь байгаа нь өмнөх оноос 12.8 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 25.5 хувь байгаа нь 15.3 нэгжээр тус тус буурсан тул эрүүгийн мөрдөгч, мөрдөгч нарийн энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах мэдлэг, ур чадварыг сайжруулахад анхаарах нь зүйтэй юм.

---0000000---



4.6. ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 1357 бүртгэгдсэн нь өмнөх оноос 1041 буюу 4.3 дахин, нийслэлийн хэмжээнд 1330 бүртгэгдсэн нь 1028 буюу 4.4 дахин, орон нутгийн хэмжээнд 27 бүртгэгдсэн нь 13 буюу 92.9 хувиар тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	316	1357	4.3 дах	0.9	3.0
Нийслэлд	302	1330	4.4 дах	1.2	4.1
Орон нутагт	14	27	92.9	0.1	0.2

1.2. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).



1.3. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 237 буюу 17.5 хувь нь даваа гарагт, 198 буюу 14.6 хувь нь мягмар гарагт, 219 буюу 16.1 хувь нь лхагва гарагт, 190 буюу 14.0 хувь нь пүрэв гарагт, 230 буюу 16.9 хувь нь баасан гарагт, 156 буюу 11.5 хувь нь бямба гарагт, 127 буюу 9.4 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 473 буюу 34.9 хувь нь 06:00-14:00 цагт, 568 буюу 41.9 хувь нь 14:00-19:00 цагт, 207 буюу 15.3 хувь нь 19:00-22:00 цагт, 109 буюу 8.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00			1					1
01:00			1		2	2	3	8
02:00		1	2	2	6	2		13
03:00	1	3	1	3	1	7	1	17
04:00	2	1	3		1	2	3	12
05:00	3	2	1	3	2	2	1	14
06:00	1							1
07:00	2	10	8	1	6	1	1	29
08:00	9	9	7	5	5	7	3	45
09:00			2	4	1	1		8
10:00	14	13	17	6	11	8	7	76
11:00	19	9	13	13	10	7	7	78
12:00	6	7	7	6	6	6	1	39
13:00	42	27	37	30	32	11	18	197



14:00	36	19	32	22	27	22	23	181
15:00	12	15	7	16	19	5	10	84
16:00	30	25	17	26	22	16	12	148
17:00	19	14	16	12	16	11	10	98
18:00	6	15	8	4	11	9	4	57
19:00	21	9	20	19	18	18	12	117
20:00	7	12	12	7	18	6	4	66
21:00	4	3	1	3	6	6	1	24
22:00		2	2	4	3	4	4	19
23:00	3	2	4	4	7	3	2	25
Нийт	237	198	219	190	230	156	127	1357

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 16 буюу 1.2 хувь нь гэр, орон сууцанд, 830 буюу 61.2 хувь нь гудамж талбайд, 194 буюу 14.3 хувь нь олон нийтийн газарт, 66 буюу 4.9 хувь нь аж ахуйн нэгжид, 124 буюу 9.1 хувь нь нийтийн тээвэрт, 8 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 1 буюу 0.1 хувь нь төрийн байгууллагад, 118 буюу 8.7 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.4. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 19 буюу 1.4 хувь нь согтуугаар, 4 буюу 0.3 хувь нь хүүхэд оролцож, 72 буюу 5.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 35 буюу 2.6 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.5. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 1324 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 1030 хэрэг буюу 4.5 дахин, үүнээс 262 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 124 буюу 89.9 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 19.8 хувь байгаа нь өмнөх оноос 27.2 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 18.3 хувь байгаа нь 27.6 нэгжээр тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 92.6 хувь байгаа нь 23.4 нэгжээр өссөн байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь






Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 326 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 146 буюу 81.1 хувиар өссөн. Яллагдагчдын 43 буюу 13.2 хувь нь эмэгтэй, 283 буюу 86.8 хувь нь эрэгтэй, 4 буюу 1.2 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 147 буюу 2.1 дахин, хүүхэд 1 буюу 33.3 хувиар тус тус өсөж, эмэгтэй хүн 1 буюу 2.3 хувиар буурсан байна.


2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 1345 иргэн хохирсон нь өмнөх оноос хохирсон хүн 1033 буюу 4.3 дахин өссөн байна. Хохирогчдын 1041 буюу 77.4 хувь нь эмэгтэй, 353 буюу 26.2 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оноос эмэгтэй хүн 796 буюу 4.2 дахин, хүүхэд 263 буюу 3.9 дахин тус тус өссөн байна.



3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2561.5 сая төгрөгийн хохирлын 393.2 сая төгрөг буюу 15.4 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос учирсан хохирол 2501.4 сая төгрөг буюу 42.6 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 230.8 сая төгрөг буюу 2.4 дахин тус тус өссөн байна.



Дөрөв. Дүгнэлт.

Цагдаагийн байгууллагад 2024 онд халаасны хулгайн гэмт хэрэг 1357 бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад улсын хэмжээнд 4.3 дахин, нийслэлд 4.4 дахин, орон нутагт 92.9 хувиар тус тус өсөж, энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 19.8 хувьтай байгаа нь өмнөх оноос 27.2 нэгжээр буурчээ.

Энэ төрлийн гэмт хэргийн 50.5 хувь нь даваа, лхагва, баасан гарагт, 76.8 хувь нь 06:00-19:00 цагт, 75.5 хувь нь гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдэж, хохирогчдын 77.4 хувийг эмэгтэй хүн, 26.2 хувийг хүүхэд эзэлж байх тул тухайн цаг хугацаа, байршилд хяналт тавих эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлэг хүргэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Гэмт хэргийн Яллагдагчдын 86.8 хувийг эрэгтэй, хохирогчдын 77.4 хувийг эмэгтэй, 26.2 хувийг хүүхэд эзэлж, иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирол өмнөх оноос 4.3 дахин өсөж, хохирол нөхөн төлүүлэлт 15.3 хувьтай байна.

Үүнээс үзвэл энэ төрлийн гэмт хэргийг үйлддэг этгээдүүд зонхилон эмэгтэйчүүд, хүүхдүүдийг сонгон, биеэ хамгаалах чадваргүй, анхаарал сул, эсэргүүцэл үзүүлэх нь чадвар сул зэргийг ашиглан олон нийтийн газар, хүний хөдөлгөөн ихтэй газрууд (автобусны буудал, үзвэр, үйлчилгээ гэх мэт)-д гэмт хэргийг үйлдэж байна.

Халаасны хулгайн гэмт хэргийн халдлагын гол зүйл болж байгаа гар утсыг борлуулах, худалдах, дахин ашиглах боломж, зах зээлийг хязгаарлахад чиглэсэн бодлогын шинжтэй хууль эрх зүй, техник технологийн арга хэмжээг судалж хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн гэж дүгнэж болохоор байна.

---oooOooo---

4.7. ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 568 бүртгэгдсэн нь өмнөх оноос 176 буюу 44.9 хувиар өсөж, нийслэлийн хэмжээнд 486 бүртгэгдсэн нь 176 буюу 56.8 хувиар, орон нутгийн хэмжээнд 82 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	392	568	44.9	1.1	1.3
Нийслэлд	310	486	56.8	1.2	1.5
Орон нутагт	82	82	0.0	0.8	0.7

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 80 буюу 14.1 хувь нь даваа гарагт, 73 буюу 12.8 хувь нь мягмар гарагт, 96 буюу 16.9 хувь нь лхагва гарагт, 87 буюу 15.3 хувь нь пүрэв гарагт, 80 буюу 14.1 хувь нь баасан гарагт, 68 буюу 12.0 хувь нь бямба гарагт, 84 буюу 14.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 124 буюу 21.8 хувь нь 06:00-14:00 цагт, 120 буюу 21.1 хувь нь 14:00-19:00 цагт, 81 буюу 14.3 хувь нь 19:00-22:00 цагт, 243 буюу 42.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	2		1		1	1	1	6
01:00	4	3	4	5	5	8	5	34
02:00	7	6	5	9	6	7	6	46
03:00	4	4	5	2	3	3	3	24
04:00	3	5	7	4	5	2	5	31
05:00	5	3	3	3	7	6	5	32
06:00			1	1		2		4
07:00	3		3	1	3			10
08:00	4	2	4	6	1	4	3	24
09:00				1				1
10:00	5	2	8	5	2	2	3	27
11:00	3	4	4	1	2	3	7	24
12:00	1		3	1	1	1	3	10
13:00	3	3	4	3	1	3	7	24
14:00	9	3	4	4	2	5	4	31
15:00	2	2		3	2		2	11
16:00	4	2	5	5	7		4	27
17:00	2	5	8	7	6	2	5	35
18:00	1	3	2	1	3	2	4	16
19:00	3	4	3	3	6	7	4	30
20:00	5	6	8	6	6	4	3	38
21:00	2	3	1	2	4	1		13
22:00	2	7	8	6	3	3	4	33
23:00	6	6	5	8	4	2	6	37
Нийт	80	73	96	87	80	68	84	568

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 48 буюу 8.5 хувь нь гэр, орон сууцанд, 379 буюу 66.7 хувь нь гудамж талбайд, 48 буюу 8.5 хувь нь олон нийтийн газарт, 27 буюу 4.8 хувь нь аж ахуйн нэгжид, 66 буюу 11.5 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 71 буюу 12.5 хувь нь согтуугаар, 41 буюу 7.2 хувь нь хүүхэд оролцож, 30 буюу 5.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 124 буюу 21.8 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.




1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 556 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 192 хэрэг буюу 52.7 хувиар, үүнээс 228 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 10 буюу 4.6 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 41.0 хувь байгаа нь өмнөх оноос 18.9 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 41.0 хувь байгаа нь 18.9 нэгжээр буурч, орон нутгийн хэмжээнд 76.0 хувь байгаа нь 9.8 нэгжээр өссөн байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 358 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 1 буюу 0.3 хувиар буурсан. Яллагдагчдын 20 буюу 5.6 хувь нь эмэгтэй, 338 буюу 94.4 хувь нь эрэгтэй, 72 буюу 20.1 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 15 буюу 4.2 хувиар буурч, эмэгтэй хүн 14 буюу 3.3 дахин өсөж, хүүхэд 14 буюу 16.3 хувиар буурсан байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 573 иргэн хохирч, үүнээс 37 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 173 буюу 43.3 хувиар, гэмтсэн хүн 1 буюу 2.8 хувиар тус тус өссөн байна.

Гэмтсэн иргэдийн гэмтлийн зэргээр нь авч үзвэл 30 буюу 81.1 хувь нь хөнгөн, 4 буюу 10.8 хувь нь хүндэвтэр, 3 буюу 8.1 хувь нь хүнд зэргийн гэмтэл учирсан байна.



3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1079.9 сая төгрөгийн хохирлын 431.6 сая төгрөг буюу 40.0 хувийг нөхөн төлүүлж, 8.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 26.2 сая төгрөг буюу 2.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 46.8 сая төгрөг буюу 12.2 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 5.3 сая төгрөг буюу 2.5 дахин тус тус өссөн байна.

Дөрөв. Дүгнэлт.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 568 бүртгэгдсэн нь өмнөх оноос 176 буюу 44.9 хувиар өсөж, нийслэлийн хэмжээнд 486 бүртгэгдсэн нь 176 буюу 56.8 хувиар, орон нутгийн хэмжээнд 82 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг Даваа-ням гарагуудад ижил давтамжтай, 243 буюу 42.8 хувь нь 22:00-06:00 цагт, 379 буюу 66.7 хувийг гудамж талбайд, 124 буюу 21.8 хувь нь бүлэглэн үйлдэж, 50.0 хувийг 16-24 насны эрэгтэй хүн, 216 буюу 60.3 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд үйлдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэргийг эрхэлсэн тодорхой ажилгүй, бүрэн дундаас доогуур боловсролтой хүмүүс архидаан согтуурч, шунахай сэдэлтэй, амар хялбар аргаар мөнгө олох сонирхолтой, амьжиргааны эх үүсвэргүй этгээдүүд бүлэглэн камерын хяналтгүй, иргэдийн хөл хөдөлгөөн бага гудамж, талбай, орон сууцны орц, хонгилд биеэ хамгаалах чадваргүй иргэд, хүүхэд, эмэгтэйчүүдийг сонгон үйлдэгдэж байна.

Дээрэмдэх гэмт хэргийн 42.8 хувь нь шөнийн цагаар үйлдэгдсэн байх тул холбогдох байгууллагуудтай хамтран согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг, үйлчилдэг баар, ресторан, шөнийн цэнгээний газруудад тавих хяналтыг сайжруулж, зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, цагийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх чиглэлээр дээд шатны байгууллага, албан тушаалтанд саналаа уламжилж, шийдвэрлүүлэх шаардлагатай байна

Монгол Улсын хүн ам, нийгэм, эдийн засаг, гэмт хэрэг, зөрчлийн системийн динамик загварын тооцооллоор ядуурлын түвшинг 0.259-0.2 болгож бууруулахад энэ төрлийн гэмт хэрэг 2035 онд 1679 болох байсныг 1301 буюу 22.5 хувиар, гудамж талбайн гэрэлтүүлэг, камерын хяналтыг 3 дахин нэмэгдүүлсэн тохиолдолд 2035 онд 1679 болох байсныг 1287 буюу 23.3 хувиар тус тус бууруулах боломжтой судалгаа гарсан.

---0000000---



4.8. ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 15889 бүртгэгдсэн нь өмнөх оноос 2904 буюу 22.4 хувиар, нийслэлийн хэмжээнд 13560 бүртгэгдсэн нь 2340 буюу 20.9 хувиар, орон нутгийн хэмжээнд 2322 бүртгэгдсэн нь 567 буюу 32.3 хувиар тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	12985	15889	22.4	36.5	35.6
Нийслэлд	11220	13560	20.9	44.9	42.2
Орон нутагт	1755	2322	32.3	16.6	18.5
Бусад	10	7	-30.0	50.0	70.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 2568 буюу 16.2 хувь нь даваа гарагт, 2581 буюу 16.2 хувь нь мягмар гарагт, 2587 буюу 16.3 хувь нь лхагва гарагт, 2429 буюу 15.3 хувь нь пүрэв гарагт, 2175 буюу 13.7 хувь нь баасан гарагт, 1787 буюу 11.2 хувь нь бямба гарагт, 1762 буюу 11.1 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 7552 буюу 47.5 хувь нь 06:00-14:00 цагт, 5361 буюу 33.7 хувь нь 14:00-19:00 цагт, 1473 буюу 9.3 хувь нь 19:00-22:00 цагт, 1503 буюу 9.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	2	4	5	2	1		3	17
01:00	36	46	34	46	45	30	41	278
02:00	27	29	33	37	29	13	24	192
03:00	7	4	7	6	2	7	1	34
04:00	20	37	29	25	22	16	24	173
05:00	44	60	47	47	53	32	43	326
06:00	4	6	6	4	3	3	2	28
07:00	92	77	79	79	63	77	67	534
08:00	127	144	132	125	105	101	90	824
09:00	46	32	41	39	27	26	29	240
10:00	270	305	296	282	247	216	222	1838
11:00	241	220	246	234	207	186	143	1477
12:00	82	99	86	70	67	42	49	495
13:00	393	310	350	320	299	208	236	2116
14:00	295	301	282	297	254	206	166	1801
15:00	94	100	105	98	91	61	71	620
16:00	243	266	251	204	204	162	169	1499
17:00	189	208	216	182	156	136	129	1216
18:00	26	45	31	42	27	27	27	225
19:00	125	103	101	101	88	77	76	671
20:00	118	97	109	101	85	80	77	667
21:00	16	8	20	23	23	29	16	135
22:00	44	50	52	37	47	38	34	302
23:00	27	30	29	28	30	14	23	181
Нийт	2568	2581	2587	2429	2175	1787	1762	15889

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 6141 буюу 38.6 хувь нь гэр, орон сууцанд, 1963 буюу 12.4 хувь нь гудамж талбайд, 1143 буюу 7.2 хувь нь олон нийтийн газарт, 1391 буюу 8.8 хувь нь аж ахуйн нэгжид, 5251 буюу 33.0 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 35 буюу 0.2 хувь нь согтуугаар, 378 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 3481 буюу 21.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 826 буюу 5.2 хувь нь бүлэглэн, 11711 буюу 73.7 хувь нь цахимаар үйлдсэн байна.




1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 15565 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 3074 хэрэг буюу 24.6 хувиар, үүнээс 7637 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 48 буюу 0.6 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 49.1 хувь байгаа нь өмнөх оноос 11.7 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 49.6 хувь байгаа нь 12.5 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 46.3 хувь байгаа нь 5.3 нэгжээр тус тус буурсан байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 8720 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 328 буюу 3.9 хувиар өссөн. Яллагдагчдын 3469 буюу 39.8 хувь нь эмэгтэй, 5251 буюу 60.2 хувь нь эрэгтэй, 401 буюу 4.6 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 45 буюу 0.9 хувь, эмэгтэй хүн 283 буюу 8.9 хувиар, хүүхэд 94 буюу 30.6 хувиар тус тус өссөн байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 15881 иргэн, 28 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оноос хохирсон хүн 2787 буюу 21.3 хувиар, хуулийн этгээд 10 буюу 55.6 хувиар тус тус өссөн.

3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 487.2 тэрбум төгрөгийн хохирлын 185.0 тэрбум төгрөг буюу 38.0 хувийг нөхөн төлүүлж, 2436.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 180.9 тэрбум төгрөг буюу 59.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 57.2 тэрбум төгрөг буюу 44.8 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 2359.7 сая төгрөг буюу 31.9 дахин тус тус өссөн байна.

Дөрөв. Дүгнэлт.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 15889 бүртгэгдсэн нь өмнөх оноос 2904 буюу 22.4 хувиар, нийслэлийн хэмжээнд 13560 бүртгэгдсэн нь 2340 буюу 20.9 хувиар, орон нутгийн хэмжээнд 2322 бүртгэгдсэн нь 567 буюу 32.3 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг Даваа-Баасан гаригуудад ижил давтамжтай, 7552 буюу 47.5 хувь нь 06:00-14:00 цагт, 6141 буюу 38.6 хувь нь гэр, орон сууцанд, 11711 буюу 71.3 хувь нь цахимаар үйлдэж, 4593 буюу 52.7 хувийг 18-24 насны, 6656 буюу 76.3 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд үйлдсэн байна.

Дэлхий нийтээр цахим хэрэглээг өргөнөөр ашиглаж байгаа энэ үед олон нийтийн сүлжээний идэвхтэй хэрэглэгч болж, өдөр бүр 50 мянга гаруй гүйлгээг онлайн банкаар дамжуулан хийдэг болсон цаг үед цахим орчинд залилуулсан гэмт хэрэгт иргэд олноор хохирч байна.

Энэ төрлийн гэмт хэргийг зохион байгуулалттайгаар, удаа дараа үйлдэгчид нь хохирогчийг урьдчилан судалж, тэдэнд чиглэсэн урхи тавих аргаар үйлдэж байгаа тул залилах гэмт хэрэгт хохирогчдын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийх нь зүйтэй юм.

Хүн амын нягтрал суурьшил, эдийн засгийн хөгжлийг даган залилах гэмт хэргийн 85.3 хувь нь нийслэлд, 14.7 хувь нь орон нутагт бүртгэгдсэн. "Системийн динамик загвар"-аар нийгэм, эдийн засаг, хүн амын нягтаршил болон гэмт хэрэг, зөрчлийн статистик тоо баримтад үндэслэн гэмт хэргийн хэтийн төлөвийг тооцож үзэхэд нийслэлийн дүүргүүдэд, орон нутагт Хөвсгөл, Дархан, Орхон, Сэлэнгэ аймгуудад гэмт хэргийн гаралт 2032 он хүртэл нэмэгдэх төлөв гарсан.



Дээрх аймаг, дүүргүүдэд залилах гэмт хэргийн гаралт нэмэгдэх болсон шалтгаан нь хүн амын өсөлт, шилжилт, хөдөлгөөн, дэд бүтэц, технологийн хурдацтай хөгжил зэрэг нөхцөл байдлуудтай зайлшгүй холбоотой юм.

Залилах гэмт хэргийн илрүүлэлт бага байгаа нь сүүлийн үед цахим залилах гэмт хэрэг ихэссэн, цахим залилах гэмт хэрэг мөрдөн шалгах алба хаагчдын цахим нотлох баримтыг таньж тодорхойлох (компьютерын шинжилгээ, өгөгдлийн сангийн шинжилгээ, сүлжээний шинжилгээ, утасны төхөөрөмжийн шинжилгээ) цуглуулах, мэдээлэл олж авах, хадгалах мэдлэг, туршлага хангалтгүй нөхцөл байдалтай холбон үзэж болно. Иймээс техник, технологи хөгжсөн өнөө үед олон улсад туршигдаж, үр дүнгээ өгсөн тоног, төхөөрөмж, гар утасны аппликейшнийг нэвтрүүлэх тал дээр судалгаа, шинжилгээ хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийгэмд чиглэсэн соён гэгээрүүлэх, уламжлалт зан заншлаа дээдлэх, хөдөлмөрлөж идэвхтэй аж төрөх, эерэг зөв ёс суртахууны талаарх нэвтрүүлгүүд цөөрч худалдаа арилжаа, сугалааны азтан болох, амар хялбар байдлаар ашиг хонжоо олох сэдлийг нийгэмд түгээсэн нэвтрүүлэг, телевизийн суваг бүрээр гарч байгааг цөөлөх бодлого барих нь зүйтэй.

---oooOooo---



4.9. АЛДААТАЙ ГҮЙЛГЭЭ, АНДУУРАГДСАН ИЛГЭЭМЖ, ГЭЭГДЭЛ ЭД ХӨРӨНГӨ, АЛДУУЛ МАЛ ЗАВШИХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 1455 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 659 буюу 82.8 хувиар, орон нутгийн хэмжээнд 280 бүртгэгдсэн нь 13 буюу 4.9 хувиар, нийслэлийн хэмжээнд 1175 бүртгэгдсэн нь 646 буюу 2.2 дахин тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	796	1455	82.8	2.2	3.3
Нийслэлд	529	1175	2.2 дах	2.1	3.7
Орон нутагт	267	280	4.9	2.5	2.2

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 203 буюу 14.0 хувь нь даваа гарагт, 205 буюу 14.1 хувь нь мягмар гарагт, 229 буюу 15.7 хувь нь лхагва гарагт, 207 буюу 14.2 хувь нь пүрэв гарагт, 212 буюу 14.6 хувь нь баасан гарагт, 207 буюу 14.2 хувь нь бямба гарагт, 192 буюу 13.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 567 буюу 39.0 хувь нь 06:00-14:00 цагт, 441 буюу 30.3 хувь нь 14:00-19:00 цагт, 139 буюу 9.5 хувь нь 19:00-22:00 цагт, 308 буюу 21.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	1		1	1	1			4
01:00	5	2	4	5	4	7	2	29
02:00	8	10	9	11	5	7	7	57
03:00	7	2	4	6	4	2	3	28
04:00	8	7	3		6	10	2	36
05:00	4	9	7	7	7	8	7	49
06:00		2		2		1	3	8
07:00	6	4	6	4	9	5	8	42
08:00	11	15	11	13	8	7	13	78
09:00		1	4	2	3	4	4	18
10:00	20	12	15	9	15	24	16	111
11:00	13	16	19	18	12	12	14	104
12:00	9	5	10	10	3	7	4	48
13:00	25	23	32	18	24	15	21	158
14:00	11	15	21	17	19	18	12	113
15:00	17	6	18	9	14	14	11	89
16:00	14	17	21	21	15	19	20	127
17:00	9	16	8	14	11	12	10	80
18:00	3	7	3	7	7	1	4	32
19:00	6	8	3	8	8	8	10	51
20:00	11	12	11	8	11	10	6	69
21:00	1	3	4	4		3	4	19
22:00	6	7	8	5	8	7	7	48
23:00	8	6	7	8	18	6	4	57
Нийт	203	205	229	207	212	207	192	1455

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 188 буюу 12.9 хувь нь гэр, орон сууцанд, 563 буюу 38.7 хувь нь гудамж талбайд, 253 буюу 17.4 хувь нь олон нийтийн газарт, 43 буюу 3.0 хувь нь нийтийн тээвэрт, 8 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 16 буюу 1.1 хувь нь төрийн бус байгууллагад, 151 буюу 10.4 хувь нь аж ахуйн нэгжид, 2 буюу 0.1 хувь нь авто зам дээр, 231 буюу 15.9 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Нийт бүртгэгдсэн хэргийн 18 буюу 1.2 хувь нь согтуугаар, 27 буюу 1.9 хувь нь хүүхэд оролцож, 152 буюу 10.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 14 буюу 1.0 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 1431 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 677 хэрэг буюу 89.8 хувиар, үүнээс 326 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 36 буюу 12.4 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 22.8 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулахад 15.7 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 13.5 хувь байгаа нь 12.1 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 64.1 хувь байгаа нь 3.7 нэгжээр тус тус буурсан байна.

Сүүлийн 20 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь





Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 366 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 18 буюу 5.2 хувиар өссөн. Яллагдагчдын 116 буюу 31.7 хувь нь эмэгтэй, 250 буюу 68.3 хувь нь эрэгтэй, 31 буюу 8.5 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх онтой харьцуулахад эрэгтэй хүн 12 буюу 5.0 хувь, эмэгтэй хүн 6 буюу 5.5 хувиар, хүүхэд 7 буюу 29.2 хувиар тус тус өссөн байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 1454 иргэн, 4 хуулийн этгээд хохирсон нь өмнөх онтой харьцуулахад хохирсон хүн 660 буюу 83.1 хувиар, хуулийн этгээд 1 буюу 33.3 хувиар тус тус өссөн.



3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 4093.4 сая төгрөгийн хохирлын 1516.2 сая төгрөг буюу 37.0 хувийг нөхөн төлүүлж, 4.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой харьцуулахад учирсан хохирол 1633.2 сая төгрөг буюу 66.4 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 1018.0 сая төгрөг буюу 3.0 дахин тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 19.2 сая төгрөг буюу 80.3 хувиар буурсан байна.

Дөрөв. Дүгнэлт.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг 1455 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 3.7 хувийг эзэлж байх бөгөөд өмнөх оноос 82.8 хувь, нийслэлийн хэмжээнд 2.2 дахин, орон нутгийн хэмжээнд 4.9 хувиар өссөн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг өсөхөд ажилгүйдэл, ядуурал нөлөөлсөн гэхээс илүүтэйгээр амар хялбар аргаар мөнгөтэй болох гэсэн хүсэл, эрмэлзэл нөлөөлж байна.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үзвэл энэ төрийн гэмт хэрэг өнгөрсөн оноос нийслэлд Багануур дүүрэгт 9 дахин, Баянзүрх дүүрэгт 2,7 дахин, Сүхбаатар дүүрэгт 2,4 дахин, Хан-Уул дүүрэгт 2,3 дахин, Чингэлтэй дүүрэгт 97.6, Сонгинохайрхан дүүрэгт 95.3, Баянгол дүүрэгт 70.7 хувиар тус тус өсөж, Налайх дүүрэгт 35.7 хувиар буурсан, орон нутагт Говь-Алтай аймагт 2.6 дахин, Хөвсгөл аймагт 3 дахин, Хэнтий аймагт 3.2 дахин, Архангай, Баянхонгор, Орхон, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ аймгуудад 11.8-85.7 хувиар тус тус өссөн, Дорнод, Төв аймгуудад мөн үеийн түвшинд, Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд, Булган, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар аймгуудад 4.2-82.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс үзэхэд гэмт хэргийн гаралтад хүн амын тоо, оршин суугчдын нягтрал шууд нөлөөлж байна.

Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэргийн 76.2 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар, бусад газарт, 69.3 хувь нь 06.00-19.00 цагийн хооронд бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн 59.3 хувь нь 18-39 насны залуус, 37.2 хувь нь ажилгүй, 22.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, өөрөөр хэлбэл 59.3 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс байгаа нь хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшин, ажлын байрны хүртээмж нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд хэрхэн нөлөөлж болохыг харуулж байна.



Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй энэ цагт “Олсон хүний олз, хаясан хүний гарз” гэх хүний эд зүйлсийг олчхоод өгдөггүй сэтгэлгээ иргэдэд байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн статистик тоон үзүүлэлтээр харагдаж байна. Тиймээс хүний эд зүйлсийг олсон бол хувьдаа завшихгүй, буцаан өгөх нийгмийн төлөвшлийг суулгах соёлын давлагааг бий болгох нь зүйтэй байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь нийгмийн хор багатай гэмт үйлдэл боловч мал, аж ахуй зонхилсон манай оронд алдуул мал завших нь түгээмэл тохиолддог байна. Ингэхдээ аймаг, сум, багийн бүс нутгийн зааг дээр ихэвчлэн үйлдэгддэг байна.

---oooOooo---



4.10. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 508 бүртгэгдсэн нь өмнөх оноос 135 буюу 21.0 хувиар, нийслэлийн хэмжээнд 23 бүртгэгдсэн нь 15 буюу 39.5 хувиар, орон нутгийн хэмжээнд 485 бүртгэгдсэн нь 120 буюу 19.8 хувиар тус тус буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	643	508	-21.0	1.8	1.1
Нийслэлд	38	23	-39.5	0.2	0.1
Орон нутагт	605	485	-19.8	5.7	3.9

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 80 буюу 15.7 хувь нь даваа гарагт, 87 буюу 17.1 хувь нь мягмар гарагт, 91 буюу 17.9 хувь нь лхагва гарагт, 75 буюу 14.8 хувь нь пүрэв гарагт, 70 буюу 13.8 хувь нь баасан гарагт, 44 буюу 8.7 хувь нь бямба гарагт, 61 буюу 12.0 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 113 буюу 22.2 хувь нь 06:00-14:00 цагт, 112 буюу 22.0 хувь нь 14:00-19:00 цагт, 73 буюу 14.4 хувь нь 19:00-22:00 цагт, 210 буюу 41.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	1							1
01:00	4	4	4	4	4	3	7	30
02:00	5	9	8	5	6	3	5	41
03:00	2	2	2		2	1	2	11
04:00	3	2	5	4	1	1		16
05:00		1			3			4
06:00	1			1	1	1		4
07:00	1	1	1		1	1		5
08:00	2	2		1	2	1	1	9
09:00	2	2	2	1		1	1	9
10:00	9	5	6	4	3	4	4	35
11:00	1		5	1	4		3	14
12:00	1		1	4	4	1	1	12
13:00	4	7	7	2	3		2	25
14:00	4	7	4	3	3		1	22
15:00	3	4	5	3	4	3	3	25
16:00	7	2	7	5	7	3	5	36
17:00	2	5	3	3	2	2	5	22
18:00	1	1	1	1		2	1	7
19:00	6	2	4	6	3	3	4	28
20:00	6	3	5	5	6	6	3	34
21:00	1	3	2	2	2		1	11
22:00	6	8	12	9	2	3	6	46
23:00	8	17	7	11	7	5	6	61
Нийт	80	87	91	75	70	44	61	508

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 3 буюу 0.6 хувь нь гэр, орон сууцанд, 12 буюу 2.4 хувь нь гудамж талбайд, 493 буюу 97.0 хувь нь бусад газарт буюу бэлчээрт үйлдэгдсэн байна.

1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 12 буюу 2.4 хувь нь согтуугаар, 3 буюу 0.6 хувь нь хүүхэд оролцож, 13 буюу 2.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 91 буюу 17.9 хувь нь бүлэглэн, 267 буюу 52.6 хувь тээврийн хэрэгсэл ашиглаж тус тус үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 491 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 132 хэрэг буюу 21.2 хувиар, үүнээс 267 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 84 буюу 23.9 хувиар тус тус буурсан.



Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 54.4 хувь байгаа нь өмнөх оноос 2.0 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 57.1 хувь байгаа нь 0.2 нэгжээр тус тус буурч, нийслэлийн хэмжээнд 23 хэрэг бүртгэлтийн хэрэг бүртгэгдсэнээс илрүүлээгүй байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 390 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 142 буюу 26.7 хувиар буурсан. Яллагдагчдын 13 буюу 3.3 хувь нь эмэгтэй, 377 буюу 96.7 хувь нь эрэгтэй, 4 буюу 1.0 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 146 буюу 27.9 хувиар, хүүхэд 5 буюу 55.5 хувиар тус тус буурч, эмэгтэй хүн 4 буюу 44.4 хувиар өссөн байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 516 иргэн хохирсон нь өмнөх оноос хохирсон хүн 148 буюу 22.3 хувиар буурсан байна.

3.2. Учирсан хохирол.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 2540.0 сая төгрөгийн хохирлын 961.2 сая төгрөг буюу 37.8 хувийг нөхөн төлүүлж, 101.4 сая төгрөгийн хөрөнгө





битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 757.8 сая төгрөг буюу 23.0 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 239.1 сая төгрөг буюу 19.9 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 82.8 сая төгрөг буюу 45.0 хувиар тус тус буурсан байна.

Дөрөв. Дүгнэлт.

Цагдаагийн байгууллагад сүүлийн 5 жил (2020-2024)-д бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн статистик мэдээллээс үзэхэд жилд дунджаар 14.4 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн онд бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн 50.7 хувь нь даваа, мягмар, лхагва гарагт, 41.3 хувь нь шөнийн буюу 22:00-06:00 цагт, 52.6 хувь нь тээврийн хэрэгсэл ашиглан, хатуу хучилттай замын ойролцоо байршлуудад үйлдэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 54.4 хувь байгаа нь өмнөх оноос 2.0 нэгжээр буурчээ.

Иймд орон нутгийн замын цагдаагийн постыг нэмэгдүүлэх, эргүүл хяналтыг сайжруулж, энэ төрлийн гэмт хэргийн газарт үзлэг хийх, нотлох баримт цуглуулах, сэжигтнийг илрүүлэх, эрэн сурвалжлах, урьдчилан сэргийлэх ажилд нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/-ийг ашиглах нь олон төрлийн давуу тал юм.

Өнгөрсөн онд “Мал хулгайлах” гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 2540.0 сая төгрөгийн хохирлын 961.2 сая төгрөг буюу 37.8 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 19.9 хувиар буурсан байх тул энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг сайжруулах чиглэлээр иргэд болон нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай байна.

---oooOooo---



4.11. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРЭГ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.


1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 252 бүртгэгдсэн нь өмнөх оноос 14 буюу 5.9 хувиар, орон нутгийн хэмжээнд 47 бүртгэгдсэн нь 13 буюу 38.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 205 бүртгэгдсэн нь 38.2 хувиар тус тус өссөн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	238	252	5.9	0.7	0.6
Нийслэлд	204	205	0.5	0.8	0.6
Орон нутагт	34	47	38.2	0.3	0.4

1.3. Гэмт хэргийн түвшин (2009-2024 он).



1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 39 буюу 15.5 хувь нь даваа гарагт, 51 буюу 20.2 хувь нь мягмар гарагт, 47 буюу 18.7 хувь нь лхагва гарагт, 46 буюу 18.3 хувь нь пүрэв гарагт, 33 буюу 13.1 хувь нь баасан гарагт, 20 буюу 7.9 хувь нь бямба гарагт, 16 буюу 6.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 55 буюу 21.8 хувь нь 06:00-14:00 цагт, 80 буюу 31.8 хувь нь 14:00-19:00 цагт, 52 буюу 20.6 хувь нь 19:00-22:00 цагт, 65 буюу 25.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 89 буюу 35.3 хувь нь гэр, орон сууцанд, 77 буюу 30.6 хувь нь гудамж талбайд, 35 буюу 13.9 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 11 буюу 4.4 хувь нь аж ахуйн нэгжид, 39 буюу 15.4 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 14 буюу 5.6 хувь нь согтуугаар, 9 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 36 буюу 14.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 33 буюу 13.1 хувь нь бүлэглэн, 2 буюу 0.8 цахим орчинд үйлдсэн, 233 буюу 92.5 хувь нь мансуурсан үедээ тус тус үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 229 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 16 хэрэг буюу 7.5 хувиар, үүнээс 144 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 8 буюу 5.9 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 62.9 хувь байгаа нь өмнөх оноос 0.9 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 58.7 хувь байгаа нь 4.6 нэгжээр тус тус буурсан бол орон нутгийн хэмжээнд 80.0 хувь байгаа нь 13.0 нэгжээр өссөн байна.



Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 221 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 1 буюу 0.5 хувиар өссөн.

Яллагдагчдын 27 буюу 12.2 хувь нь эмэгтэй, 194 буюу 87.8 хувь нь эрэгтэй, 11 буюу 5.0 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 2 буюу 1.1 хувиар өсөж, эмэгтэй хүн 1 буюу 3.6 хувиар буурч, хүүхэд 5 буюу 83.3 хувиар өссөн байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.





Гурав. Дүгнэлт.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 252 бүртгэгдсэн нь өмнөх оноос 14 буюу 5.9 хувиар, орон нутгийн хэмжээнд 47 бүртгэгдсэн нь 13 буюу 38.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 205 бүртгэгдсэн нь 38.2 хувиар тус тус өссөн байна.

Хэрэг бүртгэлтийн 229 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 16 хэрэг буюу 7.5 хувиар, үүнээс 144 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 8 буюу 5.9 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 62.9 хувь байгаа нь өмнөх оноос 1.0 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 58.7 хувь байгаа нь 4.6 нэгжээр тус тус буурсан бол орон нутгийн хэмжээнд 80.0 хувь байгаа нь 13.0 нэгжээр өссөн байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 14 буюу 5.6 хувь нь согтуугаар, 9 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 36 буюу 14.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 33 буюу 13.1 хувь нь бүлэглэн, 2 буюу 0.8 цахим орчинд үйлдсэн, 233 буюу 92.5 хувь нь мансуурсан үедээ тус тус үйлдсэн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 216 буюу 85.7 хувь нь Даваа-Баасан гарагт, 145 буюу 57.5 хувь нь 14:00-19:00, 22:00-06:00 цагуудад, 198 буюу 78.5% нь гэр, орон сууц, гудамж талбай, бусад газарт үйлдэгдсэн байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 14 буюу 5.6 хувь нь согтуугаар, 9 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 36 буюу 14.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 33 буюу 13.1 хувь нь бүлэглэн, 2 буюу 0.8 цахим орчинд үйлдсэн, 233 буюу 92.5 хувь нь мансуурсан үедээ тус тус үйлдсэн байна.

Нийт 221 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 1 буюу 0.4 хувиар өссөн. Гэмт хэрэгт Яллагдагчдын 106 буюу 48.0 хувь нь тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй иргэд, 85 буюу 38.4 хувь нь 18-24 насны буюу сурч, хөдөлмөрлөх насны залуучууд байна.

Сүүлийн жилүүдэд хар тамхи, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хэрэглэгчдийн тоо ихсэж, хууль бус эрэлт, нийлүүлэлт нэмэгдэж, бодисын төрөл зүйл олширч, судсаар тарьж амь насаа алдах явдал гарч, нөхцөл байдал хүндэрч байна.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг гэмт хэргийн хар зах зээл цахим орчинд захиалах, худалдан авах үйлдлийн аргыг ашиглан синтетик төрлийн мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэх, цахим тоглоом, криптовалют ашиглан төлбөр тооцоо хийх, хууль бусаар олсон орлогын эх үүсвэрийг нуун далдлахдаа ашиглах эрсдэл байна.

Манай улсад зэрлэгээр ургадаг олсны (каннабис) ургамлыг түүж бэлтгэн ахуйн хэрэглээний газ, будаг шингээгч, спирт ашиглан гар аргаар “гашиш” боловсруулан бусдад худалдаж байгаа ба цаашлаад химийн угтвар бодис, тоног төхөөрөмж ашиглан синтетик төрлийн мансууруулах бодис үйлдвэрлэх эрсдэл үүсэх чиг хандлагатай байна.

Монгол улсын нутаг дэвсгэрийг метамфетамин, героин, синтетик опиоид зэрэг наркотик тээвэрлэхэд ашиглах оролдлого нэмэгдэж болзошгүй.

Олон улсын байгууллагын зөвлөмж, бусад улсын туршлагыг судлахад мансууруулах, эм сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй хүнийг баривчлах, шийтгэхээс илүү тэдний аль болох эрт илрүүлэх, хэрэглээнээс татгалзуулах, эмчлэх, нийгэмшүүлэх, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх болон мэдээллийн төөрөгдлийг арилгасан соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх ажил илүү үр дүнтэй бөгөөд тухайн эм, бодисыг анх удаа хэрэглэсэн, эсвэл нэгэнт хэрэглээтэй болсон хүнийг донтогч болохоос өмнө эрт илрүүлж, бүртгэл хяналтад авч, сайн дурын болон албадан эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг олгох нь ач холбогдолтой гэж үздэг байна.

---oooOooo---

4.12. ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 489 бүртгэгдсэн нь өмнөх оноос 17 буюу 3.6 хувиар, орон нутгийн хэмжээнд 417 бүртгэгдсэн нь 22 буюу 5.6 хувиар тус тус өсөж, нийслэлийн хэмжээнд 72 бүртгэгдсэн нь 5 буюу 6.5 хувиар буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	472	489	3.6	1.3	1.1
Нийслэлд	77	72	-6.5	0.3	0.2
Орон нутагт	395	417	5.6	3.7	3.3

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 63 буюу 12.9 хувь нь даваа гарагт, 87 буюу 17.8 хувь нь мягмар гарагт, 74 буюу 15.1 хувь нь лхагва гарагт, 84 буюу 17.2 хувь нь пүрэв гарагт, 61 буюу 12.5 хувь нь баасан гарагт, 59 буюу 12.1 хувь нь бямба гарагт, 61 буюу 12.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 172 буюу 35.2 хувь нь 06:00-14:00 цагт, 193 буюу 39.5 хувь нь 14:00-19:00 цагт, 53 буюу 10.8 хувь нь 19:00-22:00 цагт, 71 буюу 14.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00			1			1		2
01:00	2	2			1	1	1	7
02:00			2	1		2		5
03:00	1			1	2	1		5
04:00	3			1			1	5
05:00	1	2		2	1	1	1	8
06:00		8	1	1			1	11
07:00	2	1	2	2		1		8
08:00	1	3		2		2	2	10
09:00	3	1	4	2	2	2	3	17
10:00	5	8	1	3	4	3	4	28
11:00	2	3	2	4	3	5	1	20
12:00		4	1	8	4	4	6	27
13:00	8	10	12	8	3	4	6	51
14:00	9	9	12	8	8	6	3	55
15:00	4	3	2	5	2	4	6	26
16:00	7	13	11	6	8	4	7	56
17:00	5	8	4	13	7	2	4	43
18:00	1	2	1	2	2	2	3	13
19:00	5	5	3	2	5	6	5	31
20:00		2	3	2	2	2	5	16
21:00			5			1		6
22:00	3	2	5	4	5	1	1	21
23:00	1	1	2	7	2	4	1	18
Нийт	63	87	74	84	61	59	61	489

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн гэмт хэргийн 182 буюу 37.2 хувь нь ойн сав бүхий газар, 29 буюу 5.9 хувь нь хууль бусаар алт олборлож байгаа газар, 120 буюу 24.5 хувь нь хөдөө хээр, 28 буюу 5.7 хувь нь гол, усны ай сав газар, 9 буюу 1.8 хувь нь аж ахуйн нэгжид, 5 буюу 1.0 хувь нь ашиглаж байгаа уурхайд, 10 буюу 2.0 хувь нь ашигт малтмалын орд газарт, 9 буюу 1.8 хувь нь бэлчээрт, 97 буюу 19.8 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Нийт бүртгэгдсэн хэргийн 2 буюу 0.4 хувь нь согтуугаар, 1 буюу 0.2 хувь нь хүүхэд оролцож, 26 буюу 5.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 92 буюу 18.8 хувь нь бүлэглэн, 4 буюу 0.8 хувь нь галт зэвсгээр, 3 буюу 0.6 хувь нь гадаадын иргэн оролцож, 3 буюу 0.6 хувь нь цахим орчинд тус тус үйлдсэн байна.үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 399 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 93 хэрэг буюу 30.4 хувиар, үүнээс 291 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 74 буюу 34.1 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 72.9 хувь байгаа нь өмнөх оноос 20.0 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 74.3 хувь байгаа нь 2.7 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 72.6 хувь байгаа нь 1.9 нэгжээр тус тус өссөн байна.

Сүүлийн 20 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 543 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 14 буюу 2.5 хувиар буурсан. Яллагдагчдын 23 буюу 4.2 хувь нь эмэгтэй, 520 буюу 95.8 хувь нь эрэгтэй, 1 буюу 0.2 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 5 буюу 0.9 хувиар, эмэгтэй хүн 9 буюу 28.1 хувиар тус тус буурч, хүүхэд 1 бүртгэгдсэн нь өмнөх оны түвшинд байна.

2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 398 иргэн, 6 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оноос хохирсон хүн 16 буюу 4.2 хувиар өсөж, хуулийн этгээд 8 буюу 57.1 хувиар буурсан байна.



3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 9457.8 сая төгрөгийн хохирлын 7446.4 сая төгрөг буюу 78.7 хувийг нөхөн төлүүлж, 800.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 2971.6 сая төгрөг буюу 45.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 2840.7 сая төгрөг буюу 61.7 хувиар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 226.6 сая төгрөг буюу 22.1 хувиар буурсан байна.

Дөрөв. Дүгнэлт.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 489 бүртгэгдсэн нь өмнөх оноос 17 буюу 3.6 хувиар, орон нутгийн хэмжээнд 417 бүртгэгдсэн нь 22 буюу 5.6 хувиар тус тус өсөж, нийслэлийн хэмжээнд 72 бүртгэгдсэн нь 5 буюу 6.5 хувиар буурсан, хэргийн илрүүлэлт 72.9 хувь байгаа нь өмнөх оноос 20.0 нэгжээр өссөн. Сүүлийн 20 жилийн (жилийн дундаж) статистикаар 332, сард 28 гэмт хэрэг үйлдэгджээ.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг нь байгаль орчинд хор хөнөөл учруулах, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, эсвэл байгаль орчныг устгах, бохирдуулах зэрэг үйлдлүүдийг хэлдэг. Энэ төрлийн гэмт хэрэг нь эдийн засгийн хямрал, хөрөнгө оруулалтын дутагдал, хууль эрх зүйн зохицуулалт, мэдлэг боловсролын дутагдал, техникийн болон технологийн хүчин зүйлс, байгаль орчныг бодитой үнэлэх, хяналт тавих дутагдал, сөрөг нөлөөний үнэлгээний дутагдал зэргээс хүчин зүйлээс шалтгаалдаг. Хүрээлэн байгаа орчны судалгааны талаар Нэгдсэн Үндэсний байгууллага, Дэлхийн Байгаль орчны сан (WWF), Дэлхийн эрүүл мэндийн байгууллагууд (WHO) олон улсын хэмжээнд судалгаа, шинжилгээ хийдэг бөгөөд эдгээр бүх судалгаанууд нь байгаль орчны асуудлыг шийдвэрлэх, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж, дэлхий нийтийн түвшинд байгаль орчны хамгааллын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн чухал алхмуудыг хэрэгжүүлдэг байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 245 буюу 50.1 хувь нь Мягмар, Лхагва, Пүрэв гарагт, 365 буюу 74.7 хувь нь 06:00-19:00 цагуудад үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, хяналт тавих эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, иргэд олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

---oooOooo---



4.13. ТЭЭВРИЙН ХЭРЭГСИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН, АШИГЛАЛТЫН ЖУРАМ ЗӨРЧИХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 3158 бүртгэгдсэн нь өмнөх оноос 1879 буюу 2.5 дахин, нийслэлийн хэмжээнд 1239 бүртгэгдсэн нь 656 буюу 2.1 дахин, орон нутгийн хэмжээнд 1921 бүртгэгдсэн нь 1223 буюу 2.8 дахин тус тус өсөж, бусад газар /хилийн чандад/-т бүртгэгдээгүй байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	1279	3158	2.5 дахин	3.6	7.0
Нийслэлд	581	1237	2.1 дахин	2.3	3.9
Орон нутагт	698	1921	2.8 дахин	6.6	15.3

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 468 буюу 14.8 хувь нь даваа гарагт, 485 буюу 15.4 хувь нь мягмар гарагт, 474 буюу 15.0 хувь нь лхагва гарагт, 448 буюу 14.2 хувь нь пүрэв гарагт, 439 буюу 13.9 хувь нь баасан гарагт, 434 буюу 13.7 хувь нь бямба гарагт, 410 буюу 13.0 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 671 буюу 21.2 хувь нь 06:00-14:00 цагт, 800 буюу 25.3 хувь нь 14:00-19:00 цагт, 603 буюу 19.1 хувь нь 19:00-22:00 цагт, 1084 буюу 34.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	7	10	7	8	9	11	13	65
01:00	27	32	21	28	24	36	32	200
02:00	12	28	21	17	21	17	17	133
03:00	21	13	9	14	12	24	14	107
04:00	5	11	7	6	8	12	11	60
05:00	5	10	12	8	8	4	5	52
06:00	6	6	7	4	5	5	7	40
07:00	14	9	14	6	11	6	10	70
08:00	8	8	17	12	6	3	12	66
09:00	6	10	9	13	6	12	7	63
10:00	17	17	14	10	14	12	14	98
11:00	13	14	17	15	18	6	10	93
12:00	15	13	26	12	13	11	12	102
13:00	21	19	18	23	16	22	20	139
14:00	28	22	16	21	16	17	20	140
15:00	23	25	16	13	19	22	11	129
16:00	34	27	21	28	33	19	23	185
17:00	26	34	35	32	31	26	22	206
18:00	23	29	24	15	21	12	16	140
19:00	33	30	37	26	26	28	24	204
20:00	33	28	31	41	37	35	36	241
21:00	23	18	25	26	25	23	18	158
22:00	32	38	33	30	29	33	24	219
23:00	36	34	37	40	31	38	32	248
Нийт	468	485	474	448	439	434	410	3158

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1428 буюу 45.2 хувь нь орон нутгийн, 1145 буюу 36.3 хувь нь хотын, 237 буюу 7.5 хувь нь гудамж талбайд, 3 буюу 0.1 хувь нь аж ахуйн нэгжид, 132 буюу 4.2 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 1760 буюу 55.7 хувь нь согтуугаар, 21 буюу 0.7 хувь нь хүүхэд оролцож, 402 буюу 12.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 3 буюу 0.1 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 2180 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 1120 хэрэг буюу 2.0 дахин, үүнээс 1771 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 947 буюу 2.1 дахин тус тус өссөн.



Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 81.2 хувь байгаа нь өмнөх оноос 3.5 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 79.2 хувь байгаа нь 12.9 нэгжээр тус тус өсөж, нийслэлийн хэмжээнд 83.2 хувь байгаа нь 4.9 нэгжээр буурсан байна.

Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2710 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 1695 буюу 2.7 дахин өссөн. Яллагдагчдын 352 буюу 13.0 хувь нь эмэгтэй, 2358 буюу 87.0 хувь нь эрэгтэй, 22 буюу 0.8 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 1529 буюу 2.8 дахин, эмэгтэй хүн 166 буюу 89.3 хувиар, хүүхэд 8 буюу 57.1 хувиар тус тус өссөн байна.


2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 1773 иргэн хохирч, 357 хүн нас барж, 1352 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 340 буюу 23.7 хувиар, нас барсан хүн 46 буюу 14.8 хувиар, гэмтсэн хүн 256 буюу 23.4 хувиар тус тус өссөн байна.





3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 11882.4 сая төгрөгийн хохирлын 9791.5 сая төгрөг буюу 82.4 хувийг нөхөн төлүүлж, 364.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 3112.7 сая төгрөг буюу 35.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 2297.1 сая төгрөг буюу 30.7 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 48.5 сая төгрөг буюу 15.4 хувиар тус тус өссөн байна.

Дөрөв. Дүгнэлт.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 3158 бүртгэгдсэн нь өмнөх оноос 1879 буюу 2.5 дахин, нийслэлийн хэмжээнд 1239 бүртгэгдсэн нь 656 буюу 2.1 дахин, орон нутгийн хэмжээнд 1921 бүртгэгдсэн нь 1223 буюу 2.8 дахин тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 2314 буюу 73.2 хувь нь Даваа-Баасан гарагт, 1084 буюу 34.3 хувь нь 22:00-06:00, 800 буюу 25.3 хувь нь 14:00-19:00 цагуудад, 2788 буюу 88.3 хувь нь авто замд үйлдэгдсэн байх тул тухайн өдөр, цагуудад хяналт шалгалтыг эрчимжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэргийн 1760 буюу 55.7 хувь нь согтуугаар, 402 буюу 12.7 хувь нь эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 1773 иргэн хохирч, 357 хүн нас барж, 1352 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 340 буюу 23.7 хувиар, нас барсан хүн 46 буюу 14.8 хувиар, гэмтсэн хүн 256 буюу 23.4 хувиар тус тус өссөн байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 11882.4 сая төгрөгийн хохирлын 9791.5 сая төгрөг буюу 82.4 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос учирсан хохирол 3112.7 сая төгрөг буюу 35.5 хувиар өссөн байна.

---0000000---



1.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн зүйл ангиар).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
1	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	3	3	0.0	0.01
2	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	13	26	2.0 дах	0.1
3	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	252	408	61.9	0.9
4	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	1	10	10.0 дах	0.02
5	Эрүүл мэндийн эсрэг	1			
6	Хүүхдийн эсрэг	45	34	-24.4	0.1
7	Өмчлөх эрхийн эсрэг	8132	12069	48.4	27.0
8	Эдийн засгийн гэмт хэрэг	34	43	26.5	0.1
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	380	53	-86.1	0.1
10	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	388	401	3.4	0.9
11	Авлигын эсрэг		1		
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	3	3	0.0	0.01
13	Нийтийн ашиг сонирхлын эсрэг	10	7	-30.0	0.02
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг	8	3	-62.5	0.01

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 2063 буюу 15.8 хувь нь даваа гарагт, 2147 буюу 16.4 хувь нь мягмар гарагт, 2075 буюу 15.9 хувь нь лхагва гарагт, 1930 буюу 14.8 хувь нь пүрэв гарагт, 1711 буюу 13.1 хувь нь баасан гарагт, 1592 буюу 12.2 хувь нь бямба гарагт, 1543 буюу 11.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 6218 буюу 47.6 хувь нь 06:00-14:00 цагт, 4304 буюу 33.0 хувь нь 14:00-19:00 цагт, 1321 буюу 10.1 хувь нь 19:00-22:00 цагт, 1218 буюу 9.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	1	3	5	3	1	1	3	17
01:00	30	33	33	37	35	25	31	224
02:00	20	27	24	25	22	13	11	142
03:00	3	4	5	4	4	7	5	32
04:00	15	26	21	14	16	13	24	129
05:00	37	46	36	37	49	27	36	268
06:00	6	3	5	4	1	3	1	23
07:00	81	70	73	71	47	69	65	476
08:00	113	128	120	100	94	90	82	727
09:00	40	30	31	35	27	24	30	217
10:00	210	256	227	229	193	189	188	1492
11:00	184	177	209	201	148	156	123	1198
12:00	62	90	75	51	53	40	43	414
13:00	298	257	272	243	210	192	199	1671
14:00	234	227	220	224	181	172	146	1404
15:00	71	76	81	72	64	57	63	484
16:00	186	226	189	159	176	143	146	1225
17:00	166	159	162	141	133	115	111	987
18:00	22	42	34	29	26	24	27	204
19:00	106	104	88	83	77	75	73	606
20:00	98	84	93	84	67	81	69	576
21:00	19	12	16	25	23	28	16	139
22:00	38	41	37	37	43	32	32	260
23:00	23	26	19	22	21	16	19	146
Нийт	2063	2147	2075	1930	1711	1592	1543	13061



Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 5622 буюу 43.0 хувь нь гэр, орон сууцанд, 1428 буюу 10.9 хувь нь гудамж талбайд, 761 буюу 5.8 хувь нь олон нийтийн газарт, 48 буюу 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 46 буюу 0.4 хувь нь төрийн байгууллагад, 49 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 639 буюу 4.9 хувь нь аж ахуйн нэгжид, 4468 буюу 34.2 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.4. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Нийт бүртгэгдсэн хэргийн 21 буюу 0.2 хувь нь согтуугаар, 407 буюу 3.1 хувь нь хүүхэд оролцож, 2816 буюу 21.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 732 буюу 5.6 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.5. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 390 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 6 хэрэг буюу 1.6 хувиар, үүнээс 144 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 7 буюу 5.1 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 36.9 хувь байгаа нь өмнөх оноос 1.2 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 63.4 хувь байгаа нь 47.6 нэгжээр тус тус өсөж, нийслэлийн хэмжээнд 33.8 хувь байгаа нь 4.1 нэгжээр буурсан байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь





Хоёр. Яллагдагч.

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 7955 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 1859 буюу 30.5 хувиар өссөн. Яллагдагчдын 3145 буюу 39.5 хувь нь эмэгтэй, 4810 буюу 60.5 хувь нь эрэгтэй, 427 буюу 5.4 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 1117 буюу 30.2 хувь, эмэгтэй хүн 742 буюу 30.9 хувиар, хүүхэд 135 буюу 46.2 хувиар тус тус өссөн байна.




2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 12981 иргэн, 13 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оноос хохирсон хүн 4016 буюу 44.8 хувиар, хуулийн этгээд 1 буюу 8.3 хувиар тус тус өссөн.



3.2. Учирсан хохирол.



/Сая төгрөгөөр/ 2023 он 2024 он
сая төгрөг буюу 2.4 дахин өссөн байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 78343.8 сая төгрөгийн хохирлын 29785.4 сая төгрөг буюу 38.0 хувийг нөхөн төлүүлж, 395.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 9221.5 сая төгрөг буюу 10.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 8742.5 сая төгрөг буюу 22.7 хувиар тус тус буурч, битүүмжилсэн хөрөнгө 229.7

Дөрөв. Дүгнэлт.

Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 13061 бүртгэгдсэн нь өмнөх оноос 3791 буюу 40.9 хувиар, нийслэлийн хэмжээнд 10960 бүртгэгдсэн нь 3137



буюу 40.1 хувиар, орон нутгийн хэмжээнд 2094 бүртгэгдсэн нь 650 буюу 45.0 хувиар тус тус өссөн байна.

Энэ төрлийн гэмт хэргийн 48.1 хувийг даваа- лхагва гарагт ижил давтамжтай, 6218 буюу 47.6 хувийг 06:00-14:00 цагт, 5622 буюу 43.0 хувийг гэр орон сууцанд, 2816 буюу 21.6 хувийг эмэгтэй хүн оролцож, 4577 буюу 57.5 хувийг 18-24 насны, 6183 буюу 77.7 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд үйлдсэн байна. Энэ нь ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргийн нийтлэг дүр зураг бөгөөд ажилгүйдэл энэ төрлийн гэмт хэрэгт нөлөөлж байгааг харуулж байна.

Цахим орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэрэг ихэвчлэн фейсбүүк, мэйл хаягаар нэвтэрч хүний нэр барин мөнгө залилсан үйлдлүүд байна. Цахим залилангийн үйлдэл нь хэлбэрийн хувьд цахим шуудангийн луйвар, романс луйвар, зээл олгох, банкны залилан, үнэгүй бараа өгөх, мөнгө гуйх, өвчтэй хүний нэр хаягийг ашиглан хандив цуглуулах, иргэдийн фейсбүүк хаягийн нэвтрэх нэр, нууц үгийг авах, таах зэргээр хууль бусаар нэвтэрч ойр дотно хүн, найз нөхөд рүү нь эзэмшигчийн өмнөөс чат бичиж мөнгө залилж байгаа хэрэг ихэвчлэн үйлдэгдсээр байна.

Залилах гэмт хэргийн илрүүлэлт бага байгаа нь сүүлийн үед цахим залилан ихэссэн, цахим залилах гэмт хэрэг мөрдөн шалгах алба хаагчдын цахим нотлох баримтыг таньж тодорхойлох (компьютерын шинжилгээ, өгөгдлийн сангийн шинжилгээ, сүлжээний шинжилгээ, утасны төхөөрөмжийн шинжилгээ) цуглуулах, мэдээлэл олж авах, хадгалах мэдлэг, туршлага хангалтгүй нөхцөл байдалтай холбон үзэж болно. Иймээс техник, технологи хөгжсөн өнөө үед олон улсад туршигдаж, үр дүнгээ өгсөн тоног, төхөөрөмж, гар утасны аппликейшнийг нэвтрүүлэх тал дээр судалгаа, шинжилгээ хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийгэмд чиглэсэн соён гэгээрүүлэх, уламжлалт зан заншлаа дээдлэх, хөдөлмөрлөж идэвхтэй аж төрөх, эерэг зөв ёс суртахууны талаарх нэвтрүүлгүүд цөөрч худалдаа арилжаа, сугалааны азтан болох, амар хялбар байдлаар ашиг хонжоо олох сэдлийг нийгэмд түгээсэн нэвтрүүлэг телевизийн суваг бүрээр гарч байгааг цөөлөх бодлого барих нь зүйтэй.

---0000000---



5.2. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСЭЭС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 1373 бүртгэгдсэн нь өмнөх оноос 103 буюу 8.1 хувиар, нийслэлийн хэмжээнд 971 бүртгэгдсэн нь 180 буюу 22.8 хувиар тус тус өсөж, орон нутгийн хэмжээнд 402 бүртгэгдсэн нь 77 буюу 16.1 хувиар буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	1270	1373	8.1	3.6	3.1
Нийслэлд	791	971	22.8	3.2	3.0
Орон нутагт	479	402	-16.1	4.5	3.2

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин (2005-2024 он).





1.4. Эрүүгийн хуульд заасан бүлгээр:

Гэмт хэргийн төрөл		Хэргийн тоо		Өсөлт, бууралт /хувиар/	Нийт насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн хэрэгт эзлэх хувь
		2023 он	2024 он		
Хүнийг алах			3		0.2
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг		383	366	-4.4	26.7
Хүчиндэх		38	23	-39.5	1.7
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг		798	885	10.9	64.5
Үүнээс	Хулгайлах	381	363	-4.7	26.4
	Залилах	295	378	28.1	27.5
	Дээрэмдэх	52	41	-21.2	3.0
Мансууруулах эм, сэтгэгдэд нөлөөт бодсыг хууль бусаар ашиглах		5	9	80.0	0.7
ХАБТХАЖЭ		14	21	50.0	1.5
Бусад		32	66	2.1 дах	4.8

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 211 буюу 15.4 хувь нь даваа гарагт, 215 буюу 15.7 хувь нь мягмар гарагт, 204 буюу 14.9 хувь нь лхагва гарагт, 214 буюу 15.6 хувь нь пүрэв гарагт, 163 буюу 11.8 хувь нь баасан гарагт, 184 буюу 13.4 хувь нь бямба гарагт, 182 буюу 13.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 469 буюу 34.2 хувь нь 06:00-14:00 цагт, 344 буюу 25.1 хувь нь 14:00-19:00 цагт, 179 буюу 13.0 хувь нь 19:00-22:00 цагт, 381 буюу 27.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00		3			2		1	6
01:00	12	13	8	14	4	16	12	79
02:00	5	10	15	4	11	5	11	61
03:00	7	2	5	6	5	2	4	31
04:00	5	10	4		6	7	8	40
05:00	7	6	3	6	3	3	4	32
06:00	5	3		3	1	2	2	16
07:00	3	3	3	6	2	4	5	26
08:00	7	8	5	6	4	6	4	40
09:00	4		1	6	3	5	5	24
10:00	19	25	22	25	16	29	20	156
11:00	11	10	11	8	11	8	6	65
12:00	8	12	3	5	1	7	3	39
13:00	19	11	25	18	8	10	12	103
14:00	18	14	18	13	11	6	9	89
15:00	6	13	7	3	2	6	6	43
16:00	16	13	20	7	16	13	14	99
17:00	10	9	15	17	11	10	8	80
18:00	6	7	4	4	6	3	3	33
19:00	7	15	5	9	12	8	10	66
20:00	14	6	12	23	2	10	9	76
21:00	4	3	3	5	4	8	10	37
22:00	8	12	5	13	6	6	9	59
23:00	10	7	10	13	16	10	7	73
Нийт	211	215	204	214	163	184	182	1373



Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 351 буюу 25.6 хувь нь гэр, орон сууцанд, 428 уюу 31.2 хувь нь гудамж талбайд, 108 буюу 7.8 хувь нь олон нийтийн газарт, 7 буюу 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 14 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 20 буюу 1.5 хувь нь төрийн бус байгууллагад, 108 буюу 7.8 хувь нь аж ахуйн нэгжид, 20 буюу 1.5 хувь нь авто зам дээр, 317 буюу 23.1 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.6. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Нийт бүртгэгдсэн хэргийн 50 буюу 3.6 хувь нь согтуугаар, 10 буюу 0.7 хувь нь мансуурсан үедээ үйлдсэн, 3 буюу 0.2 хувь нь галт зэвсгээр үйлдэгдсэн, 91 буюу 6.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 12 буюу 0.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 234 буюу 17.0 хувь нь бүлэглэн, 407 буюу 29.6 хувь нь цахимаар үйлдсэн байна.

1.7. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 1224 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 161 хэрэг буюу 15.1 хувиар, үүнээс 1223 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 161 буюу 15.2 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт 99.9 хувь байгаа нь өмнөх оны түвшинд байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь





Хоёр. Гэмт хэргийн холбогдогч

2.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 1675 хүүхэд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 81 буюу 5.1 хувиар өссөн. Яллагдагчдын 98 буюу 5.9 хувь нь эмэгтэй, 1577 буюу 94.1 хувь нь эрэгтэй хүүхэд эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмэгтэй хүүхэд 193 буюу 66.3 хувиар буурч, эрэгтэй хүүхэд 274 буюу 21.0 хувиар өссөн байна.




2.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 2936 хүүхэд хохирч, үүнээс 111 хүүхэд нас барж, 997 хүүхэд гэмтсэн нь өмнөх онтой харьцуулахад хохирсон хүүхэд 721 буюу 32.6 хувиар, нас барсан хүүхэд 12 буюу 12.1 хувиар, гэмтсэн хүүхэд 111 буюу 12.5 хувиар тус тус өссөн байна.



3.2. Учирсан хохирол.



Гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хүнд 6924.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх онтой харьцуулахад 2235.0 сая төгрөг буюу 47.7 хувиар өссөн байна.

Дөрөв. Дүгнэлт

Насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 1373 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 3.1 хувийг эзэлж байх бөгөөд өмнөх оноос 8.1 хувь, нийслэлийн хэмжээнд 22.8 хувиар тус тус өсөж, орон нутгийн хэмжээнд 16.1 хувиар буурсан байна.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үзвэл нийслэлд Хан-уул дүүрэгт 5.1 дахин, Багануур дүүрэгт 2.8 дахин, Багахангай дүүрэгт 3 дахин, Сүхбаатар дүүрэгт 49.1, Чингэлтэй дүүрэгт 16.1 хувиар тус тус өсөж, бусад дүүрэгт 3.3-26.4 хувиар буурсан, харин орон нутагт Сүхбаатар аймагт 6.3 дахин, Говь-Алтай аймагт 16.7, Увс аймагт 18.8, Дархан-Уул аймагт 5.1, Өмнөговь аймагт 6.7, Хэнтий аймагт 7.7 хувиар тус тус өсөж, бусад аймагт 5.4-53.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс үзэхэд нийслэлийн гэмт хэргийн гаралтад хүн амын тоо, оршин суугчдын нягтрал шууд нөлөөлж байна.



Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг байгуулж, нэгдсэн бодлого, төлөвлөлтөөр удирдан зохион байгуулсан, мөн цар тахлын хорио цээрийн үр дүнд 2020, 2021 онуудад насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн гаралт буурсан боловч 2022, 2023, 2024 онуудад тогтмол өссөн байна.

Насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн 57.0 хувийг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (үүнээс 26.4 хувийг Хулгайлах, 27.5 хувийг Залилах, 3.0 хувийг Дээрэмдэх), 26.7 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, үлдсэн хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Гэр бүлийн санхүүгийн асуудал, эцэг эхийн хараа хяналт, найз нөхдийн нөлөө, гэмт хэрэг, гэмт хэрэгтэн болох талаарх мэдээлэлгүй байдал, эрсдэлтэй үйлдлүүдийн талаар мэдлэггүй байх нь насанд хүрээгүй хүнээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдож байгаатай шууд холбоотой.

Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний 70.7 хувь нь нийслэлийн нутаг дэвсгэрт, 64.7 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар, гэр, орон сууцанд, 34.2 хувь нь 06.00-14.00 цагийн хооронд, 65.9 хувь нь 16-17 насны хүн гэмт хэрэгт холбогджээ.

---oooOooo---



1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 980 буюу 15.8 хувь нь даваа гарагт, 989 буюу 16.0 хувь нь мягмар гарагт, 992 буюу 16.0 хувь нь лхагва гарагт, 916 буюу 14.8 хувь нь пүрэв гарагт, 823 буюу 13.3 хувь нь баасан гарагт, 781 буюу 12.6 хувь нь бямба гарагт, 710 буюу 11.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2449 буюу 39.6 хувь нь 06:00-14:00 цагт, 1999 буюу 32.3 хувь нь 14:00-19:00 цагт, 734 буюу 11.9 хувь нь 19:00-22:00 цагт, 1009 буюу 16.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	4	4	4	2	2	2	2	20
01:00	27	17	16	26	18	24	29	157
02:00	13	18	22	22	21	19	13	128
03:00	9	6	11	6	10	21	8	71
04:00	11	22	13	8	20	11	17	102
05:00	19	13	14	15	16	18	24	119
06:00	4	2	4	3	3	5	6	27
07:00	19	17	19	18	21	23	15	132
08:00	43	45	56	29	29	39	30	271
09:00	22	15	25	21	12	12	16	123
10:00	93	96	74	70	72	65	53	523
11:00	74	62	86	91	69	65	53	500
12:00	46	56	33	24	25	26	19	229
13:00	106	104	104	104	93	66	67	644
14:00	92	82	89	97	80	65	58	563
15:00	43	42	46	36	31	35	27	260
16:00	74	109	85	79	69	57	80	553
17:00	67	92	91	71	59	67	48	495
18:00	19	21	15	29	15	16	13	128
19:00	53	46	44	45	38	29	37	292
20:00	58	43	72	53	49	41	38	354
21:00	11	11	8	11	16	20	11	88
22:00	40	41	36	41	26	31	25	240
23:00	33	25	25	15	29	24	21	172
Нийт	980	989	992	916	823	781	710	6191

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 2101 буюу 33.9 хувь нь гэр, орон сууцанд, 816 буюу 13.2 хувь нь гудамж талбайд, 788 буюу 12.7 хувь нь олон нийтийн газарт, 41 буюу 0.7 хувь нь нийтийн тээвэрт, 67 буюу 1.1 хувь нь төрийн байгууллагад, 36 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 666 буюу 10.8 хувь нь аж ахуйн нэгжид, 369 буюу 6.0 хувь нь авто замд, 1307 буюу 21.0 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 596 буюу 9.6 хувь нь согтуугаар, 91 буюу 1.5 хувь нь хүүхэд оролцож, 867 буюу 14.0 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

